



“СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨСӨВ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАСАН ТУРШЛАГА, СУРГАМЖ”

ДӨРВӨН СУМЫН КЕЙСИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2014 он



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар,
Шинжлэх ухааны Академийн харьяа
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨСӨВ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАСАН ТУРШЛАГА, СУРГАМЖ

Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Мерси Кор Олон Улсын байгууллагын хэрэгжүүлсэн “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх Идэвхтэй түншлэл ба Иргэдийн оролцоо” (APPEAL) төслийн хүрээнд хийгдсэн кейс судалгааны тайлан ба олон улсын туршлагад тулгуурлан одоо ба ирээдүйн төрийн албан хаагчид, судалгаа шинжилгээний байгууллага болон ИНБ-ын ажилтнуудад зориулан Үндэсний Хөгжлийн Хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид боловсруулан хэвлэв.

Зохиогчид:

Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор

Б.Энхбайгаль (Судалгааны багийн ахлагч)

Доктор Б.Сувданцэцэг

Д.Түвшинбат

Ж.Алтайбаатар

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Энэ нь Мерси Кор, USAID, Үндэсний хөгжлийн Хүрээлэн, зохиогчдын бүтээл бөгөөд зөвшөөрөлгүйгээр хэвлэх, нийтлэх, аль ч хэлбэрээр хуулбарлах олшруулахыг хориглоно.

2014 он

Энэхүү хэвлэлд тусгасан мэдээлэл нь Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Америкийн Нэгдсэн Улсын засгийн газарт хамаарахгүй.

Цаасны хэмжээ А5

Хэвлэлийн хуудас: 5,6 х.х

Хэвлэсэн тоо: 3000

“СЭЛЭНГЭПРЕСС” ХХК-д хэвлэв

ӨМНӨТГӨЛ

Засаг захиргааны нэгжээр авч үзвэл улс орны хөгжил нь хот, аймаг, нийслэлийн хөгжлөөс, хот, аймаг, нийслэлийн хөгжил нь хороо, дүүрэг, сумаас эхтэй билээ. Хөгжил хэмээгч нь цаасан дээр буусан статистикийн үзүүлэлт, улс орны тал нь төвлөрсөн нийслэл хотын эмх цэгцээс гадна хамгийн гол нь Монгол Улсын нийт ард иргэдийн амьжиргаа сайжрах, тэд маань амьдралдаа сэтгэл өег байх явдал юм.

Монгол Улс сүүлийн хорин таван жилд чамгүй туршлага хуримтлуулж, тухай тухайн нөхцөлд хөгжлийн төлөөх шийдлээ хэрэгжүүлсээр өнөөг хүрсэн. Төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх чиглэлээр ч бас томоохон алхмууд хийгээд байна. Аливаа ажилд бэрхшээл, зовлон олон тохиодгийн адилаар орон нутгаа хөгжүүлэх оролдлогод ч бас өөрийн гэсэн туршлага, сургамж, анхаарах асуудлууд, бас үүний хажуугаар түгээн дэлгэрүүлж, хөгжүүлэх санаа санаачилгууд бий.

Хийсэн ажлын үр дүнг хөндлөнгөөс хараад шууд үнэлж дүгнэх хялбар бөгөөд өгөөж муутай байдаг. Болж байгаа үйл явцыг шинжлэн чухам ямар учраас, юунаас шалтгаалан ийм үр дүнд хүрч, үүнд юу нөлөөлж байгааг судлах нь өмнөх туршлагаа цаашид сайжруулан хөгжүүлэх, сургамж авч эндэгдлээс зайлсхийх үндсэн нөхцөл юм. Орон нутгийг судлахдаа кейсийн судалгааны аргыг сонгосны гол шалтгаан нь энэ билээ.

Бид энэ судалгаагаар орон нутгаас жишээ болгон байгаль цаг уур, дэд бүтэц, орчин нөхцөл, удирдлагын арга барилын хувьд ялгаатай дөрвөн өөр сумыг сонгон авч судаллаа. Дөрвөн өөр туршлага, дөрвөн өөр арга барил, дөрвөн өөр сэтгэлгээ, дөрвөн өөр сургамжийн тухай энд өгүүлнэ. Эдгээр туршлага сургамжууд нь хэдэн жилийн дараа эргээд харвал инээд хүрэм энгийн санагдаж болох ч, өнөөгийн нөхцөлд бол орон нутагт нийтлэг тулгарч буй асуудлууд юм.

Орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдэд зориулан бичиж байгаа учраас судалгааны баг эдгээр үйл явцын өрнөсөн дараалал, орчин нөхцөл, хүрсэн үр дүн, учир шалтгаан, шинэлэг санаа санаачилгыг аль болох ойлгомжтойгоор хүргэхийг хичээлээ. Уншигч эрхэм эдгээр кейсийг уншихдаа өөрийн нөхцөл байдал, шийдвэртэй харьцуулж,

- ✓ “Бидний шийдэж чадаагүй ямар асуудлыг тэд яаж шийдэж вэ?”
- ✓ “Бид энэ хүмүүсийн оронд байсан бол яаж шийдэх байсан бол?”
- ✓ “Энэ хүмүүс юуг биднийхээс өөрөөр хийжвэ?”
- ✓ “Бид эндээс ямар шинэ санаа, шийдэл олж авах вэ?”
- ✓ “Ямар учраас, яаж ажилласан болохоор биднийхээс ялгаатай үр дүнд хүрсэн бол...?”

хэмээн эргэцүүлнэ буй заа. Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгох, нийтлэг практик болгох, цаашид улам хөгжүүлэх нь энэ номын гол зорилго билээ.

Судалгааны ажлыг санхүүжүүлсэн Мерси Кор Олон Улсын Байгууллага, Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, судалгааны ажлын явцад хамтран ажиллаж, үнэтэй санал зөвлөгөө өгсөн Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх Идэвхтэй түншлэл ба Иргэдийн оролцоо” (APPEAL) төслийн багийнханд-д орон нутгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаад нь гүнээ талархаж байна.

Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн
захирал, доктор, дэд профессор
Б.Энхбайгаль

ТОВЬЁГ

“СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨСӨВ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХ ТУХАЙ.....	7
ХАМТЫН ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР.....	15
Хөгжлийг хамтран төлөвлөх арга замын эрэлд.....	16
Иргэдийн оролцоо нь мэдээллийг хүргэх арга хэлбэрээс хамаардаг	25
ХӨГЖЛИЙН ГАРЦАА ЗӨВ ТОДОРХОЙЛЖ ТӨСВИЙГ ЗОХИСТОЙ ХУВААРИЛАХ НЬ.....	37
Бодлого төлөвлөлттэйгээр сумыг хөгжүүлэх нь.....	38
Орон нутгийг хөгжүүлэхэд төсвийг үр дүнтэй хуваарилах нь.....	41
Иргэдийн идэвхи, оролцоог нэмэгдүүлэх нь.....	49
ХӨДӨӨГИЙН МАЛЧИД, СУМЫН ТӨВИЙН ИРГЭДИЙН ХҮСЭЛ СОНИРХОЛЫГ УУЛЗУУЛАХЫГ ЗОРЬСОН НЬ.....	53
Иргэдэд хийх ажил, төлөвлөсөн ирээдүйн тухай мэдээллийг хүргэх нь амаргүй ажил.....	59
Сумын хөгжлийн төлөвлөгөө, иргэдийн хүсэлт, хэрэгцээг уялдуулах нь.....	63
Төлөвлөж, баталсан ажлын гүйцэтгэлийг сайжруулах оролдлого бүхэн туршлага болох нь.....	67
АЙМГИЙН ЦАРААТАЙ СУМ БУЮУ БЭРХШЭЭЛ, ШИЙДЛИЙН УУЛЗВАР ДЭЭР.....	73
Хүсэл сонирхол, бодит хэрэгцээг уялдуулах нь.....	78
Хөгжлийн төлөвлөгөө өөрчлөгдөшгүй зүйл биш.....	85
Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянах, тухай бүрт нь сайжруулах аргын эрэлд.....	89

“СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨСӨВ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулинд туссан бодлогын шинэчлэл нь орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог дэмжих, удирдлагын идэвхи, санаачилга, хариуцлагыг сайжруулахад чухалач холбогдолтой шийдэл болжээ. Үүний зэрэгцээ орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд иргэдийг идэвхитэй оролцуулах, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг илүү зөв боловсруулах, улсын болон бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулах, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянах, сайжруулах зэрэг олон сорилтыг ч бас бий болгож байна.

Сум, орон нутаг хөгжихийн эх үндэс нь хөгжлөө зөв төлөвлөх, удирдлага илүү үр нөлөөтэй арга барилаар ажиллах, иргэдтэйгээ хамтрах, төсвийн хөрөнгө оруулалт, дэмжлэгийг үр өгөөжтэй зарцуулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх билээ. Орон нутагт иргэдийн амьжиргаа сайжирч, орлого нэмэгдвэл орон нутгийн эдийн засаг ч бас сэргэнэ. Орон нутаг хөгжвөл улс хөгжинө.

Сум аймаг тус бүр иргэдэд хүргэх төрийн үйлчилгээнийхээ чанарыг дээшлүүлж, иргэдэд аж төрөх таатай орчныг бүрдүүлж чадвал хот руу чиглэсэн нүүдлийн урсгал саарч, нутаг эзэнтэйгээ үлдэж, ядуурал, ажилгүйдэл ч бас багасна. Улс шиг улс байх, иргэд сэтгэл хангалуун байхын эх үндэс нь орон нутгийн хөгжил буюу.

Сайн туршлагыг судалж түгээн дэлгэрүүлэх, саар сургамжийг ч бас судалж сэрэмжлүүлэх нь цаашдын үйл ажиллагаа алдаа мадаггүй байхад туслахын зэрэгцээ бас ч гэж олон сумдад бусад нь ингэж ажиллаж байна гэсэн баримжааг өгөх, бага ч атугай асуудал шийдэх шийдлээ олоход нь тус болох билээ.

Чухам ийм шалтгаанаар Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгааны баг энэ сэдвийг сонгон авч ажиллаа. Энэ бол Мерси Кор Олон Улсын Байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар,

Шинжлэх ухааны Академийн харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн хамтын ажиллагааны хүрээнд, Мерси Кор Олон Улсын Байгууллагын захиалгаар хэрэгжсэн кейсийн судалгаа бөгөөд үр дүнг нь уншигч танаа толилуулж байна.

Судалгааны баг энэ судалгаагаар сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлын төлөвлөлт, хэрэгжилт, тэдгээрийн уялдааг сайжруулах, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тулгарч буй сорилт, туршлага, сургамжийг дөрвөн сумын жишээгээр авч үзсэн юм. Сумын хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулаад хэрэгжүүлж байгаа Дундговь аймгийн Сайнцагаан, Дэлгэрцогт сумд, төлөвлөгөө боловсруулах шатандаа яваа Хэнтий аймгийн Биндэр, Цэнхэрмандал сумдыг кейс болгон сонгож авлаа.

Энд өгүүлсэн кейс бүхэн бодит түүх бөгөөд судалгааны баг баримт бичгийн шинжилгээ, сурвалжлага, асуулга, фокус группын ярилцлага, статистик өгөгдлийн шинжилгээ, ажиглалт зэрэг судалгааны аргуудыг ашиглан ажиллав.

Эдгээр сумдад сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сумыг хөгжүүлэхэд дараах сорилтууд тулгарч байна. Үүнд:

1. Уламжлалт төлөвлөлтийн арга барилыг иргэдийн оролцоонд тулгуурласан шинэ арга барилтай яаж уялдуулах вэ?
2. Иргэдэд орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний тухай мэдээллийг яаж хүргэх вэ? Хүргэхээс гадна мэдээллийг яаж байнга шинэчилж, бусад төлөвлөлтөд иргэдийн тусламжтайгаар тусгах вэ?
3. Идэвхигүй иргэдийг яаж орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд оролцуулах вэ? Хөгжлийн тухай иргэдийн ойлголт, мэдлэгийг яаж сайжруулах вэ? Тэдний оролцоо, санаачилгыг яаж сайжруулах вэ?
4. Цаг үеэ яаж мэдэрч, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг илүү зөв боловсруулах вэ? Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй яаж уялдуулах вэ?

5. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг яаж хянах вэ?
Тухай бүрт нь яаж сайжруулах вэ?

Сумд дор бүртээ нутаг орноо хөгжүүлэх, ажлаа сайжруулахыг хичээн эрмэлзэж байгаа ч нөхцөл байдал бүхэн ихээхэн ялгаатай байна. Дэд бүтэц, хол ойр, байгаль цаг уурын нөхцөл, байгалийн баялаг, нөөц, байгалийн бүс бүслүүр, иргэдийн оролцоо, хүн амын тоо, бүтэц, нутгийн уламжлал, зан заншил, удирдлагын арга барил, удирдлагын багийн чадавхи зэрэг олон хүчин зүйл үүнд нөлөөлж байна.

Сумдын орчин нөхцөл ялгаатай учир тухай бүрт тохирсон арга барил, санал санаачилга, тухайн орчин нөхцөлд илүү тохирсон шийдэл хэрэгтэй болж байгаа нь судалгаанаас харагдаж байсан. Сум хөгжүүлэх төлөвлөгөөг нэг талаас иргэдийн оролцоо, орон нутгийн онцлог, нөөц боломжид тулгуурлахын зэрэгцээ аймаг, бүс нутаг, улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах шаардлагатай байна.

Нэгэнт боловсруулсан төлөвлөгөөг тэр чигээр нь эсвэл заавал дөрвөн жилдээбагтааж хэрэгжүүлэхийн оронд нөхцөл байдал өөрчлөгдсөн бол үүнд нийцүүлж төлөвлөгөөгөө шинэчлэх нь зүй ёсны хэрэг юм. Сумын хөгжлийн төлөвлөгөөнөөс сүүлд батлагдсан улс, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд, 2013 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн Орон нутгийн хөгжлийн сан зэрэг сумын хөгжлийн төлөвлөлтөд нөлөөтэй шинээр батлагдсан бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах, зарим төслүүдийг шинэчлэх, өөрчлөх, шинээр тусгах шаардлага ч бий.

Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нийт иргэдийг санаа бодлыг тусгах, иргэдийн төлөөллийг биечлэн оролцуулах, мэргэжлийн туслалцаа авах, тодорхой арга зүйд түшиглэх шаардлагатай болдог. Эдгээр сумд Мерси Кор Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сумын хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулах, аймаг, сумын засаг даргын мөрийн хөтөлбөрт хөгжлийн төлөвлөгөөг тусгах нь ч бас чухал ач холбогдолтой асуудал байдаг.

Төлөвлөгөөг боловсруулсаны дараа хэрэгжүүлэхдээ орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих

сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг сангуудыг үр өгөөжтэй ашиглах чиглэлээр сумын удирдлагууд, иргэд, төрийн бус байгууллагууд санал солилцон идэвхитэй ажиллаж байгаа нь сайшаалтай юм.

Сум, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр үнэлж, тухай бүрт нь засч залруулан сайжруулах, орчин нөхцөл, нөөц боломжид нийцүүлж ажиллах, хэрэгжилтийн гүйцэтгэлийг тухай бүрт нь хянаж, чанарыг сайжруулах нь бас төлөвлөлтөөс дутуугүй шийдвэрлэх үүрэгтэй.

Иргэдийн оролцоотойгоор хөгжлөө төлөвлөхөд иргэдийн хэрэгцээ, төлөвлөж буй ажлын үр ашгийг харгалзан үзэх шаардлагатай.

Сумын хөгжлийн төлөвлөгөө, орон нутагт хэрэгжиж буй ажлын тухай мэдээллийг иргэдэд хүргэх ажил олон сорилттой тулгарч байна. Сумын удирдлага янз бүрийн арга хэлбэрээр хүргэхийг зорьж байгаа ч хүч тарамдах, хөрөнгө дутагдах, зохион байгуулалт дутах бэрхшээл байнга тохиолдож байна.

2013 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн орон нутгийн хөгжлийн сан нь сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол санхүүгийн эх үүсвэр болоод байгаа ч урьд нь боловсруулсан хөгжлийн төлөвлөгөө, бодлогыг иргэдийн гаргаж буй санал, санаачилгатай уялдуулах нь амаргүй бөгөөд янз бүрийн бэрхшээлтэй тулгарч байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн иргэд нь хүүхдийн тоглоомын талбай тохижуулах, усан сан, гэрэлтүүлэг, хаяг, тохижилтын ажил зэрэг амьдрах орчиноо өөрчлөхөд чиглэсэн ажил, үйлчилгээнд саналаа өгч байгаа бол малчид гойд ашиг шимт мал үржүүлэх буюу малжуулах, худаг засварлах, бэлчээр хашихыг их төлөв дэмжиж байна.

Хүн ам олонтой учраас ихэнх хөрөнгө оруулалт сумын төвд зориулагдаж байна. Яваандаа сумын төвийн хөгжил, сумын төвөөс хол амьдардаг иргэдийн амьдралын хооронд ихээхэн зааг ялгаа бий болох, энэ нь суурин газар руу төвлөрөхийг нэмэгдүүлж болзошгүй нь ажиглагдаж байна.

Эдгээр ажлууд нь үнэхээр үр ашигтай ажил болсон гэдэгт эргэлзэх иргэд ч бас бий. Гүйцэтгэгч байгууллагууд сайн ажиллахгүй байх, гэрээ

хангалтгүй хийгдэх, олонхийн санал авсан ажлыг цөөнх нь дэмжихгүй байх, шүүмжлэх тохиолдлууд олон.

Сумын захиргаа, багийн хийх ажлын ачааллыг дахин тооцож, шаардлагатай дэмжлэгийг өгөх, сум орон нутгийн ажиллах хүчийг чадавхижуулахад анхаарах нь цаашид сум орон нутгийг хөгжүүлэх ажилд ихээхэн хувь нэмэртэй байхаар харагдаж байна.

Энд бидний авч үзсэн жишээнд сумын хөгжлийн төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг уялдуулах, иргэдийн оролцоог дэмжиж ажиллах тухайд бусдад туршлага, сургамж болох зүйлс олон бий. Хуримтлуулсан сайн туршлагын зэрэгцээ олж авсан сургамжууд ч бас их.

Төлөвлөсөн төсөл хөтөлбөр, ажлыг эзэнжүүлэх, гэрээ, төсвийг хяналттай байлгах, зөвлөл, ажлын хэсэг, хорооны гишүүдийг чадваржуулах, хугацааг зөв төлөвлөх нь ажлын үр дүнд эерэгээр нөлөөлж байна.

Саналыг нь авсан учраас иргэдэд үүссэн хүлээлт, төсвийг нь өгсөн учраас орон нутаг хөгжинө гэсэн засгийн газар, төв байгууллагуудын итгэлийг хөсөрдүүлэхгүйгээр, орон нутгийн нөхцөл байдал, зовлон бэрхшээлийг давж гарах нөхцөл боломжийг бүрэн ашиглах, иргэдийн хүчийг дайчлах, хамтдаа хөгжих нь хэлэхэд амар боловч хийхэд хэцүү ярвигтай даалгавар билээ.

Судалгааны явцад хүрсэн үр дүнгүүдээс товчоолон багцалбал:

1. Сумын хөгжлийн мастер төлөвлөгөө бол тухайн сумын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, хөгжихийн тулд хийх ажлыг үе шат, төсөв, хугацаатай нь урьдчилан төлөвлөж, аль нэг нам, улс төрийн хүчнээс үл хамааран үе үеийн сумын удирдлагууд үйл ажиллагааны үндсэн чиглэлээ болгон хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд орчин нөхцлийн өөрчлөлтөд нийцүүлэн сайжруулах баримт бичиг юм. Хөгжлийн төлөвлөгөөгүй, эсвэл үндэслэлтэй, сайтар боловсруулж чадаагүйгээс сумдын хөгжил урагшлахгүй, бусдаас хоцрох, сумын хөгжил гэдгийг сумын төвийн хөгжил гэж ташаа ойлгох явдал байсаар байна. Хөгжлийн

- төлөвлөгөө боловсруулах нь хялбар биш, олон нийтийн оролцоо, шинжилгээ судалгаа, арга барил, тодорхой арга зүй шаардсан ажил юм. Зарим тохиолдолд мэргэжлийн байгууллагуудаас туслалцаа авах, хамтран ажиллах нь дөхөмтэй байж болох юм.
2. Орон нутгийн хөгжлийн улс орны хөгжил, эдийн засагт гүйцэтгэх үүрэг, ролийг ойлгож, хөгжлөө төлөвлөж, хэрэгжүүлэх чадвартай мэргэшсэн удирдах ажилтнуудыг бэлтгэх, ийнхүү боловсруулах нь чухал байна.
 3. Хөгжлийг төлөвлөхөд урт, дунд, богино хугацаанд тулгарч болох сорилтууд, боломжуудыг зөв тодорхойлж, улс, бүс нутаг, аймгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах шаардлагатай нь харагдаж байна. Хөдөө орон нутаг, аймаг, улс орны нийгэм-эдийн засаг, байгаль орчинд үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан төлөвлөх чадавхи сумдад хязгаарлагдмал учраас энэ ажил удааширч байгаа нь ажиглагдаж байна. Мэргэжлийн байгууллагуудын, тухайлбал, зураг төсөл, төсөв, бусад чиглэлийн туслалцаа ихээхэн хэрэгтэй нь ажиглагдлаа. Тэгэхдээ өөрийн нөөц бололцоо, нутгийн иргэд, нутгийн зөвлөлийн хүчийг зөв ашиглан үр дүнд хүрч байгаа жишээ ч бас бий. Орон нутгийн удирдлагын хичээл зүтгэл, санаачилгаас үр дүн ихэд хамаарч байна.
 4. Хөгжлийн төлөвлөгөөгөө бодитойгоор боловсруулж, гарцаа зөв тодорхойлсон үед төсвийг зөв зарцуулах нөхцөл аяндаа бүрдэж, иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэж байна. Иргэдэд мэдээлэл хүргэх, байнга мэдээлэл солилцох нь энэ үйл явцад шийдвэрлэх үүргийг гүйцэтгэж байна.



Кейс уншигч нь бидний өгүүлэх дөрвөн кейсийг уншихдаа дараах асуултуудын дагуу эргэцүүлэх нь илүү үр дүнд хүргэнэ. Үүнд:

1. Тухайн үеийн нөхцөл байдал ямар байсан бэ?
2. Хамгийн гол тулгамдсан асуудлууд юу байсан бэ?
3. Энэ асуудалтай уялдаа холбоотой өөр ямар асуудлууд байсан бэ?
4. Тухайн асуудлыг шийдэх ямар боломжууд байсан бэ?
5. Эдгээр шийдлийн хувилбаруудыг харьцуулж үнэлбэл ямар давуу, сул талууд байна вэ?
6. Шийдлийн хамгийн оновчтой хувилбар юу вэ?
7. Энэ сумын хэрэгжүүлсэн хувилбар зөв байж чадсан уу?
8. Энэ хувилбарыг хэрэгжүүлэхэд үүссэн сөрөг үр дагавар, эрсдэл юу байсан бэ?
9. Энэ туршлагаас уншигч ямар шинэлэг санаа оноо, сургамж олж авсан бэ?



Доктор, дэд профессор Б.Энхбайгаль

ХАМТЫН ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР СУМ

Эдийн засаг сайнгүй байхад ч гэсэн нутгийн өөрөө удирдах ёсыг дэмжих, орон нутагт төсөв зарцуулах нь яваандаа орон нутаг хөгжиж чадавхижих, улсын эдийн засагт өөрийн гэсэн байр сууриа эзлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Хуучных шиг төвөөс бүхнийг шийдэх нь орон нутгийн тулгамдсан асуудал, бэрхшээлийг бүрэн гүйцэд шийдэхгүйгээс гадна хөгжлийн гол тулгуур, багана болсон орон нутгийн санаачилга, идэвх оролцоог сулруулж байсан юм.

Орон нутаг бие даан асуудлаа шийдэх төсөв мөнгөтэй болох, иргэдийн саналаар асуудлаа шийддэг болох нь орон нутгийн тулгамдсан асуудлыг зөв олж харах, оновчтой шийдэхийн эхлэл билээ. Үүний зэрэгцээ, орон нутагт ийм туршлага урьд нь байгаагүй нь бас сул тал болж байна.

Шууд бие даалган асуудлаа өөрсдөө шийд гээд хаяхын оронд, сайн туршлага, сургамжийг түгээн дэлгэрүүлж, хэрэгтэй үед нь мэргэжлийн түвшинд туслах, улс, бүс нутгийн хөгжлийн үйл явцтай сумын хөгжлийг уялдуулах, мэдлэг мэдээллээр дэмжих шаардлага цаашид ч бас байсаар л байх болно. Шинээр туршиж байгаа бүхэнд оноо ч, алдаа ч байдаг нь зүйн хэрэг билээ. Орон нутаг, сумын хөгжлийн үйл явц хэр хурдацтай оновчтой байх нь байгаа мэдлэг, мэдээлэл, нөөц боломж, хүн хүчээ хэр зэрэг ашигласнаас, бусад талууд, оролцогчид, байгууллагуудтай хэр зэрэг хамтарч ажилласнаас шууд хамаарч байна.

Нэгдсэн төсвөөс орон нутгийн төсвийг зориудаар дэмжсэнээр орон нутгийн эдийн засагт өсөлтийг бий болгох, ард иргэдийн амьжиргаа, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, тэгэхдээ үүнийг тодорхой зорилго, дэс дараатай гүйцэтгэнэ гэсэн хүлээлтийг бий болгож байна. Энэ хүлээлтийн үр дүн хоёроос гурван жилийн дараа л тодорхой харагдах болно. 2010 оноос өмнө иргэд дэд бүтэц, зам, гэрэлтүүлэг зэрэг амьдрах орчны нөхцлийг сайжруулахыг илүү хүсдэг байсан бол

өдгөө ажлын байр, орлоготой байхыг илүү ихээр чухалчлах болжээ. Дэд бүтэц, орчин шаардлагатай суурь боловч хөгжихөд бас хангалттай нөхцөл биш билээ.

Улс орон нэгдсэн хөгжлийн төлөвлөгөөтэй байхаас өөр аргагүй, нөгөө талаас нь авч үзвэл иргэдийн хүсэл сонирхол, оролцоонд тулгуурлан ажиллах нь хамгийн бодитойгоор асуудлыг шийдэх, иргэдийн оролцоог дэмжих үндсэн арга юм. Иргэдийн оролцоо мэдээллийн хүртээмжээс ихээхэн хамаардаг ч, газар зүйн алслалт бас л хэцүүхэн сорилтын нэг болж байна. Мэдээллийг иргэдэд хүргэх төсөв ч бас хязгаартай.

Орон нутгийн удирдлага хэрхэн улс орны төлөвлөлт, иргэдийн хүсэл, хүлээлт, орон нутгийн ирээдүйн эрх ашгийг уялдуулж, бага төсвөөр мэдээллээ хангалттай хүргэх үйл явцыг тасалдуулахгүйгээр иргэдийн оролцоог бий болгож, товлосон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянаж, сайн үр дүнд хүргэх вэ? Байгаа нөхцөл байдалдаа нийцүүлэн, хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд хаанаас ямар мэдлэг, мэдээлэл олж авах вэ?

Сумдаа дутагдаж байгаа туршлага, мэргэжлийн мэдлэг мэдээллийг олж авах, санаачлагыг бий болгох, нөөц боломжоо бүрэн дайчлах, өнөөгийн дүрэм журам, шаардлагуудад нийцүүлэн ажиллаж, орон нутаг хөгжнө гэсэн иргэдийн итгэлийг сэргээхэд удирдлагын арга барил, манлайллаас гадна сумын захиргаа, нутгийн зөвлөл, иргэдийн оролцооны аль аль нь хэрэгтэй.

ХӨГЖЛИЙГ ХАМТРАН ТӨЛӨВЛӨХ АРГА ЗАМЫН ЭРЭЛД

Улсын хөгжлийн төлөвлөгөө, төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд л сумын төсөв санхүү тодорхойлогддог. Шинэ төсвийн хуулиар нэгдсэн төсөвт ордог байсан мөнгийг орон нутагт тусгайлсан чиг үүргийн дагуу хуваарилах болсоноор орон нутагт өөрийн тулгамдсан асуудлыг бие даан шийдвэрлэх цоо шинэ боломж нээгдэж байгаа билээ. Энэ боломжийг хэр зэрэг зөв ашигласнаас орон нутгийн хөгжлийн ирээдүй хамаарна.

Шинэ тутам бүхэн амаргүй байдаг.

Иргэдийн хувьд ч орон нутгийн хөгжилд оролцож, хувь нэмрээ оруулах нь урьд өмнө нь байгаагүй туршлага юм. Орон нутгийн хувьд уламжлалт бус аргаар, иргэдийн оролцоонд тулгуурлан орон нутгаа хөгжүүлэх нь хуучнаас ялгаатайгаар, орон нутгийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлэх шинэ гарц ч байж болох юм. Төвөөс

ХӨГЖЛИЙН БАРИМЖАА ХАМГИЙН ЧУХАЛ НЬ

Зах зээлийн үед нийгмийн амьдрал хэцүү, өнөө маргаашаа яая гээд цалингаа хүлээдэг байсан үед сумын хөгжлийн бодлого гэж байгаагүй. Зорилго, зорилт байгаагүй болохоор хөгждөггүй байсан байх. Одоо цаг өөр болсон хөгжлийн ямар нэгэн зорилго зорилт тавихгүй бол биелэгдэхгүй.

Судалгаанд оролцогч “Г”.

нэгдсэн байдлаар бүхнийг шийдэх нь илүү эрсдэлтэй байдаг бол, орон нутгийн зовлон бэрхшээл, нөхцөл байдлыг сайн мэдэж байгаа сумын удирдлага, иргэд хамтран шийдэх нь илүү оновчтой ч байж болно. Гэхдээ ямар ч нөхцөлд энэ бүхэн удирдлагын арга барил, овсгоо, сэтгэл зүтгэл, чадвараас шууд хамаарна. Иргэдээ сонсож, талуудыг оролцуулан, хамтын шийдэлд хүрнэ гэдэг бас тийм хялбар ажил биш ээ.

Хэнтий аймгийн Биндэр сум 2006 оноос хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа. Эхний үе шатны хэрэгжилт 2010 онд дуусч, 2 дахь нь 2015 онд дуусахаар байгаа ч, ард иргэдийн оролцоотойгоор хөгжлөө төлөвлөх, хэрэгждэг сайн төлөвлөгөөтэй байхын ач холбогдол их учраас Мерси Кор Олон Улсын Байгууллага, Нутгийн удирдлагын холбоотой хамтран олон сар ажилласны дүнд 2014-өөс 2017, 2018-аас 2023, 2024-өөс 2030 он гэсэн гурван үе шаттай 2030 он хүртэлх сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулжээ.

Мерси Кор Олон Улсын Байгууллага болон Нутгийн удирдлагын холбоотой хамтраад гурван өдрийн сургалт хийж 30 хүний бүрэлдэхүүнтэй Төлөвлөлт, хяналтын хороо байгуулан арван сараас эхлээд сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байна. Эдгээр хүмүүсээс мэргэжлийн зөвлөгөө авч байна. Тамгын газрын дарга сумын мастер төлөвлөгөөг нэгтгэж байгаа.


Хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулахад иргэдээс санал авсан, фокус ярилцлага хийсэн, Нутгийн зөвлөлийн Улаанбаатар, Хэнтий, Багануур зэрэг хотуудад амьдарч байгаа иргэдээс санал авсан.

Орон нутгийн хөгжлийн Сангийн мөнгийг хуваарилахдаа нэг багт 30 хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг хийж, иргэдээс бичгээр санал авдаг. Ажлын хэсэг гарган тэдгээр хүмүүс саналыг үнэлж, эрэмбэлдэг. Хөдөөгийн иргэд бол өөрсдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй зүйл дээр санал өгдөг. Энэ жилээс Төлөвлөлт, хяналтын хорооныхон ухуулга сурталчилгаа хийж сайн ажилласан. Тиймээс 2015 оны санал арай өөр байдалтай гарах байх гэж найдаж байна. Учир нь арай олон нийтийн эрх ашиг, нийгэм рүү хандсан байдлаар хийгдэх байх.

Засаг дарга Алтангэрэлийн 2014 оны 5 сарын 4-ний ярианаас

Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн санаа бодлыг авах, нутгаасаа хол амьдарч байгаа боловсрол, мэдлэг туршлага бүхий иргэд, нутгийн зөвлөлийнхний мэдлэг туршлагыг ашиглах зэргээр төлөвлөж, байгаа нөөц бололцоогоо дайчилж ажилласан нь оролцоог дэмжих, хөгжлийн төлөвлөгөөг олон талаас нь авч үзэн, шүүн тунгааж сайтар боловсруулахад ихээхэн нэмэр болжээ. Энэ нь цаашид хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, дэмжлэгийг авахад дөхөмтэй болгох буй заа.

Зураг 1. Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан үе шатны зураглал



Төлөвлөгөөнд олон нийтийн оролцоог бий болгох, тэдний санал санаачлагыг тусгах, сумын хөгжлийн гарцыг хамтдаа эрэлхийлэх зорилгоор нийтдээ давхардсан тоогоор 3049 хүний санал сэтгэгдлийг сонсож, гол гол саналуудыг төлөвлөгөөнд тусгажээ.

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад иргэдийн оролцоог дэмжиж ажилласан байдал			
	Оролцооны хэлбэр	Давтамж	Оролцогчдын тоо
1	Фокус бүлгийн ярилцлага	10	225
2	БОС	3	170
3	SWOT шинжилгээ	7	293
4	Олон нийтийн хэлэлцүүлэг		
5	Санал асуулгын хуудас	8	1200
6	Сумын чадавхийн үнэлгээ		
7	Ганцаарчилсан ярилцлага	15	44
8	Мэдээллийн самбар	13	
9	ЕБС-ийн зохион бичлэг	1	435
10	ИТХ-ын төлөөлөгч сонгогчидтой уулзах	4	57
11	Багийн засаг дарга айл өрхөөр явж санал авах	2	300

Биндэр сумынхан “Алтан ургийн голомт-Өгөөж баян Биндэрьяа” хэмээн бүтээж бий болгох ирээдүйгээ тодорхойлж, мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлж үр ашгийг дээшлүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь тэргүүлэх зорилт гэж үзэж байна.

СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	
1. Мал аж ахуйг хөгжүүлэх	Сумын бэлчээрийн даац, боломжид тохируулан уламжлалт болон эрчимжсэн хэлбэрээр зохистой хослуулан хөгжүүлэх
	Нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлж, нутгийн сайжруулсан омог, хэвшлийг бий болгох
2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх	

Зүүн бүсийн аялал жуулчлалын хөгжлийн чиглэл, мастер төлөвлөгөөнд тулгуурлах
Онон голын ай савын үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалд түшиглэн аялал жуулчлалыг иж бүрэн цогцоор нь үе шаттай хөгжүүлэх
Аялал жуулчлал дагасан төрөл бүрийн угтвар үйлчилгээг сайжруулах
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Орон нутгийн нөөцийг ашиглан нэмж үнэ цэнэ бүтээхэд анхаарах
Нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг голчлон хөгжүүлэх
Мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэрэг хүнсний голлох нэрийн бүтээгдэхүүнээр сум өөрийн хэрэгцээг бүрэн хангах

Биндэр сумынхан хөгжлийн төлөвлөгөөгөө гурван үе шатанд хувааж, эхний үе шатанд иргэдээ чадавхижуулж сургах, оюуны хөрөнгө оруулахад голчлон анхаарч, эхний ээлжинд орон нутагтаа байгаа нөөц боломжид түшиглэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж байна. Мах, сүү, гурил, тэжээлийн болон бусад бага оврын үйлдвэрлэл хөгжүүлж, сүү, сүүн бүтээгдэхүүнийг нутгийн брэнд болгох нь хамгийн боломжтой буюу Биндэрчүүдийн хувьд 2014-өөс 2017 оны зорилго болж байна. Өрхийн түвшинд хэрэгжиж байгаа үйлдвэрлэлийг хамтарч хорших замаар бага дунд үйлдвэрлэлийн түвшинд хүргэх ньцаашид эдийн засгийн хувьд бэхжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлж, ажилгүйдлийг багасгах эх үндэс болно.

Үүний дараагийн үе шат буюу 2018-аас 2023 онуудад аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөжээ. Эзэн чингисийн төрсөн тоонот, агуу түүхийн гэрч нууц товчооны олон олон үйл явдал болж өнгөрсөн, эртний түүхээр баялаг нутгийн хувьд аялал жуулчлал хөгжих хамгийн боломжтой салбарын нэг билээ. Хэний ч мэдэх дэд бүтэц, хоол унд, жуулчны бааз аялал жуулчлал хөгжих хангалттай нөхцөл биш, харин туулж өнгөрүүлсэн түүхийн улбааг мэдэрч, чимээг нь чагнаархах нь л түүх соёлын чиглэлээр аялах жуулчдыг татах хүлхүүр болно. Үүний тулд түүхийн мэдлэг, түүнийгээ амьдруулж, хүргэх чадвар бас хэрэгтэй. Зон олноороо л хичээж, зүтгэж байж хийх ажил.

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: Хөгжлийн төлөвлөгөөг сурталчилан таниулах, хөгжилд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хөгжлийн суурь нөхцлийг хангах үе шат 2014-2017 он

- Хөгжлийн төлөвлөгөөг сурталчлан таниулах, олны хүртээл болгох
- Тодорхой төслүүдийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө босгох
- Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрхзүйн болон мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтэрч, бүтээн байгуулалтын суурь орчин бүрдүүлэх

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ: Хөгжлийн төлөвлөгөөний эрчимтэй хөгжлийн үе шат 2018-2023 он

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, иргэдэд хурдан шуурхай, хүртээмжтэй, мэргэжлийн, ур чадварын, сэтгэл ханамжийн өндөр түвшинд үйлчлэх тав тухтай орчин бүрдүүлэх.
- Бизнес эрхлэх эрхзүйн болон санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах замаар бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх
- Байгалийн нөөцийн судалгаа, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулж, байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийг дэмжих
- Орон нутгийн нөөц, онцлог давуу талд түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх
- Харилцан ашигтай гадаад, дотоод харилцааг хөгжүүлэх

ГУРАВДУГААР ҮЕ ШАТ: Нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хөгжлийн ололт амжилтыг бэхжүүлэх, хөгжүүлэх үе шат 2024-2030 он

- Алсын хараанд хүрэхэд тэмүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах
- Эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсон, санхүүгийн хувьд бие даах
- Үйлдвэрлэл үйлчилгээний ажиллагаа тогтмолжиж, үр ашиг дээшилсэн, гадаад дотоодод нийлүүлэх
- Сумын төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинд хүрэх

Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийн санг ажиллуулсан туршлагадаа тулгуурлаж, шинээр хэрэгжиж эхэлж байгаа орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг хөгжлийн төлөвлөлттэй уялдуулахын чухлыг тэд сайн ойлгожээ. Аль алинд нь л иргэдийн оролцоо, санаачилга, хариуцлага чухал үүрэгтэй. 2030 он хүртэлх сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэд, талуудын оролцоог чухалчлан Сумын нутгийн удирдах зөвлөл ч бас санаачилгатайгаар

хамтран ажиллаж, Өндөрхаан, Багануур, Улаанбаатар хотод байгаа нутгийн уугуул иргэд, нэр хүндтэй бизнесийнхэн, эрдэмтдийн санал бодлыг сонсож хэлэлцэн, тусгаж ажилласан нь орчин үеийн нутгийн удирдлагад мэдлэгийн менежментийг ашиглаж байгаагийн жишээ юм.

Иргэний танхимыг 2013 оны 03 дугаар сарын 19-нд өдөр нээж ажиллуулан, Иргэний танхимын журмыг таван багийн иргэдээр хэлэлцүүлэн баталж, иргэдийн саналыг авах дэвтэр, жижүүрийн дэвтэр, утас ажиллуулж эхэлсэн.

Эхлээд төрийн үйлчилгээний ажилтнуудыг ээлжээр ажиллуулж, иргэдээс нэр хаягтай санал, гомдол авахын зэрэгцээ ирсэн санал бүрийг анхаарч, санал гомдлыг хэрхэн шийдвэрлэснээ хариу мэдэгдэн санал солилцож эхэлжээ. Эхэн үед энэ нь санал, гомдол бичсэн цөөн хүмүүсийг хамарч байсан учраас сар тутамд иргэдийг хамруулсан лекц зохион байгуулж, иргэдийг хамруулах болсноор Иргэний танхимыг хүмүүс мэддэг болж, хөл хөдөлгөөн ихэссэн байна.

Иргэний танхим бол иргэдтэйгээ илүү ойрхон ажиллах, Сумын засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг иргэдэд илүү их ойртуулах, иргэдтэй мэдлэг мэдээллээ байнга солилцох нэг гол түлхүүр юм.

Хөгжлийг хамтдаа зүтгэж бүтээдэг.

Төрийн үйлчилгээний албан хаагчид ээлжээр Иргэний танхимд ажиллаж байсан ч, иргэдтэй илүү сайн харилцах шаардлагатай гэж үзэн байнгын хариуцсан ажилтантай болжээ. Иргэний танхимд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, гишүүд, багийн дарга нар тодорхой хуваариар жижүүрлэдэг. Санал авах нэг хэрэг, харин саналын дагуу ажиллаад хүрсэн үр дүнгээ эргээд мэдээлэх нь иргэдтэйгээ ойлголцох, хамтран ажиллах нэг түлхүүр билээ. Иймд Иргэний танхимын ажилтан ирсэн санал, гомдол, болсон үйл явдал хийсэн ажлын тэмдэглэлийг хөтөлж, хэнд хандах хэзээ шийдвэрлэхийг тодруулан албан хаагчидтай харьцдаг болсон. Иргэд заавал биеэр ирэхгүйгээр нэрээ хэлээд утсаар мэдээ, мэдээллээ өгөх боломжтой нь Иргэний танхимын үйлчилгээг сайжруулах төдийгүй, Засаг даргын

Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг иргэдэд улам ойртуулахад дөхөм болжээ.

Биндэр сумын хөгжлийн шинэ төлөвлөгөөг боловсруулахад зөвхөн иргэдийн, ажлын хэсэгт оролцогчдын саналыг аваад зогсоогүй, Өндөрхаан хот (тухайн үеийн нэрээр), Багануур, Улаанбаатар хотод амьдардаг нутгийн уугуул иргэдээс санал авч, Биндэр сумынхаа нутгийн зөвлөлтэй нягт хамтран ажиллаж байгаа нь хөгжлийн ирээдүйгээ илүү өргөн хүрээтэйгээр олж харах боломжийг олгож, хэрэгжих боломжтой, нөөц боломжоо бүрэн ашиглахуйц бодитой төлөвлөгөөтэй болно гэсэн итгэл найдварыг төрүүлж байна.

Судалгааны фокус ярилцлагад оролцсон иргэд, иргэний нийгмийн төлөөлөл, ганцаарчилан ярилцлага авсан сумын удирдлагын аль аль нь өрхийн үйлдвэрлэлийн түвшнээс хальж, цех тасгийн, болж өгвөл жижиг дунд үйлдвэрлэл рүү шилжих, үүний тулд техник технологид суралцах, үйлдвэрлэлээ зах зээлтэй завсрын шат дамжлагагүйгээр холбохын чухлыг цохон тэмдэглэж, өөр өөрсдийн жишээгээр тайлбарлаж байсан юм. Үүнд шаардлагатай үйлдвэрлэлийн бүс, битүү худалдааны зах, ахуй үйлчилгээний нэгдсэн төвийн хэрэгцээ нэн тэргүүнд тулгамдаж байгаа ажээ.

Иргэд хоршин ажиллаж, хамтрахын чухлыг ойлгож, “дан дангаараа ажилласнаас хамтран ажиллавал илүү үр дүнд хүрдэг, үүний тулд санхүүжилтээ тарамдахын оронд төслөө хамтран боловсруулах хэрэгтэй” хэмээн удаа дараа өгүүлж байсан нь сум дотроо, өөр хоорондоо өрсөлдөх биш, харин хамтран төв суурин газрын зах зээлд байр сууриа эзлэхийн чухлыг ойлгосны илэрхийлэл байлаа.

Гэвч орон нутгийн хөгжил, урт хугацаан дахь орон нутгийн хөгжлийн ач тус, нөлөөний тухай иргэдийн ойлголт бүрхэг байсаар байна. Сумын төвийн оршин суугчид, малчид, тариаланчид, ойн аж ахуйнхны хэрэгцээ, тулгамдсан асуудлууд ялгаатай төдийгүй, тэдэнд мэдээллийг хүргэх бололцоо харилцан адилгүй байгаагаас шалтгаалан саналууд ч ихээхэн ялгаатай байдаг. Сумын хөгжлийн төлөвлөгөө гэдэг бол нутаг орныг бүхэлд нь харж, хөгжүүлэх, нийт ард иргэдийн амьжиргааг сайжруулах төлөвлөгөө болохоос хүн ам олонтойгоор нь сумын төвөө хөгжүүлэх төлөвлөгөө бас биш ээ.

“Зүгээр ороод ирж байгаа мөнгийг буцаагаад явуулчихаж болохгүй” гэх биш, харин үүний эсрэгээр “Ирж байгаа мөнгийг зөв зарцуулж, нутаг орондоо бүтээж байгуулах, үлдэцтэй ажил хийх, ядаж л цөөн хэдэн хүнийг ажлын байртай болгож амьдралыг нь өөд татах” нь сумын удирдлага, иргэд, аж ахуй эрхлэгчид, ашгийн бус байгууллагуудын аль алиных нь чин хүслэн болох нь илт. Энэ нь бас л иргэддээ мэдээллийг хэрхэн яаж, ямар арга замаар хүргэснээс оновчтой шийдлээ олж чадах эсэх нь хамаарна.

ИРГЭДИЙН ОРОЛЦОО НЬ МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГЭХ АРГА ХЭЛБЭРЭЭС ХАМААРДАГ

Багийн нэр	Хүн ам (2010)
Онон баг	1125
Баянгол баг	674
Баян-Өндөр баг	566
Мандалхаан баг	560
Дэлгэрхаан баг	530

Иргэдэд орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний тухай мэдээллийг яаж хүргэх вэ? Мэдээллийг яаж байнга шинэчилж, бусад төлөвлөлтөд иргэдийн тусламжтайгаар тусгах вэ?

НЭГДМЭЛ ОЙЛГОЛЦОЛ ХАМГИЙН ЧУХАЛ НЬ

Яаж ийгээд санал авах нь гол биш, нутгийнхны санаанд нийцсэн, сэтгэлд хүрсэн ажлуудыг хэрэгжүүлэх, нийтийн эрх ашигт нийцүүлэн нутаг орноо хөгжүүлэх нь л хамгаас чухал билээ. Иймд иргэдэд мэдээллээ хүргэх, нутаг орны тулгамдсан асуудал, хөгжлийн ирээдүйн тухай санаа бодлоо солилцох, иргэдээ сонсох нь хамгийн эхэнд хийх, байнга тасралтгүй хийх ажил юм.

“Санал өгөх нь чухал биш саналаа хамгаалах нь чухал гээд бүх санал гаргасан ажлын хэсгийнхэн ажлаа хамгаалдаг. Хамгаалахын тулд сурталчилгаа хэрэгтэй. Тиймээс багуудын өдөрлөгөөр хийх гэж байгаа болон хийсэн ажлуудаа сурталчилдаг.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүн бол тухайн баг, албан газар, иргэний нийгмээс сонгогдсон ард түмний төлөөлөл. Энэ хүн ажлаа сайн хийж чадахгүй, саналаа хамгаалж чадахгүй шийдвэрлүүлж чадахгүй бол халагдаад чаддаг хүнд нь шилжүүлэх үүрэгтэй.”

Сумын засаг даргын ярианаас

5364 километр квадрат нутаг, 3818 оршин суугч, 1200-гаад өрх, таван багтай, үүнээс 787 малчин өрхтэй сумын хувьд иргэдэд мэдээлэл тухай бүрт нь хүргэх гэдэг бас амар ажил биш ээ.

Иргэдэд орон нутгийн хөгжлийн сангийн тухай мэдээлэл хүргэх зардал нь төсөвт суугаагүй, багийн засаг даргын шатахууны норм жилд ердөө л 90 мянган төгрөг, тэгээд ч ус ихтэй жил Онон голыг гаталж, голын зүүн биед байгаа айлууд руу очих тун хэцүү. Заримдаа ч голын хоёр талд хашигдаад сараар хүлээх нь бий. Гол дээгүүр гүүр барих тухай ярьсаар олон жил болж байгаа ч, урсгал ширүүн, үертэй үедээ савнаасаа халих нь их учир инженерийн шийдэл тун сайн, санхүүжилт хангалттай байж, мэргэжлийн байгууллагаар хийлгэхгүй бол горьгүй. Концессийн гэрээгээр гүүр барих ажил эхэлж байгаа ч, олон жил үргэлжилсэн ажил болох төлөвтэй. Сумын төв 650 өрхтэй учраас харьцангуй хүн ам төвлөрсөн гэж хэлж болох ажээ.

Иргэдэд жилдээ нэг хоёр удаа мэдээлэл хүргэх хангалтгүй, сумаараа зохион байгуулж байгаа өдөр тутмын ажлууд, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, бусад хэрэгжиж байгаа олон төсөл хөтөлбөрүүд, иргэдийнхээ ахуй амьдралд санаа тавих, гал түймэр гамшгийн аюулаас хамгаалахаас эхлээд хоорондоо холбоотой байж хэл чимээ дуулгах хэрэгцээ байнга гарна.

Хөгжлийн төлөвлөгөөнд иргэдээс саналыг бүрэн авах нь бараг л боломжгүй. Үүнд иргэдийн идэвхи оролцоо ч бас чухал үүрэгтэй. Настайчууд, нялх хүүхэдтэй хүмүүс, малаа түр харуулах хүнгүй малчид, хол байгаа хүмүүс тэр бүр хуралд ирж оролцоод байж чаддаггүй. Одоогийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажлын тухай нийт иргэдийн 60 хувийн саналыг авч чаджээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд 10 өрхийн иргэдтэй фокус ярилцлага хийгээд, ярилцлагын үеэр гарсан саналыг нэгтгэж, аль нь тулгамдсан, нэн тэргүүнд шаардлагатайг лавлан эрэмбэлжээ. Шууд л нэхээд санал нэхэж авсан нэр хэмээх нь гол биш ээ. Тухайн ажил сумын хөгжилд, иргэдэд юугаараа хэрэгтэйг сайтар таниулж, мэдээллээ хүргэх нь чухал юм. Ажлын хэсгийн гишүүд ч үүний төлөө хичээж ажилладаг. Төлөвлөлт хяналтын хорооны ажлын хэсэг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, ажлын хэсэгтэй хамтарч хэлэлцэн

журмаа баталсан нь ажлаа шууд хэрэгжүүлж эхлэхэд дөхөм болжээ.

“Иргэний танхим гээд хүмүүс очоод хуралдаад байгаа, би тийшээ очиж үзээгүй. Уг нь санал өгнө гэж бодсон юмаа, санал өгнө гэж бодож байна. Нээлттэй бэлэн байдаг юм гэнэ билээ. ...Би төвийн багийнх учир хөдөөний багийн өдөрлөг рүү очдоггүй. Төвийн багийн өдөрлөг рүү ч очдоггүй. Гэрийн ажил гэсээр байтал очиж амжихгүй байна. Тэмцэн, хурал цуглаан болвол оролцдог. Хурал цуглаан дээрээ хийж байгаа ажлуудын тухай ярилцдаг юм билээ.”

Ой хамгаалах нөхөрлөлийн гишүүний ярианаас

5 сарын 13 нд багийн хуралтай тэр үеэр санал авах байх. Ганцаараа байдаг, багийн төвөөсөө нилээд хол байдаг болохоор очиж чадахгүй байна. Уг нь хэлэлцдэг гэсэн. Саналын хуудас гэрээр ирдэггүй. Суман дээр явж байж таарвал авдаг юм.

Малчны ярианаас

Санал цуглуулах нь гол биш, харин нийтээр нэгдсэн ойлголттой болж, олон талаас нь шүүн хэлэлцэж, юу илүү хэрэгтэйг шийдэх нь л хэрэгтэй. Ийм болохоор “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэгчийн үлгэрээр багийн өдөрлөгүүдийг аль болох сонирхолтойгоор зохион байгуулж, иргэдийн оролцоог дэмжин, энэ үеэр сумын хөгжил, хөгжлийн төлөвлөгөө, хийх ажлын тухай мэдээллийг хангалттай хүргэхэд анхаарч ажилласан нь нэг талаас авах гэж байгаа саналын тухай мэдээллийг иргэдэд хүргэж ойлгуулах, нөгөө талаас иргэдийн өөр хоорондоо санаа бодлоо солилцох боломжийг бүрдүүлэхийг зорьсон ажил болжээ.

Багийн өдөрлөгийг сумын төрийн байгууллагуудын аль нэгний нь үйл ажиллагааны танилцуулгатай хамтатгасан нь иргэдийн сонирхолд ч нийцэж байна. Сургууль үйл ажиллагаагаа танилцуулж, эцэг эхчүүдтэй ажиллахад сургуулийн насны хүүхэдтэй хүмүүс дуртай байх нь мэдээж. Эмнэлгийн үзлэг ч бас л хэрэгтэй. Малын хулгайг бууруулах ажил ч бас иргэдийн анхаарлыг татсан асуудлын нэг байдаг.

Иргэдээр ч бас саналын хуудсыг дамжуулан хүргүүлдэг. Сумын сэтгүүлд сар тутмын мэдээлэл гардаг, FM радиогоор мэдээлэн, айлуудын гадна зар наадаг, багийн дарга нарт мэдээлэх ажлыг даалгахын зэрэгцээ иргэдэд мэдээлэл хэр хүрсэн тухай судалгаа авдаг нь эргээд хийсэн

ажил, хүрсэн үр дүнгээ үнэлэхэд дөхөм болж байна.

Төлөвлөсөн хугацаандаа санал авч, эрэмбэлэн төлөвлөгөө баталж байж ирэх оны хөрөнгө оруулалтын төсөв батлагддаг болохоор хугацаа нь бас хязгаартай. Малчид айл саахалтынхнаасаа, зурагтаар мэдээлэл авах нь ч бий. Эдгээр боломжуудыг бүгдийг нь бүрэн дүүрэн ашиглахыг хичээж байж л тодорхой үр дүнд хүрнэ. Захиргаа, иргэний танхимд самбар гаргах, мэдээний булан ажиллуулах нь сумын төвөөр ирсэн иргэдэд мэдээлэл хүргэх бас нэг хэрэгсэл боловч хамгийн үр дүнтэй нь иргэдийн өөр хоорондоо солилцсон санаа бодол байх нь мэдээжийн хэрэг билээ.

Сумандаа хийх ажлыг ажлын хэсгүүдээр хэлэлцэн боловсруулж, тодорхой санал гаргаад түүнийгээ багийн өдөрлөгөөр, телевиз радиогоор болон бусад арга хэлбэрээр иргэдэд танилцуулж, хэлэлцүүлсэний дараа саналын хуудас илгээдэг. Саналын хуудсанд жагсаан бичсэн ажлуудаас гадна нэмэлт санал өгөх боломжтойгоор, санал авах нь зөв шийдэл болжээ. “Тэгэхгүй бол хөдөөгийн малчид юм бичдэггүй, бие биенээ дуурайдаг, эсвэл нэгнийгээ чи биччих гэдэг” гэж сумын захиргааны гишүүд өгүүлж байна.

“Биндэр суманд суурь хоньтой, азарга адуутай, сувай үнээтэй айлууд байдаг. Нэг айлд байх малыг арав болгох тухай, таван тугалтай үнээ байя гээд хэлэлцүүлэг хийсэн. Хуралд малтай иргэд ирсэн, малгүй иргэд ирээгүй. Гомдол тавьсан иргэд ирээгүй. Тэгсэн нэг талруугаа шийдвэр гарсан. Малтай иргэд гомдолоо ярьсан. Сүүлдээ малчдын хороололтой болъё гэсэн санал гарсан. Үүнд маш их хугацаа мөнгө орно. Нийгмийн асуудлыг шийдэх хэрэгтэй болно.”

Нутгийнхны санаанд нийцсэн, сэтгэлд хүрсэн ажлуудыг хэрэгжүүлэх, нийтийн эрх ашиг, орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллах нь хамгаас чухал билээ. Хурал, хэлэлцүүлэгт нэг талын эрх ашиг, нэг талын оролцогч давамгайлах нь сөрөг нөлөөтэй байгааг ч бас анзаарчээ. Хурал, хэлэлцүүлэгт иргэдийн төлөөлөл ижил тэгшээр, аль аль талыг хамарсан байдлаар оролцох нь шийдвэр зөв байхын эх үндэс болдог.

Газар хол хэдий ч, иргэдийн, түүний дундаас залуучуудын идэвх

оролцоо орон нутгийн хөгжилд бас чухал үүрэгтэй.

...Саяхан соёлын төвдөө малын хулгайтай холбогдолтой хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэг хийхдээ тоо заасан. Нэг багаас таван хүн оролцоно. Нэг хурлын төлөөлөгч, нэг Засаг дарга, гурван малчин байна. 3 малчин байхдаа бүсчилсэн хэлбэрээр төлөөлөл болгон орно.

Энэ нь арай илүү үр дүнд хүрсэн. 21 санал гарч ирсэн. Бид малын хулгайн тасагтай ярилцаад дөрвөөс тавыг нь ажил болгон хийе гэсэн. Бүгдийг нь ажил болгож арай л чадахгүй. Дөрвөөс таван саналыг шийдвэр гаргах түвшний хүмүүстээ танилцуулаад ажил болгох гээд явж байна.

ИТХ-ын даргатай хийсэн ярилцлагаас

Өдрийн тогтсон цалинтайгаар ажил зарлахад хүн ирж ажилладаггүй, тэгсэн атлаа ажлын байр байхгүй байна гэж ярих нь бий. Хотоос сургуулиа төгсөөд ирсэн залуус нэг бол мал маллаж, эсвэл буцаад хот руу явдаг болжээ. Байгаа ажлын байр нь мэдлэг, мэргэжилтэй хүний хийх ажил биш, биеийн хүчний ажил голдуу.

Сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан аль аль нь сумын хөгжил, ажилгүйдэлд нөлөөлж байгаа. Хөрөнгө оруулалтын үр шимийг хүртээд ажлаа эрхэлсэн хүмүүс байна. Ингээд байхад яагаад ажилгүйдэл буурахгүй байна вэ? Урьд нь ахуйн үйлчилгээний төв, модны үйлдвэр, ойн аж ахуй, сүү тосны завод төвлөрсөн байсан. Одоо бол тархай бутархай байна. Нэг сая төгрөг нэг өрхийн амьжиргаанд арай хийж хүрнэ. Зоригтой хөдөлж том “Цогцолбор” байгуулаад ажиллах хэрэгтэй байна.

Фокус бүлгийн ярилцлагын оролцогч 3

Манай суманд олон сан, төсөл хэрэгждэг. Сум хөгжүүлэх сангийн хувьд 2011 оноос хойш 12 иргэнд зээл олгосон. Их хэмжээгээр мөнгө олгодог. 12 төслийн нэг төсөл хийгдээгүй буцаагдсан. Бусад нь хийнэ гэсэн зүйлээ хийсэн, хийгээд явж байна. Гутлын цех, оёдлын машин зэрэг их хэмжээгээр зээл өг гэж байх шиг байна гэхдээ энэ нь цаашид өснө. Сумын төсөл хэрэгжиж байгаа, хийх эрмэлзэлтэй хүмүүст зээл өгдөг, дэмждэг. Талбай, явган хүний замыг эндээ хийсэн. Худаг, байшингийн блокыг эндээ үйлдвэрлэж байгаа. 2011 оноос хойш 12 иргэнд зээл олгож, 1 төсөл буцаагдсан нь “Мал нядалгааны цэг” байсан.

Фокус бүлгийн ярилцлагын оролцогч 4

Судалгааны багийн фокус ярилцлагад орсон зарим хүмүүс “ядуурлыг бид өөрсдөө л бий болгож байна. Хийж л чадвал ажил зөндөө бий. Хамгийн гол нь хамтарч ажиллах, хүчээ нэгтгэх хэрэгтэй” гэж үзэж байсан нь анхаарал татаж байсан юм.

Олон улсын байгууллага, янз бүрийн төсөл хөтөлбөрийн хүрээнд иргэдийн ахуй амьдралд хэрэг болох сургалтыг байнга хэрэгжүүлж байгаа нь өгөөжөө өгч, иргэдийн идэвх оролцоог дээшлүүлж байна. Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн санхүүжилтээс зээл авч үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх иргэдэд ч бас ийм сургалтууд гарааны түлхэц болдог. Шууд бэлэн мөнгө тарааж өгөхөөс¹ иргэдээ чадавхижуулах нь илүү үр дүнтэйг Биндэр сумынхан ойлгож, бүтээж, үйлдвэрлэж чаддаг л болбол сайн сайхан ирээдүй бий хэмээн өгүүлцгээж байна.

2014 оны Орон нутгийн хөгжлийн сангаар иргэдийн санаачилгад тулгуурлан сайн хэрэгжүүлсэн ажлын нэг нь “Архигүй Биндэр” хөтөлбөр юм. Уриалга гарган, архинд орсон иргэдийн гэр бүлтэй уулзан, өсвөр насны хүүхдүүдэд архины хорыг таниулах сэтгэл зүйчийн сургалт зохион байгуулж, нийт иргэдэд ч бас архины хор уршиг, гэр бүлийн үнэ цэнийн тухай лекц уншуулан олон ажлыг өрнүүлжээ. Архины кодлох эмчилгээ, эмчилгээний дараах сургалтын тал үнийг Орон нутгийн хөгжлийн сангаас, “Архигүй Биндэр” хөтөлбөрийн хүрээнд зарцуулах, хамгийн гол нь үүний дараа тухайн иргэдийг суманд хэрэгцээтэй байгаа мэргэжлээр сургах, сурсаны дараа байгууллагуудад хуваарилж ажилтай болгох саналыг иргэд нааштайгаар хүлээн авчээ. Хөтөлбөрт хамрагдагсдын ар гэр, ах дүү, арван жилийн найз нөхөд нь дэмжиж, үлдсэн тал зардлыг нь гаргах, тухайн иргэдийг сэтгэл санаагаар дэмжихэд хамтран ажиллажээ. Энэ ажилдаа Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай бас хамтран ажилласан байна.

Хүн хөгжвөл нутаг орон хөгжинө. Иргэд чадвартай, бүтээж чаддаг,

¹ “Одоо манай суманд 8 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Дэлхийн зөн хүүхдэд зориулсан, “Малчдын амьжиргааг дэмжих төсөл”, “Бор өндөр, Дэлхийн байгаль хамгаалах сан”-гаас “Онон голын байгалийн цогцолбор газар, орчны бүс тогтоох”, Азийн хөгжлийн сангаас “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог хангах төсөл”, UNDP-ээс “Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл” гэх мэт. Эдгээр төслүүд өрх гэрлүү хандсан. Сүүлийн үед иргэдийн сэтгэхүй ядуурах боллоо. Би л ядуу болж төсөлд орье гээд байдаг болсон”.

идэвхитэй бол сумынхны сэтгэл санаа бас өөдрөг, ирээдүйдээ итгэлтэй, хамтран ажиллах, хөдөлмөрлөх хүсэл эрмэлзэл өрнүүн байдаг нь Биндэр сумын жишээнээс харагдаж байна.

Нүдээ олсон зөв санаачилгад олны дэмжлэгийг авах хялбар. Иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжихийн тулд Биндэр сумынхан:

- Ахмадын холбоо;
- Эмэгтэйчүүдийн холбоо;
- Залуучуудын холбоо;
- Ойн нөхөрлөлүүдийн холбоо (34 ойн нөхөрлөлтэй);
- Спортын холбоо;
- Шагайн холбоо;
- Бөхийн холбоог байгуулан ажиллуулж байна.

Иргэдийн идэвх их сэргэсэн. Энэ ажил бусад хүмүүст их нөлөөлж, нийгэмд сайн нөлөө үзүүлсэн. Эмчилгээнд хамрагдсан хүмүүсийг Сантехникийн мэргэжил олгох сургалтад хамруулж байгаа. 10 жилийн хүүхдүүдээс сар бүр санал авдаг. Тэгэхэд архины эсрэг ажил хийгээч гэсэн санал их гаргадаг.

Энэ эмчилгээ эрэмбэлсэн саналын дагуу гарч ирсэн. Эмчилгээнд хамрагдах хүмүүсээс өөрсдөөс нь санал авсан. Ямар сургалтад хамрагдах тухай. Эмчилгээний санал тавихын өмнө ар гэрийнхний хамт уулзалт хийсэн. Архигүй Биндэр баймаар байна. Дэд бүтцийн ажлын үед ажлын байр бий болно. Тэнд ажиллуулна. Байгууллагуудад хуваарилна гэх зэргээр ярилцсан. Үүний дараа эмчилгээнд явах хүмүүс өөрсдийн саналаа хэлсэн. Архигүй Биндэрийн ажлын нэг хэсэг нь ар гэрийн хүмүүстэй нь, эмчлүүлсэн хүмүүстэй байнга уулзаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Нас насныхан, мөн сонирхлынхоо дагуу иргэдийн оролцоо, идэвхийг дэмжих нэг боломж нь сайн дурын, олон нийтийн байгууллагууд билээ. Иргэд өөр хоорондоо санаа бодлоо солилцох, хүсэл сонирхлынхоо дагуу хамтран ажиллах нь санал санаачилгыг нутаг орныг хөгжүүлэх ажилтай уялдуулах, дэмжих, иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлан хөгжихөд хүчтэй дэм болно.

Иргэдээс санал авахад:

- Багшийн хөгжлийн төв;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн төв;
- Аялал жуулчлалын төв;
- Техник технологийн төв;
- Интернет мэдээллийн төв;

байгуулахыг хүссэн нь олон. Бид байгаа нөөц боломжийнхоо хүрээнд ажиллахын тулд “Хүн хөгжлийн төв” байгуулаад, интернетийн шилэн кабельтай холбож, багшаа хөгжүүлэх, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр иргэдэд мэдлэг олгох, залуучуудыг интернеттэй холбогдох боломжоор хангах ажлыг хийхээр төлөвлөж байна. Төлөвлөсөн ажлууд илүү үр дүнтэй болох эсэх нь хамтын ойлголцлоос хамаарна.

Энд ажилгүйдэл бараг байхгүй ээ. Би цагаар ажилладаг. Сардаа 900,000 төгрөг олдог. Ядуу хүн манай нутагт байхгүй. Орон нутгийн компаниудыг улсын төсвөөр хийж байгаа ажилд оруулах хэрэгтэй байна. Орон нутгийн компаний хөрөнгө бага л даа. Гэхдээ барилгын сургуулийг ийм тоосгоор хийх байсан бол бид чадна. 400-аас 500 сая төгрөгөөр бид энэ ажлыг дуусгах л байсан. Сандал ширээг бид хийж чадна. Энд тендер зарласан бол чадах л байсан. Орон нутгийн компани зарим ажлыг хийж чадна шүү дээ. Тиймээс том том ажилд оруулмаар байна. Бид хараад сурна, ажиллаж чадна.

Цагдаагийн буткийг бид барьж чадна. Сургуулийн дээвэр засах ажлыг бид өөрсдөө зарим ажлыг нь хийсэн. Тусгай зөвшөөрөлтэй хүнээс бид дутуу хийнэ гэж бодохгүй байна. Өрлөг, засварчин бүгд байна. Биднээр хийлгэсэн бол сургуулийн ажил аль хэдийнээ дуусчих байсан. Эмнэлгийн засварыг 100 гаруй сая төгрөгөөр хийсэн. Эндээ байгаа хүмүүсээр хийлгэсэн бол болох байсан. Сургуулийн засварыг өөр газраас хүмүүс хийсэн. Тэд хийгээд л явна, бид үлдэнэ. Бид хийж чадна. Тэгвэл туршлага сууна. Заавал компани гэх шаардлага байна уу, багаар ажиллаад одоогийнхоос илүү зүйл хийнэ. Гаднаас бидэнтэй адилхан л хүмүүс ирж ажилладаг шүү дээ. Манай суманд хөгжил байна, сумын компаниуд харин эдийн засгийн хувьд чадавхижаагүй байгаа.

Фокус бүлгийн ярилцлагад оролцогч

Сум хэр зэрэг хөгжих, хөгжлийн төлөвлөгөө хэр зэрэг хэрэгжих нь хөрөнгө оруулалтууд хэр зэрэг чанартай сайн байхаас хамаарна. Хотын

том компаниудад ажлаа даалгаад нүдээ аниад суух, гүйцэтгэгчтэй алхам тутамд нь хамтран ажиллаж, чанартай сайн гүйцэтгүүлэхэд анхаарахын хооронд асар их зааг ялгаа бий. Холоос ирсэн гадны компаниуд ажлаа хүлээлгэж өгсөн болоод явдаг, засвар үйлчилгээг хариуцдаггүй, барьсан байгууламж нь жил хүрэхгүйн дотор засвар хэрэгтэй болдог тухайн нутгийн иргэд олонтаа өгүүлж байсан юм.

Бүтээн байгуулалтын ажилд нутгийн иргэдийг түлхүү оролцуулбал, эргээд хариуцлага тооцоход хялбар. Зарим ажлыг хаа холын, таньж мэдэхгүй компани биш, нутгийн компаниуд гүйцэтгэвэл ядаж л буух эзэн, буцах мөртэй учраас ажлын гүйцэтгэл чанартай байж мэдэх л юм. Тэгэхдээ үүнд найдаж бас болохгүй билээ.

Чанартай сайн ажил гүйцэтгүүлэхийн тулд эхлээд сум өөрөө юу хийлгэхээ, шаардлагаа тодорхой болгох нь чухал юм. Тендэр шалгаруулахад АЗ сертификаттай хүний тоо цөөн байхаас эхлээд суманд зовлон бэрхшээл мундахгүй их. Ядаж л гэрээ байгуулахдаа ажлын даалгавар, хүлээж авах нөхцлөө тодорхой болгож чадвал ажил гүйцэтгэгчид хийх ажил тодорхой, орон нутаг, иргэдийн хувьд хүлээлт тодорхой болно гэсэн үг юм.

Ажлын явцыг хянаж, тухай бүрт нь сайжруулах боломж ч эндээс л бий болно. Өнөөгийн энэ хөрөнгө оруулалтууд нь үр өгөөжөө өгч, цаашдын нутаг орны хөгжлийн суурь болох учиртай. Багыг бага гэлгүй, нэг удаагийнх гэлгүй эхнээс нь хариуцлагатай хандаж чадвал л үр дүнд хүрдэг. Мэргэжлийн зураг, төсөвчингүй, мэргэжлийн хяналт хийх нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан дутагдалтай байсаар л байгаа нь бодитой тулгамдаж буй асуудал юм. Орон нутагт хийж байгаа хөрөнгө оруулалтын өгөөжийг сайжруулья гэвэл ядаж л мэдлэг, мэргэжлийн хувьд төвөөс дэмжих, мэргэжлийн байгууллагуудыг оролцуулах хэрэгцээ зайлшгүй бий.

“Дарга нар л мэддэг байх” гээд зөнд нь орхих бас тийм ч үр дүнтэй арга биш ээ. Иргэд ч бас орон нутагт, иргэдийн эрх ашгийн төлөө оруулж байгаа хөрөнгө, бүтээн байгуулалт, хийж байгаа ажилд анхаарч, хянах нь чухал юм.

Томхон хөрөнгө оруулалтуудаас гадна жижиг бизнес, үйлдвэрлэлд зориулсан зээл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх

нийтийн эрх ашгийн төлөөх ажлуудад ч бас л сайн үр дүнд хүрэх хэрэгтэй нь мэдээж.

Биндэр суманд улсын төсөв, олон улсын байгууллага, бусад эх сурвалжаас 2008-2012 онд нийт 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг зарцуулжээ. Суманд жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, жижиг дунд бизнесийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан ажилладаг. Эдгээр сангуудын дэмжлэгээр орон нутгийн иргэд

- Талх, нарийн боовны цех,
- Блок, явган хүний замын хавтангийн үйлдвэр,
- Сэргээн засах сувилал,
- Ан амьтны музей,
- Гутлын цех,
- Нэхмэлийн цех,
- Хүнсний ногоо даршлах цех,
- Халуун усны цех,
- Гахай, тахианы байр барьж байгуулан ашиглалтад оруулжээ.

Иргэдийн оролцоо аль газар руу, зээл олгоно, мөнгө тусламж өгнө гэвэл ирнэ. Нэг хүн олон давтажтай зээл, тусламж авах сонирхол их байдаг. Тиймээс олон жил ажилласан учраас хэн зээл аваад юу хийснийг сайн мэднэ. Тиймээс олон дахин үр ашиггүй зээл авсан хүмүүс дахиж авья гэж ирэхээ больсон. Зарим овсгоотой хүмүүс бүх зээлд хамрагдсан байдаг ч дахиад л авахыг оролддог. Одоо бид арга механизмаа өөрчлөөд гадаа самбарт бүх зээлд хамрагдсан хүмүүсийн нэрсийг авсан дүн гүйцэтгэсэн ажилтай нь тавьдаг болсон. Ингэснээр хэрүүл гарахаа больсон. Энэ нь ард түмэнд нээлттэй болсноор өөрсдөө ухамсарлаж эхэлсэн.

Сумын засаг даргатай хийсэн ярилцлагаас

Нэг удаа зээл аваад төлж чадаагүй, төлөвлөсөн ажлаа хийж чадаагүй бол дахин зээл тусламжид хамруулахгүй гэсэн байр суурь баримтлан зээл тусламж авсан иргэдийн нэрсийн жагсаалт, зээл тусламжийн зорилго, зориулалт, хэмжээг олон нийтэд ил зарлан байга самбарт өлгөдөг. Энэ нь бусад иргэд ч бас мэдээлэлтэй байх, олон нийтэд ил тод байх нөхцлийг бүрдүүлжээ. Нэг удаа зээл тусламж аваад үр дүнтэй ашиглахгүй л бол дараагийн зээл тусламж авахад хэцүү болно, харин авсан зээл тусламжаа зориулалтынх нь дагуу, үр дүнтэй ашиглаж

чадвал дараа нь дахин дэмжлэг авах боломж бүр илүү болно гэдгийг иргэд ч ойлгодог болжээ. Аль аль нь хариуцлагаа ойлгож, ухамсарлаж, байгаа нөөц боломжоо бүрэн ашиглаж, хичээж зүтгэвэл болохгүй бүтэхгүй ажил гэж байхгүй.

Манай суманд сургалт хангалттай байдаг. Сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, сүлжмэл, нарийн боовны сургалт хангалттай байдаг. Мөн байгаль хамгаалах сургалт байдаг. Манайхан эндээс л өөрийн санааг олох хэрэгтэй. Ажил хийсэн хүн ажил нь бүтэмжтэй байх юм бол нэмээд дэмжлэг хүсээд ороод ирдэг. Тэр ажил нь бүтэмжтэй байгаа учир бид сумаас дэмждэг.

Газрын даамал, н.Батзориг:

Биндэр сум иргэдийг чадавхижуулах, сургалтад хамруулахад онцгойлон анхаарч гадна дотны олон байгууллагуудтай хамтран ажилладаг. Сүү, цагаан идээний сургалтад л гэхэд аймгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран 20 иргэнийг хамруулжээ. Тэд “манай сум сургалтын ажлыг хангалттай зохион байгуулдаг” хэмээн өгүүлж байна. Иргэдийнхээ оюуны баялагт хөрөнгө оруулах нь хамгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалт байдаг.

Орон нутагт бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд мэргэжилтэй, чадвартай ажиллах хүч дутагддаг. Яаж хийх арга мэдэхгүй, технологи байхгүйгээс гацах нь олон. Энэ бэрхшээл Биндэр сумыг ч бас тойроогүй. Мэргэжил эзэмшсэн залуус орон нутагтаа суурьшиж чадалгүйгээр хот суурин бараадах нь их. Нэг үеэ бодвол АЗ сертификаттай хүний тоо олширч байгаа ч, олон чиглэлээр мэдлэг, мэргэжилтэй ажиллах хүч хэрэгцээтэй байгаа билээ. Чадалтай, мэргэжилдээ, бүтээж чадах иргэдийг яаж татах вэ гэдэг асуудал цаашид ч бас толгойн өвчин байсаар л байх бололтой.

Урьд нь сүүн далай хэмээн нэрлэгдэж, цөцгийн тос, цөцгий, сүүн бүтээгдэхүүн ихээр нийлүүлдэг байсан Биндэр сумын хувьд энэ чиглэлээрээ хөгжих боломж бий. Хотын зах зээлтэй ченжийн гар дамжуулахгүйгээр шууд холбохын тулд нэгдмэл зохион байгуулалт, хамтын ажиллагаа хэрэгтэй. Талхны өвөрмөц технологи, жимс жимсгэнийн бүтээгдэхүүн, модон эдлэл гээд хөгжүүлж, зах зээлд хүргэж чадвал нутгийн брэнд болохоор бүтээгдэхүүн чамлахааргүй олон бий.

Иргэд юуны өмнө сумын төвд битүү захтай болохыг хүсч байна. Энэ нь бараа, мах сүү ногоо, байгалийн гаралтай бүтээгдэхүүнээ солилцох, зарж борлуулах, талх, цагаан идээ, жимс жимсгэнийг гэрээр зарахыг больж нийтэд хүргэхэд тус болно. Үсчин, гуталчин, зурагчин, хими цэвэрлэгээний газрууд бүхий ахуй үйлчилгээний төвийн хэрэгцээ ч бас бий. Нутгийн байгальд ээлтэй, уламжлалт аргаар үйлдвэрлэсэн “ориг” бүтээгдэхүүн ченжийн гараар дамжихдаа чанар нь муудаж, үнэ өсдөг гэж тэд өгүүлж байна.

Биндэр сумынхан мэдлэг мэргэжилтэй залуучуудаа татахыг хичээхээс гадна хойч үеэ хөдөлмөрч, бүтээлч болгон хөгжүүлэхийг ч бас зорьж байна. Хойд бүсийн сумдын залуучуудын спортын наадмыг гурван жил дараалан зохион байгуулж, ая тухтай орчин нөхцөл бүрдүүлэхийн тулд дэд бүтэц бүхий хувийн хаусын жишиг хороолол төлөвлөжээ.

Хөдөлмөр зуслан байгуулан ажиллуулж эхэлж байгаа нь есөөс дээшхи ангийн сурагчдыг зуны амралтаар нь хөдөөгийн ажилд сургах, хүч чадал муутай байгаа иргэдэд тус нэмэр болгох, монгол ёс заншилаа эзэмшүүлэх зорилгоор хийж байгаа ажил юм. Малчид хоол ундыг дааж, хүүхдүүдийн хийсэн цагаан идээний дээжийг өөрсдөд нь өгөх ажээ. Үнээ саах, хашаа янзлах, морь унах, даага сургах, хонь хариулах, хөр гаргах, хонь хяргах, цагаан идээ борлуулахаас хэлээд хийж сурах ажил хүүхдүүдэд зөндөө. Ойн нөхөрлөлүүдэд ажиллан ой цэвэрлэх, нөхөн сэргээх, байгаль орчноо хамгаалах ажилд суралцах нь ч бас сурагчдад хэрэгтэй.

ХӨГЖЛИЙН ГАРЦАА ЗӨВ ТОДОРХОЙЛЖ ТӨСВИЙГ ЗОХИСТОЙ ХУВААРИЛАХ НЬ

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ СУМ

Сумын хөгжлийг төлөвлөхөд орон нутагт тулгамдаж буй нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг зөв тодорхойлохын зэрэгцээ сумынхаа нөөц боломж, чадавхид тулгуурлаж улс орон, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх алсын хараа нэн чухал юм.

Төлөвлөлтөд нэг талаас сум, орон нутгийн удирдлагын санаачилга, удирдах арга барилын онцлог чухал ач холбогдолтойн дээр нөгөө талаас иргэдийн хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт шийдвэрлэх нөлөөтэй. Иймд оршин суугаа газар нутгаа хөгжүүлэх шийдлийн тохиромжтой хувилбарыг сонгож боловсруулах, хийх ажлаа төлөвлөх, төсвийг зөв хуваарилах, төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй ажилд хяналт тавих ажилд хамтын хичээл зүтгэлээр оролцож, төрөлх сумынхаа ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулахад иргэн бүрт тэгш боломж олгох нь сумын удирдлагын өмнө тулгарч буй том сорилт болоод байна.

Төсвийн тухай шинэ хууль орон нутаг бие даан хөгжих шинэ гарц, шинэ боломжийг бий болгож байгаа билээ. Энэ нөхцөлд хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж эхэлж буй сумын хувьд үйл ажиллагаа нь саяхан эхэлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай эхнээс нь нарийн уялдуулж төлөвлөх шаардлага тулгарч байна.

Газар нутгийн байршил, дэд бүтцийн хөгжил, удирдлагын арга барил, иргэдийн идэвхи зүтгэл зэрэг сумын хөгжилд нөлөөтэй олон хүчин зүйлс бий. Гэхдээ эдгээр хүчин зүйлсээс тухайн суманд чухам аль нь илүү давамгайлах нөлөөтэйг зөв тооцоолж, түүнд тохирсон бодлого боловсруулж төлөвлөхгүй бол хөгжлийн төлөвлөгөө ямар ч үр дүн, үр нөлөөгүй баримт бичиг болж хувирах нь тодорхой.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТТЭЙГЭЭР СУМЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

2003 онд Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газраас санаачлан Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн” 26-р зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулан “Сумын засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” боловсруулсан нь тус сумын анхны бөгөөд өнөөг хүртэл гартаа барьж хүнд үзүүлж ирсэн төлөвлөлтийн ганц баримт бичгийн үндэс нь болжээ.

Энэ баримт бичиг нь Засаг даргын тамгын газрын алсын хараа, зорилго, үйл ажиллагааны хамрах хүрээ, нийлүүлэх ажил, бараа бүтээгдэхүүн, хөгжүүлэх салбар чиглэлийг дэлгэрэнгүй томъёолон тусгаж богино хугацаанд буюу 2003-2005 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Зорилго:

Төрийн үйлчилгээг өндөр боловсрол, ур чадвартай албан хаагчдаар иргэдэд хүргэж, компьютержсэн мэдээллийн орчноор хяналт зохицуулалтыг хийж, малчдын хоршоог байгуулан ХАА-г дэмжих, байгаль-түүх соёлын дурсгалт газрыг хамгаалан аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтэц-эрчим хүчний давуу талыг ашиглан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, боловсрол-соёл-эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарыг хөгжүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах...

Цэнхэрмандал сумын Засаг даргын тамгын газар, 2003

Гэвч энэ зорилго нь сумын удирдлагын халаа сэлгээ, төсвийн хүрэлцээ муу, мэргэжлийн ажиллах хүчний хомсдол, удирдлагын арга барил ялгаа, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй үл уялдах зэрэг олон шалтгааны улмаас бүрэн хэрэгжиж чадаагүй. Мэдээжээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө хэлбэрээр боловсруулсан тул зарим нэг зорилтууд нь биелсэн гэж үзэж болох боловч сумыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой зорилтуудын биелэлт хангалттай хэрэгжиж чадаагүй нь иргэдэд чамлалттай санагддаг ажээ.

2008 онд 2008-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны богино хугацааны төлөвлөгөөг дахин баталсан нь цаг хугацааны хувьд л ондоо байснаас биш эхний баримт бичгээс агуулгын хувьд огт ялгаагүй байв.

Энэ баримт бичгээс хойш тус суманд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох баримт бичиг батлагдаагүй бөгөөд өнөөг хүртэлх сумын засаг дарга нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг богино, дунд хугацааны баримт бичгүүдэд тулгуурласан өөрийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймаг, улсын төр захиргааны байгууллагуудын үүрэг, даалгаварыг биелүүлэх чиглэлээр л ажиллаж иржээ.

Угтаа бол сумын нөөц бололцоо, нөхцөл байдлыг тооцоолсны үндсэн дээр хөгжлийн гарцаа тодорхойлоход иргэдийн оролцоог хангаж ажиллах учиртай. Тэгж байж сая олон нийтийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах боломж бүрдэх юм.

“Сумын хөгжлийн мастер төлөвлөгөө бол тухайн сумыг хөгжүүлэх боломжтой бүх үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, арга хэмжээг урьдчилан тооцоолж ямар ч нам, улс төрөөс үл хамааран үе үеийн сумын удирдлагууд үйл ажиллагааны үндсэн чиглэлээ болгон хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж байх баримт бичиг”

Засаг дарга Л.Баатар

Сумын засаг дарга Л.Баатар дээр дурдсан хоёр баримт бичгийг боловсруулахад голлох үүрэгтэй оролцож явсан туршлагатай албан тушаалтан юм. Тэрээр 2013 онд сумын засаг даргаар томилогдсон даруйд Засаг даргын тамгын газрын даргаар ахлуулсан Төлөвлөлт хяналтын хороог 29 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 4 бүлэгт хувааж сумынхаа хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үүргийг өгч ажиллуулж эхэлжээ.

Тэрээр эхний ээлжинд юуг, хэрхэн хөгжүүлэх арга зам, чиглэлээ зөв тодорхойлсон баримт бичиг нэн шаардлагатай байгааг олж харжээ.

Хөгжлийг төлөвлөхөд урт, дунд, богино хугацаанд тулгарч болох сорилтуудыг тодорхойлж түүнийг даван гарах шийдлийн зөв хувилбаруудыг боловсруулах хэрэгтэй. Хөдөө орон нутаг, аймаг, улс орны нийгэм-эдийн засаг, байгаль орчинд үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг боловсруулан төлөвлөх нь хүн бүрийн хийгээд байдаг амархан ажил бас биш юм. Төслийн шинэ санаа гаргах, өртөг зардлыг тооцоолж, ирээдүйг харсан стратеги боловсруулах нь чадварлаг ажиллах хүчээр дутмаг хөдөөгийн сумын хувьд хэцүүхэн даваа ажээ.

Хэдий тийм ч зориод, хийж бүтээе гээд зүтгэвэл ямар ажлын ард гарч болдогийн үлгэрээр сумынхаа хөгжлийн төлөвлөгөөг Мерси Кор Олон Улсын Байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулах ажлыг эхлүүлж чаджээ. 2013 оны 12 дугаар сараас эхлэн Төлөвлөлт, хяналтын хорооны гишүүддээ 2 удаа мэргэжил аргазүйн хичээл мэргэжлийн багш нараар заалган, сурсан аргазүй, туршлагадаа тулгуурлан орон нутгийнхаа хөрсөнд буух хөгжлийн төлөвлөгөөний төслийг бэлтгэж эхэлжээ.

Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил арга зүйн тусламж маш их хэрэгтэй юм гэдгээ тэд уламжилж байна. Одоо гурав дахь удаагаа мэргэжил аргазүйн сургалтыг авч, төсөл хөтөлбөрүүдийн тооцоо хийх, нарийвчлан бодож гаргах, эмхэтгэн нэгтгэх ажлуудыг мэргэжлийн хүмүүсийн тусламжтай хийхээр шийджээ.

Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийг аль болох бүрэн оролцуулах, улмаар өөр сум, аймаг, нийслэлд амьдардаг сумын уугуул иргэдийг Нутгийн зөвлөлөөрөө дамжуулан татан оролцуулж сумын хөгжлийн холбогдолтой шинэлэг, судалгаанд суурилсан, ач холбогдол өндөр төсөл, хөтөлбөр, санал, санаачилгууд цуглуулан шинжилгээ хийсэн бөгөөд орон нутгийн онцлог, улс, аймгийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулахыг хичээх болжээ.

Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулах Төлөвлөлт, хяналтын хороо нь хөгжлийн алсын хараа, тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтуудаа урьдчилан тодорхойлсон байна.

Тэд хөгжлийн тэргүүлэх чиглэлээ нийгэм, эдийн засаг, бизнес орчин, байгаль орчин гэсэн үндсэн дөрвөн бүлэгт хуваажээ. Эдгээр бүлгүүд нь тус бүрдээ 2-оос 5 дэд бүлэгтэй, дэд бүлэг тус бүр дотроо 4-өөс 8 төсөл үйл ажиллагааны зорилтуудтай. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан төсөл хөтөлбөрүүд нь 2 үе шаттай (2015-2020, 2021-2025 он) хэрэгжих юм.

Цэнхэрмандалчууд мастер төлөвлөгөөнийхөө алсын харааг 2025 он гэхэд “Эко орчиноор хүрээлэгдсэн, эдийн засгийн хараат бус, эрүүл чийрэг, соёл боловсролтой, ажилтай орлоготой иргэдтэй, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэлээ болгосон тэргүүний

жишиг сум болно” гэж тодорхойлжээ.

Одоогоор төлөвлөгөөний эхний хувилбарыг боловсруулан мэргэжлийн байгууллага, хүмүүсийн зөвлөмжийн дагуу сайжруулж ойрын хугацаанд батлуулан хэрэгжүүлэхийн төлөө нөөц боломжоо шавхан ажиллаж байна. Энэ ажлын үр дүнд Цэнхэрмандалчууд сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлээ бэлчээрийн мал аж ахуй, хариуцлагатай уул уурхай, аялал жуулчлал гэсэн гурван салбарын хөгжлөөс хамаарна гэсэн шийдэлд хүрчээ. Иймээс эдгээр салбаруудын хүрээнд орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ оруулах, улс орны хөгжилд жишиг болох ажлуудыг төлөвлөх болсон байна.

ОРОН НУТГИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ТӨСВИЙГ ҮР ДҮНТЭЙ ХУВААРИЛАХ НЬ

2013 онд ажлаа хүлээж авсан шинэхэн удирдлага мөрийн хөтөлбөртөө тус сумын хөгжлийн зорилго, чиглэлийг дараах байдлаар тодорхойлон, хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

Тус сумын хөгжлийн гол зорилго нь харууцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, нийгмийн салбарын хөгжил хангагдсан, ХАА, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхайг цогцлоон хөгжүүлж ажил орлого нэмэгдсэн, тав тухтай орчин бүрдсэн ногоон сум болон өргөжин хөгжих юм.

Сумын засаг дарга Л.Баатартай хийсэн ярилцлагаас

Энэ зорилготой холбоотойгоор тус суманд тулгарч буйнэн тэргүүний асуудал бол хуучирч, үеэ элээсэн, хэзээ мөдгүй нурах барилга байгууламжуудад ажиллаж байгаа төсвийн байгууллагууд болоод байна. Төрийн үйлчилгээг чанартай, шуурхай хүргэхэд орчин нөхцөл чухал үүрэгтэй.

2010 онд сургуулийн багш, ажилчид, сурагчид сургуулийн барилгыг шинэчлэх санаачилга гаргаж, түүнийгээ сумын засаг даргын тамгын газарт уламжилжээ. Засаг дарга нөхцөл байдлыг шалган үзээд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан аймгийн засаг дарга, холбогдох яамны удирдлагуудад уламжилж хөөцөлдсөний дүнд

2013онд тус суманд улсын төсвийн хөрөнгөөр 1.8 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ сургуулийн байр баригдаж ашиглалтад орсон байна.

Энэ нь иргэдийн өөрсдийн санаачилга, оролцоо, хяналтл байвал хөдөө орон нутагт тулгамдаж буй аливаа ажлыг хурдан шийдвэрлэж, чанартай, шуурхай гүйцэтгэх боломж байгааг харуулж байгаа хэрэг юм.

Сургуулийн шинэ байртай болсноор сурагчдийн тоо нэмэгдэх, хүүхдүүд идэвх чармайлттай суралцах, бусад сумдаас шилжин ирэх суралцагчдын тоо нэмэгдэх, хүүхдийн өвчлөл, ханиад томуу багасах зэрэг эерэг үр дүн гарч шилжилт хөдөлгөөний гадагшаа биш дотогшоо чиглэсэн урсгал бий болж байгаа ажээ.

Орон нутгийн хөгжлийн сан нь сум, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэхийн тулд төрөөс орон нутагт олгож буй маш чухал боломж юм. Цэнхэрмандалчууд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд нийт 15 ажил үйлчилгээг 190 сая төгрөгийн төсөвтэйгээр хийхээр төлөвлөж, 11 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй, 4 ажлыг 80 хувийн гүйцэтгэлтэйгээр, нийт 165 сая төгрөгийн өртөгтэйгээр хүлээн авчээ.

Сумын удирдлагууд сумын хөгжлийн зорилгоо тодорхойлсон, ажиллах талбараа олж харсан, ямар асуудалд голлож анхаарахаа ойлгосон боловч яаж ажиллах арга барилаа нэг л олж өгөхгүй байна.

Төсвийн тухай шинэ хуулиар иргэдийн оролцоотойгоор буюу тэдний гаргасан санал санаачилгын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах үүрэгтэй. Тиймээс эхний 2 жил буюу 2013, 2014 онууд бол иргэдээс гарсан санал санаачилгыг голчлон дэмжсэн боловч эхийг нь эцээж тугалыг нь тураахгүй байхын үүднээстөсөл болгоныг боломжийн хэрээр санхүүжүүлэх гэж оролдсон нь төсвийн хөрөнгийг аманд ч үгүй, хамарт ч үгүй болоход хүргэжээ.

Эхний жилд баталсан журмынхаа дагуу багийн иргэдийн ирүүлсэн саналыг сумын Засаг даргын тамгын газрын ажлын хэсэгтэй хамтран

Сумын хөгжлийн зорилгоо тодорхойлж, ажиллах талбараа олж харах нь эхний алхам боловч яаж ажиллах арга барилаа олох, сайжруулах нь бас чухал бөгөөд амаргүй сорилт юм.

эрэмбэлж төсвийн хөрөнгийг сумын төвийн тохижилт-дэд бүтэц, иргэдийн эрүүл аюулгүй орчин, хөдөөгийн малчид, байгаль орчны хамгаалал, нийгмийнаюулгүй байдал зэрэг бүх салбарт тэнцүү хүртээж, хөгжүүлэх хэлбэрээр шийдвэрлэхийг зорьсон.

Гэвч энэ нь энгийн иргэний нүдээр харвал иргэдийн санал болгоныг дэмжиж байгаа мэт харагдаж буй боловч төсөв нь хүрээгүйн улмаас гүйцээгүй, дутуу, чанаргүй гүйцэтгэсэн ажлуудын тоог нэмэгдүүлсэн явдал болжээ. Ирсэн төсөл бүхнийг дэмжсэн нэртэй сууж төсөв болон хүчээ тарамдуулах уу, эсвэл сумын хөгжилд үнэхээр хэрэгцээтэй, бодитой, ажил хэрэгч саналыг дорвитойхон дэмжээд өгөх үү гэдгийг бодох л асуудал болоод байна.

Цэнхэрмандал сумын нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбар нь мал аж ахуй, уул уурхай, аялал жуулчлалд суурилахболовч юуны өмнө хөдөө аж ахуйруугаа хандсан хөгжлийн гол ажлуудыг төсөвлөх нь зүйтэй гэж үзээд аливаа санхүүжилт, арга хэмжээг сумын төв гэхээсээ илүү хөдөөгийн малчдын асуудал, хүрээлэн буй орчны хамгааллыг түлхүү анхаарч байна.

Ирсэн төсөл бүхнийг дэмжсэн нэртэйгээр төсөв болон хүчээ тарамдуулах уу, эсвэл сумын хөгжилд үнэхээр хэрэгцээтэй, бодитой, ажил хэрэгч саналыг дорвитойхон дэмжих үү?

Мал аж ахуйн эрсдэл, малын гоц халдварт өвчнийг бууруулах зорилгоор баг тус бүрт малын эмнэлэг, сумын төвд малын эмийн сан шинээр байгуулах, малыг вакцинжуулах ажил эрчимтэй хийгдэж, Хэрлэн гүүрний орчимд мал эмнэлгийн лабораторитой болохоор газраа товлон лабораторийн багажны заримыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдаж авчээ.

Хөдөөгийн малчдад тулгамддаг гол асуудал бол бэлчээрийн болон ундны усны асуудал байдаг. Үүнийг шийдэхийн тулд бэлчээрийн менежментийн төслөөр 2, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, орон нутгийн хөгжлийн сангаар 4, уул уурхайн хөрөнгөөр 2, хувийн хөрөнгөөр 1 гээд нийт 10 гүн өрмийн худгийг 2013 онд гаргасан нь малчдын сэтгэлд хүрсэн ажил болсон байна.

Хөдөө аж ахуйд түшиглэн хөгжих сумын хувьд түүнд тулгуурласан

хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллах нь бодлогын хувьд зөв зүйтэй алхам юм. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2010-2014 онд нийт 45 тооны жижиг дунд үйлдвэрийн төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлжээ.

Тухайлбал, Хонгорын талд хүнсний ногоо, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тарих, боловсруулах хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрийн зориулалтаар 20 га газрыг хувийн хэвшилд олгож дэмжсэн нь 6-аас 8 иргэнийг ажлыг байраар хангаж, мал аж ахуй, газар тариаланг хослуулсан эдийн засгийн үр ашгаа дээшлүүлэх боломжийг бүрдүүлж буй нэг хэлбэр юм.

Нүүдлийн мал аж ахуй бол Монголчуудын уламжлалт соёл иргэншлийн салшгүй хэсэг билээ. Нэг талаас энэ соёлыг өвлүүлэн үлдээх, нөгөө талаас иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс 2013 онд цөөн малтай айлыг малжуулах, залуу малчдын халааг бэлтгэх зорилгоор нийт 9 өрхийг малжуулж, 12 өрхийг орон гэртэй болгожээ.

Малгүй болон цөөн малтай иргэдийг зөвхөн малжуулаад зөнд нь орхисонгүй. Олон малтай, амьжиргаа сайтай өрхүүдийг түшиглүүлэн огт малгүй буюу цөөн малтай иргэдийг оролцуулан малчдын бүлэг хоршоо байгуулах, хөдөлмөрөөрөө хоршин ажиллах нь илүү үр өгөөжтэйг мэдэрч, хэрэгжүүлсэн нь өдгөө үр өгөөжөө өгч байна.

Мал аж ахуйг хөгжүүлэх үндэс нь үүлдэр угсааг сайжруулах, эрсдлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх ажил чухал гэж үзэж Орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгөөр хэрэгжүүлж эхлээд байна. 2009 оны зудад 16000 толгой малаа үрэгдүүлсэнээс дунджаар 2,4 тэрбум төгрөгийнхохирол амссан. Үүнд дүгнэлт хийж анхаарлаа хандуулан олон ажлыг санаачлаад байна.

Цэнхэрмандал сум байгалийн эрдэс, нөөц баялаг элбэгтэй. 1945 оноос эхлэн Дорнод экспедиц геологийн хайгуул судалгаа хийж цагаан тугалга, вольфромын нөөцийг тогтоон улмаар хувь нийлүүлсэн Сов-Монгол металл нийгэмлэгийн харьяанд 1953 онд Модотын уурхай байгуулагдаж 1957 он хүртэл ажиллахдаа 10000 орос, монгол ажилчинтай, авто тээврийн 5 баазтай 1000 гаруй авто машин, уулын техниктэй 10 баяжуулах фабриктэй уул уурхайн үйлдвэрлэлийн төв

болж байсан түүхтэй².

Гэвч зах зээлд шилжсэнээс хойш замбараагаа алдсан байгалийн баялгийг ямарч татвар төлөлгүй, нөхөн сэргээлт хийлгүй ашигладаг эзэнтэй, эзэнгүй олон уурхай (цагаан тугалга, гянт болд, жонш, алт, зэс, нүүрсний болон, элс хайрганы карьер) бий болсон нь сумын удирдлагын санааг зовоосон асуудал болж байна. Үүнийг дагаж гар аргаар алт олборлогчид ч ихсэж, тогтвор суурьшилтай ажил эрхлэлгүй, дуртай үедээ шороо ухан өдөр хоногоо өнгөрөөх сонирхолтой хүмүүс ч олширчээ.

Иймд засаг дарга мөрийн хөтөлбөртөө хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх “Нутгийн хишиг” хөтөлбөрийг тусгажээ. Хөтөлбөрийн гол зорилго нь одоогийн ашиглалтын лицензтэй байгаа 11, хайгуулын лицензтэй 12 талбай бүхий 19 аж ахуйн нэгжийг 2016 он гэхэд 50 хувиар цөөрүүлэн ашиглаж байгаа байгаль экологи, хүн амьтанд халтай технологийг халж, нөхөн сэргээлтийг хийлгэх, хууль бус олборлолтыг зогсоож уурхайн ашиг, орлогыг нутгийн иргэд хүртээдэг байх системийг нэвтрүүлэхэд циглэсэн байна.

Хөтөлбөр ч үр ашгаа өгөөд эхэлжээ. Сумын засаг даргын тамгын газраас эдэлбэр газрыг ашигласны төлөө суманд 10-аас 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж байх САНАМЖ бичгийг аж ахуйн нэгжүүдтэй байгуулсаны дүнд 6 уурхайгаас тус бүр хорь, хорин сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг сумын төсөв төвлөрүүлэн үүгээрээ 10 айлыг гэрээр хангах, 4 залуу малчныг малжуулах, бэлчээрт худаг гаргуулж усан хангамжийг сайжруулах, улирлын чанартай уурхайн ажилд орон нутгийн 38 иргэнийг ажиллуулах, 80 сая гаруй төгрөгийн мах, сүү, цагаан идээг орон нутгийн иргэдээс уурхайд нийлүүлэх боломж олгосон гээд чамлахааргүй ажил хийгээд амжсан байна.

Мөн элс, хайрганы эзэнгүй байсан хоёр газрыг эзэнтэй болгон, хяналтад авснаар хураамж төлдөг тогтолцоог бий болгож мал, амьтан орохоос сэргийлсэн хашаа барих, гар аргаар ашигт малтмал эрхлэгчдийг байнгын ажлын байраар хангаж орлогын тогтвортой эх үүсвэртэй болгох, нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангаар малжуулах,

² Хэнтий аймгийн вэб хуудас (<http://khentii.mn/>)

жигжиг дунд бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сэтгэлд оч байвал, тулганд гал бадарна гэдэг. Зөвхөн төсвөөс хараад суух биш, боломж бололцоогоо ашиглавал ихийг бүтээж болно.

Байгаль дэлхийдээ шүтэж амьдардагийн хувьд байгаль орчноо хамгаалах, ногоон эдийн засаг, ногоон орчин бүрдсэн сум болон хөгжих нь Цэнхэрмандалчуудын хэтийн зорилго юм. Иргэдийн оролцоотойгоор байгаль

хамгаалах ажлыг өрнүүлэх төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин уул уурхайн нөхөн сэргээлт хийх, ой хамгаалах ажлыг эрчимтэй зохион байгуулах, цэцэрлэгжүүлэх, байгаль хамгаалагчийн тоог нэмэгдүүлэн ажиллуулах, унаажуулах шаардлагатай хөрөнгийг уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэж чаджээ.

Эдгээр ажил нь нутгийн иргэдэд ч нөлөөлж, ард иргэдийн санаачилгаар “Цагаан Нуурыг аврая” хөдөлгөөн өрнөсний дүнд нутаг ус, нуураа хамгаалах нөхөрлөл байгуулах үндэс болжээ. Энэ нөхөрлөл нь нутгийн иргэдээс бүрдсэн бүлгэм бөгөөд Цагаан нуурыг хамгаалах төсөл боловсруулан багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн нь дэмжигдэж, дараагийн шатны байгуулагуудад хандан санхүүгийн эх үүсвэрээ хайх боломжийг нээжээ. Цагаан нуур нь Согоот багийн Жаргалантын аманд байрладаг, орчмын мал амьтан, усны шувуудын ундаа болсон ганц нуур юм. Сүүлийн жилүүдэд дулаарал эрчимтэй явагдаж, Согоотын хөндийд мод бэлтгэл эрчимтэй явагдсанаас Согоотын голын ус тасрах болсон нь нууранд нөлөөлж, улмаар ус нь ширгэж шалбааг болох болсон нь нутгийн иргэдийн амьдрах, мал маллах нөхцөлд сөргөөр нөлөөлөх болсон байна.

Нуурыг тойрон Согоотын хөндийг дагаж нутагладаг бидний хувьд нуур ширгэж байгаа нь бидний хүүхэд байхаасаа нутаглаж ирсэн тэр сайхан үеийг үгүйсгэж байгаад сэтгэл өвддөг мөн бидний амьдрал ахуйд ч бэрхшээлтэй 10 км-ын цаанаас очиж малаа услана. Ингээд орхих харамсалтай санагдаж байна. Үүнийг хамгаалахын тулд сумын удирдлагуудад хэл хүргэж ойлгуулж хамгаалуулах, талаас нь төсөл бичиж өгсөн. Одоо хөөцөлдөж байна. Аймгийн байгаль орчны албанд бас төслөө хүргүүлсэн байгаа.

Малчин Д. Тунгалагтай хийсэн ярилцлагаас

Цэнхэрмандал байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газрууд олонтой. Тухайлбал Тэмүүжин 1189 оны “Шаргачин тахиа” жилд хамаг монголын хаан ширээнд өргөмжлөгдөн “Чингис хаан” цол хүртэж байсан “Хар зүрхний хөх нуур”, “Сэнгүр горхи” зэрэг түүхийн дурсгалт газрууд бий.

Эдгээр түүхэн дурсгалт газруудыг түшиглэн сумандаа аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч 2002 онд Хар зүрхний хөх нуурт Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулан гэрэлт хөшөө босгосон ба түүх дурсгалын энэ цогцолбор газарт их хаадын дурсгалыг хүндэтгэж Монголын төрийг удирдаж байсан бүх хаадын сийлбэр хөшөөг босгосон жуулчны бааз ажиллаж байна.

Хөх нуурын байгаль орчныг хамгаалах зорилгоор тэнд дахиж жуулчны баазын зориулалтаар газар олгохыг хориглосон нь аялал жуулчлалыг зөв менежментээр хөгжүүлж, нутгийн бүх иргэд жуулчны бааз байгуулан олсон дорвитой ашиггүй хэр нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлсэн бодлого ажээ.

Сум орон нутгийн төв гэдэг бол яах аргагүй тухайн сумын нүүр царайг илтгэдэг газар. Сумын төвийн төлөвлөлт, тохижилт дэд бүтцийн хөгжил ямар байгаагаар тухайн сумыг үнэлэх нь бий. Иймд сумын төвийн зам харилцаа, барилга байгууламж, интернэт-мэдээлэл холбоо, төрийн үйлчилгээ, үйлдвэр аж ахуйн нэгжийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй болгох нь чухал байдаг. Хөдөөгийн сумдын хүсэн хүлээдэг нэг чухал зүйл бол төв зам, инженерийн шугам сүлжээнд холбогдох түүнийг дагасан үйлчилгээний салбарын хөгжил юм.

Уулын энгэрт байрладаг Цэнхэрмандал сумын төв үерийн хамгаалалтгүй байх аргагүй. Үүнийг шийдэхгүйгээр бусад тохижилтыг хийх нь үр дүн бага тул зураг төслийг хийж байна. “Сумын төвийн дахин төлөвлөлт” төслийг хэрэгжүүлж ОНХС-аар санхүүжүүлж, бодлогын баримт бичигтэй болохоор Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус сумын нутаг дэвсгэрийг хамран 96 км хатуу хучилттай зам тавигдсан нь Өндөрхаан, Баганууртай холбогдсон. Зам дагаад үйлчилгээ эрхлэгчид ч бий. Энд тодорхой эрхэлсэн ажилгүй, малгүй, зэргэлдээ аймаг сумдаас ирсэн нийт 30-аад өрх хоолны газар, буудал, хүнсний

дэлгүүр, дугуй засвар ажиллуулан амжиргаагаа залгуулдаг. Тэдний дийлэнх нь бусад аймаг сумдын иргэд бөгөөд энд ирээд 5-аас 7 жил үйл ажиллагаа эрхэлж байгаа ч тухайн суманд бүртгэлгүйгээстөрийн үйлчилгээ авч, асуудлаа шийдүүлж чадахгүй байгаа бэрхшээл бий.

Зам дагаж хөгжил ирдэг гэдэг ч энэ нь зам, дэд бүтцийг хэр зэрэг үр өгөөжтэй ашиглахаас хамаарна. Хөгжих нөөц боломжид нөлөөтэй олон зүйлийн нэг нь л зам. Бусад боломжоо ч бас зөв тооцож, уялдуулах нь чухал юм.

Зам дагаж хөгжил ирдэг гэдэг. Зам дагаж мэдлэг боловсрол бүхий хүмүүс ирж суурьшин сум орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулна гэдэг хөгжил буурай сумын хувьд тийм ч боломжтой зүйл биш юм. Харин зам ашиглаж тээврийн үйлчилгээ, худалдаа аж үйлдвэр хөгжих явдал бий. Гэвч цөөхөн хүн амтай, эрэлт хэрэгцээ багатай сумдад энэ иргэдийн ахуй амьдрал, орлогод нөлөөлөхүйц байх нь ховор. Томоохон хот сууринд ойрхон байрладаг жижиг сумдын хувьд зам дагаж хөгжил ирэхээсээ илүү хөгжлийн чөдөр тушаа болох нь ч бий. Тиймээс дэд бүтцийн хөгжлийг зөвхөн замаар баримжаалалгүйгээр бусад гарцыг эрж хайх нь Цэнхэрмандал суманд тулгарч буй нэг чухал сорилт юм.

Миний мөрөөдөл бол интернет гээч юманд холбогдох байсан. Одоо манайд ороод ирчихсэн сайхан байна.

Баг дээр ч сум дээр ч одоогийн залуучууд гэхгүй хөгшичүүдэд ч гэсэн интернет хэрэгтэй байна.

Одоо хүүхдүүд чинь интернетээс хараад өвчнөө эмчлэх оношлох энгийн аргуудыг олж мэдээд миний мэдэхгүйг хэлж өгөөд байна шүүдээ.

Залуучуудыг хөдөөд татахын тулд тэр нь л байгаасай гэж бодож байна.

Эмнэлгийн сувилагч Ичинхорлоотой хийсэн ярилцлагаас

Тус сум 2013 оны орон нутгийн хөгжлийн сангаар сумын төвийн тохижилтод нийт санхүүжилтийн 40 хувийг зарцуулсны дотор шуудан харилцаа холбооны салбарт техник технологийн өөрчлөлтийг хийж утасгүй интернетийн орчин бүрдүүлжээ.

Энэ нь айл өрх, албан байгууллагууд технологийн дэвшлийг ашиглах боломжийг нээгээд зогсохгүй орон зай, цаг хугацаанаас үл хамаарах

нийгэм, соёлын харилцааг бий болгоход нөлөөлж байна. Мэдээлэл түгээх, олж авах шуурхай боломж орчин нөхцөл нь бүрдсэнээр иргэд ч төр захиргааны байгууллагаас хурдтай, чанартай үйлчилгээг хүсч хүлээх, сумаа хөгжүүлэх санаа бодлоо илүү чөлөөтэй солилцох, идэвхтэй оролцох боломжтой болж байгаа хэрэг юм.

ИРГЭДИЙН ИДЭВХ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Орон нутгийг хөгжүүлэх, хамгаалах, бодлого шийдвэр гаргахад иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал хүсэлт дуу хоолойг төрийн бодлого шийдвэрт тусгах чиглэлээр төрийн зүгээс хэрэгжүүлж байгаа нэг чухал ажил бол төсвийн тодорхой хэсгийг иргэдийн оролцоотойгоор зарцуулах боломжийг бүрдүүлсэн явдал юм. Энэ хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг иргэдийн оролцоотойгоор сонгох, эрэмбэлэх, худалдан авах, гүйцэтгэлд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж журам баталсан нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа бол шинэ ажлын эхлэл байсан. Энэ ажлыг үр дүнтэй зохион байгуулахад Цэнхэрмандал сумынханы хувьд олон бэрхшээл тулгарсан ч, алдаа онооноосоо сургамж авч туршлага хуримтлуулсан нь ч бас олон бий.

Иргэд хурал цуглаанд идэвхтэй оролцдоггүй, оролцож байгаа хүмүүс нь өөрийн хувийн эрх ашигт хэрэгцээтэй зүйлийг чухалчилаад олон нийтийн эрх ашгийг хөндсөн санал хүсэлт тавьдаггүй, эрхзүйн мэдлэг дутмаг учраас асуудалд ач холбогдол өгч оролцдоггүй, саналын хуудсанд нэмэлт санал бичдэггүй, хүнээр бөглүүлдэг, ар гэр, ахуйн гачигдалаас болж олон нийтийн ажилд оролцож чаддаггүй зэрэг олон хүндрэл учирч байсан ч иргэдийг оролцуулахын тулд засаг даргын тамгын газрын зүгээс төрөл бүрийн ажил санаачилж, алдаж онож, туршлага хуримтлуулсаар явна.

Цэнхэрмандал сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор “Орон нутгийн хөгжлийн санг зарцуулах журам” баталсны дагуу санал авах, эрэмбэлэх, ажил сонгох, тендер шалгаруулах, худалдан авах, хянах ажлуудыг гүйцэтгэж байна.

Энэ журмын дагуу орон нутгийн хөгжлийн сангаар гүйцэтгэсэн 11 ажилд иргэдийн сэтгэгдлийг судлахад оролцсон сумын 322 иргэний 37 хувь нь сэтгэл хангалуун, 25 хувь нь дунд зэрэг, 16 хувь нь хангалтгүй, үлдсэн хувь нь мэдэхгүй гэжээ. Тус судалгааны дүнд сумын тамгын газар энэ ажлыг цаашид хэрхэн сайжруулах чиглэлээр олон санаа олж авчээ.

Жижиг гэлтгүй асуудлыг шийдэх, яаж ажиллах арга эвээ олох нь хамгаас чухал байдаг.

Нэг удаагийн туршлагаас сургамж авч, бусдаас суралцах, ажлаа сайжруулахын төлөө эрэл хайгуул хийх нь ажлаа сайжруулахын эх үндэс болдог

Иргэдийн оролцоонд суурилсан санал авах процесс

- 1. Багийн засаг дарга орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хэрэгжүүлэх дарааллын талаар багийн иргэдийн нийтийн хурал хийж нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэн иргэдийн саналыг сонсож, гаргасан саналуудыг багцлан саналын хуудас тарааж тухайн гаргасан саналууд дээр гар өргүүлэн эрэмбэлж хурлын тэмдэглэл хөтөлж, тогтоол гаргасан.*
- 2. Багийн засаг дарга багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолыг сумын засаг даргын тамгын газарт хүргүүлж, ажлын хэсэг бүх багаас ирүүлсэн саналуудыг олонхийн саналаар эрэмбэлж багцалсан.*
- 3. Ажлын хэсгийн эрэмбэлсэн саналуудыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан дүн шинжилгээ хийж зураг төсөл, төсвийн урьдчилсан тооцоог гарган сумын иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж баталсан.*

2013 оны 4 сарын 3-ны өдрийн Цэнхэрмандал сумын ЗДТГ-ын 4-р тогтоолоос

Сумын тамгын газарт иргэдийн оролцоог бий болгож дэмжих, ашиглах, шинэ арга барилын тухай мэдлэг туршлага дутмагаас арга барилын ялгаа, эвээ олоогүй байдал их нөлөөлж байна.

АЗ сертификаттай хүн маш цөөн байснаас эхний жил бүх тендерт нэг л хүнийг оролцуулж байсан нь шүүмжлэл маргаан ихсэх, ард иргэдэд буруу ойлголт төрүүлэхэд хүргэх, үл ойлгоцол үүсгэж, тухайн хүндээ ч ажлын ачаалал, дарамт ихтэйзэрэг хүндрэлүүдийг дагуулж байв. Иймд сумын удирдлага ажиллах хүчээ чадавхижуулах, тендерт оролцох эрхтэй олон хүнтэй болох нь энэ бүх эрсдэлээс зайлсхийхэд тусалж

болохыг ойлгож, иргэдээ АЗ сертификатын сургалтад хамруулж, хүнээ бэлтгэх чиглэлээр эрчимтэй ажиллаж эхэлсэн байна. Ингэснээр иргэдийн оролцоо нэмэгдэж, ажлын ачаалал багасах болсон бөгөөд, иргэдээс тендертэй холбоотой санал гомдол гарах нь багасахын зэрэгцээиргэдийн хяналт тавих тогтолцоо ч сайжирч эхэлжээ.

Сумын удирдлага санал авах процессыг зөв зохион байгуулахыг чухалчилж байна. Эрэмблэх ажлыг зөв зохион байгуулаагүйгээс эрэмбэлж чадаагүй асуудал тулгардаг. Иргэдээс саналын хуудсаар санал авахад тодорхой санал бичдэггүй тул багийн иргэдийн нийтийн хурал дээр гаргасан нийтлэг саналуудыг гар өргүүлж санал авах болсон. Энэ үед 8 ажлыг санал болгосон бол бүгд энэ ажлуудыг 100 хувийн саналаар дэмжигдээд гараад ирдэг нь цаашид эдгээр ажлуудыг эрэмбэлэхэд хүндрэл учруулдаг аж.

Иргэдийн оролцооны тэнцвэрт байдлыг хангахын тулд багийн дарга нар иргэдийн саналыг хуудас бөглүүлэн авахаар хязгаарлалгүйгээр аль болох багийн иргэдийн нийтийн хурлаар нээлттэй хэлэлцүүлэхийг эрхэмлэх болсон байна.

Ингэж нээлттэй хэлэлцүүлгээс иргэдийн саналыг нэгтгэн, аль болох олон нийтийг хамарсан, нийгэм, эдийн засгийн хөгжилд түлхэц болох саналуудыг эрэмбэлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдүүлсэний нэг нь багийн эмчийн байр бариулсан ажил байлаа.

Иргэдэд анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийж иргэдээ эрүүлжүүлэх, амь насыг нь хамгаалах үүрэг хүлээн ажиллах багийн эмч тохилог тухтай орчинд ажил үйлчилгээгээ явуулах болсон нь заавал их хөрөнгөөр том эмнэлэг байгуулахыг хүлээх биш жижиг зүйлээс ажлыг эхэлж болохыг харуулж байна.

Сумын иргэдийн оролцоо муу байгаагийн нэг шалтгаан бол иргэд орон нутгийн хөгжлийн сангийн тухай бүрэн мэдээлэлгүйн улмаас яг яаж оролцох, ямар зүйлийг анхаарч, юунд саналаа өгөхөө мэдэхгүй, хөдөөгийн малчин иргэд хот айлын мэдээлэл сайтай эсвэл хуралд оролцсон хүнээс ам дамжиж мэдээлэл авдаг зэргээс үүдэн мэдээлэл, ойлголт хоёр зөрдөг бэрхшээлээс үүдэлтэй ажээ. Энэ бэрхшээлийг арилгахаар сумын удирдлагаас дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.

Үүнд:

- ✓ Багийн дарга нар иргэддээ мэдээлэл тараах зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг хийх,
- ✓ Саналын хуудсанд засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад чухал ажлуудыг жагсаагаад түүн дээрээ санал авах, нэмэлт саналуудыг нөхөж бичих талбар үлдээх,
- ✓ Засаг даргын тамгын газар жижиг тайлан бэлтгэж улиралд нэг удаа бүх өрхүүдээр үнэгүй тараах,
- ✓ Хийхээр төлөвлөж байгаа ажлын тухай танилцуулах,
- ✓ Хот айл болгонд байдаг идэвхтэй иргэдээс сайн дурын мэдээлэл дамжуулагч томилж мэдээлэл түгээх зэрэг болно.

Сумын хөгжлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, шинэ тутам бий болсон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зүй зохистой зарцуулахад иргэдийг оролцуулах ажилд олон саад бэрхшээл, сорилт тулгарч байгаа хэдий ч Цэнхэрмандалчууд даваад гарах санал, санаачилга бүрийг дэмжиж, болохоос болохгүйг хүртэл туршиж үзэн алдаанаас сургамж, ололтоос туршлага хуримтлуулж явна.

Сумын хүн амын тоо 2010 онд 1440 байсан бол 2013 онд 1780 болж эрчимтэй өссөн, 2009 оноос төрөлт 2 дахин нэмэгдсэн, 2013 онд нас баралт 7-н тохиолдлоор буурсан зэрэг статистик үзүүлэлт нь “Хүнтэй байвал хөгжил ирдэг” зах зээлийн зарчимд нийцэж хөгжин дэвжихийн эхлэл гэж үзэх бүрэн үндэстэй юм.

ХӨДӨӨГИЙН МАЛЧИД, СУМЫН ТӨВИЙН ИРГЭДИЙН ХҮСЭЛ СОНИРХОЛЫГ УУЛЗУУЛАХЫГ ЗОРЬСОН НЬ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМ

Нэгэнт мөрийн хөтөлбөр дэвшүүлж, сонгогдсон сумын удирдлагууд өөрсдийн мөрийн хөтөлбөрт, мөн сумын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөнд туссан ажлыг төсвийн хөрөнгөөр санхүүжиж байгаа хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын жагсаалтад оруулах сонирхолтой байх нь мэдээжийн хэрэг юм. Нөгөө талаас нь авч үзвэл, сумын иргэд юуг хамгийн хэрэгцээтэй гэж үзэх, чухалчлахаа өөрсдөө шийднэ. Энэ нь заавал Засаг даргын хөтөлбөр, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй давхцах албагүй.

Орон нутгаа хөгжүүлэх, эдийн засгийн чадавхитай болгох, иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн аль аль нь чухал ач холбогдолтой. Чухам үүнийг яаж хослуулах, аль алиныг нь шийдэх вэ гэдэг л хамгийн гол асуудал юм.

Энэ хоёр ялгаатай сонирхлыг уялдуулах, нэг зүгт чиглүүлэх нь сумын удирдлагын урд тулгардаг чангахан сорилтын нэг билээ. “Ард иргэдийнхээ саналыг дагаж тэдний амьдралд тулгараад байгаа

өдөр тутмын бэрхшээлүүдийг шийдээд явах уу?”, эсвэл “Олдож байгаа хэдэн төгрөгөөр ажлын байр бий болгож, хүмүүсийн амьжиргааг дэмжих томоохон биш юмаа гэхэд хэрдээ таарсан ажил хийх үү?” гэдэг асуудал аль ч сумын удирдлагын хувьд толгойны өвчин болж байна.

Нэгэнт боловсруулсан хөгжлийн төлөвлөгөө хөтөлбөр нь сайжруулах боломжгүй, хугацаа нь дуустал ягштал мөрдөх хууль бас биш билээ. Орчин нөхцөл өөрчлөгдөж, шинэ боломжууд нээгдэн өдрөөс өдөрт нийгмийн хүлээлт, шаардлага өөрчлөгдөж байгаа үед хөгжье л гэвэл төлөвлөгөөгөө байнга сайжруулан шинэчлэх шаардлага зүй ёсных юм.

Зарим тохиолдолд сумын хөгжлийн хөтөлбөр, засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан асуудлууд цаг үеэ өнгөрөөж, иргэдийн хувьд ач холбогдолтой байхаа болих нь ч бий. Энэ нь байгаль цаг уурын нөхцөл, дэд бүтэц, иргэдийн хүсэл сонирхол дахь өөрчлөлт гэхчлэн олон зүйлээс шалтгаалж болно.

Төлөвлөгөөгүйгээр ажиллах нь үр дүнд хүргэхгүйгээс гадна энэ нь заавал дагаж мөрдөх хууль биш.

Нэгэнт боловсруулсан төлөвлө-гөөний хэрэгжилтийг жил бүр хянаж, сайжруулах нь харин ажил хэрэгч, бодитой, илүү үр өгөөжтэй хандлага юм.

Энэ нь сайжруулна гэсэн үг болохоос муутгана, чадахгүй бол өөрчилнө гэсэн үг бас биш билээ.

гүйцэд цэгцтэй ойлголтод хүрэлгүйгээр баталсан бол иргэд шүүмжлэлтэй хандах нь мэдээжийн хэрэг юм. Хөгжлийн төлөвлөгөөнд иргэдийн саналыг тусгана гэдэг бол санал авах төдийхнөөр бүтчих ажил биш, харин нутаг орны онцлогт уялдуулж, цаашдын хөгжлийг авчрах, иргэдийн амьжиргаанд дэм болох шийдлүүдийг зөв олж тусгах хэрэгтэй болдог.

Хөгжих эсэх нь хөрөнгийг хэр зэрэг зөв зарцуулж, хийсэн ажлыг яаж хүлээж авахаас бас хамаардаг. Тендэр шалгаруулах, гэрээ хийхдээ л ажлын даалгавраа, ямар нөхцлөөр хүлээж авахаа тодорхой тусгах нь ажил гүйцэтгэгч, сумын захиргаа, иргэдийн аль алины нь ажлыг хөнгөвчлөн иргэдийн оролцоо хяналтыг боломжтой болгодог.

төлөвлөгөө хэрэгжих үндэс болдог. Хэлэхэд амар ч, хийхэд хэцүү л ажил.

Сум хөгжиж чадах эсэх нь хөрөнгийг хэр зэрэг зөв зарцуулж, хийсэн ажлыг яаж хүлээж авч байгаагаас бас хамаарна. Тендэр шалгаруулах, гэрээ хийхдээ л ажлын даалгавраа тодорхой өгөх, ямар нөхцлөөр хүлээж авахаа тодорхой болгох нь ажил гүйцэтгэгч, сумын захиргаа, иргэдийн аль алины нь хувьд тодорхой, ойлгомжтой болгож, иргэдийн оролцоо хяналтыг боломжтой болгоно гэсэн үг байдаг. Үүнийг хэр зэрэг хийж чадах, өөрөөр хэлбэл гүйцэтгэлийг хянаж, ажлаа чанартайгаар хийлгэж чадах эсэх нь мэдлэг, мэргэжил, цаг хугацаа, хичээл зүтгэл шаардсан ажил билээ.

Өдөр тутмын амьдралдаа тулгамдсан асуудлыг эхэлж шийдүүлэх иргэдийн хүсэл ч бас үүнд нөлөөлдөг.

Төлөвлөгөөнд ард иргэдийн саналыг гүйцэд тусгаж чадаагүй, эсвэл нийтээр сумынхаа хөгжлийн тухай

Үүний тулд “Сум яавал хөгжих вэ?” гэдгийг хэлэлцэн, нийтээр нэгдмэл ойлголттой болох, дараа нь нэгэнт баталсан төлөвлөгөөгөө иргэдэд сурталчлах, байнгын сэдэв болгох, явцаа үнэлж дүгнэх нь

*

*

*

Дэлгэрцогт сум олон улсын Мерси Кор Олон улсын байгууллага байгууллагын дэмжлэгтэйгээр сумын хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөгөө олон нийтийн оролцоонд тулгуурлан боловсруулж чаджээ³. Сумын удирдлагууд энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан төсөл хөтөлбөрүүдийг Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын жагсаалтад оруулан гүйцэтгэх сонирхолтой байдаг ч, сумын иргэд тэдгээр саналыг дэмжихгүй байгаагаас төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэх боломж мууддаг. Үүний шалтгаан нь нэгдүгээрт оршин суугчид сумын хөгжлийн төлөвлөгөө гэж сонссоноос өөр мэдлэг хомс, хоёрдугаарт тэд өдөр тутмын амьдралдаа тулгамдсан олон асуудлыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдүүлэх хүсэлтэй байдагтай холбоотой юм.

Зарим нэг саналуудыг нутаг усаараа, ах дүүсээрээ, ашиг хүртдэгээрээ шийдээд байх тохиолдол ч байна. Саналаар хийгдсэн ажлуудыг нэг хоёр хүн, бүлгээрээ өмчилж авчихаад нийтэд ашиглуулахгүй байх сөрөг хандлага ч гардаг байна.

Сумын удирдлага Д-тай ярилцсан ярилцлагын хэсгээс

Тус сумын удирдлагууд 2010 онд боловсруулсан “Нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2010-2021”⁴-ийг ягштал мөрдөх баримт бичиг биш гэдгийг мэдэх боловч үүнээс өөр алсыг харж, хүч хөдөлмөр гаргаж боловсруулсан сумын хөгжлийн чиг баримжаа болгочих зүйл

³ Сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад сумын засаг даргын орлогчоор удирдуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг болон 18 хүний бүрэлдэхүүнтэй төлөвлөлт хяналтын хороо ажилласан байна. Төлөвлөлт, хяналтын хороонд сумын ИТХ-ын дарга, сумын засаг дарга, нийгэм халамжийн мэргэжилтэн, төрийн сангийн төлөөлөгч, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, соёлын төвийн эрхлэгч, хүн эмнэлэгийн дарга, станцын техникч, 1-р багийн засаг дарга, сумын ахмадын хорооны дарга, залуучуудын холбооны тэргүүлэгч зэрэг хүмүүс багтжээ.

⁴ Сумын хөгжлийн төлөвлөгөө анх бий болсон тэдний түүх анхаарал татна. Төлөвлөгөө боловсруулж байх 2010 онд Орон нутгийн хөгжлийн сангаар байсангүй. Сумын удирдлагууд орон нутагтаа хандсан ажил, үйлчилгээ эхлүүлэх хөрөнгө санхүүгийн боломж байгаагүй тул нутгаас төрсөн бизнесмен, аж ахуйн нэгж, гадаад дотоодын байгууллагуудаас туслалцаа хүсэн, тэдний хандиваар бага сага бүтээн байгуулалтын ажил хийдэг байжээ. Хэдийгээр сумын нэрийн өмнөөс хүсэлт гаргаж байгаа ч сумын удирдлагуудад ингэж бадар барьж явах нь хүсэх зүйл биш байсан нь ойлгомжтой. Харин сумын хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулчихаад түүнээгээ үзүүлээд явахад тэдний ажлыг хөнгөвчлөх нь магадтай байсан тул сумын удирдлагуудад уг баримт бичгийг боловсруулах санаа анх төржээ.

тэдэнд одоогоор алга байна. Түүнчлэн сумын засаг дарга ард иргэддээ амласан мөрийн хөтөлбөрөө орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан хийсэн байна. Иймд үүрэг амлалтаа биелүүлэхийн тулд хөгжлийн төлөвлөгөөгөө мөрдөж ажиллах нь түүний хувьд чухал гэдэг нь тодорхой юм.

Дэлгэрцогт сум 2013 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 11 бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлснээс сумын хөгжлийн төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 төслийн 5 ажлыг хийж дуусгажээ. Энэ нь сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2010-2021-д туссан нийт төслийн (116 төсөл) 4.3 хувь болж байгаа юм. Энэ онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 9 бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэхээр шийдсэнээс 4 төслийн 4 ажил нь сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил байна.

Хэдийгээр сумын удирдлагууд хөгжлийн төлөвлөгөөгөө барьж ажиллахыг зорьж байгаа боловч орон нутагт хийгдэж байгаа ихэнх ажлууд иргэдээс гарсан төлөвлөгөөнд тусгагдаагүй саналыг дагаж байна.

Олон хүний хүч хөдөлмөр шингэсэн хөгжлийн төлөвлөгөөгөө сумын иргэд дорвитой дэмжихгүй байгаа нь энэ төлөвлөгөөгөөр иргэдэд бүрэн хүрч чадаагүй эсвэл 5 жилийн өмнө боловсруулсан төлөвлөгөө нь цаг үедээ нийцэхгүй, нэмэлт тодотгол оруулах цаг болсонтой холбоотой байж болох юм. Гэвч сумын иргэдээс гарч байгаа саналууд ихэвчлэн бэлчээрийн газар хаших, худаг ус гаргах, сургууль, цэцэрлэгийн хашаа хороо тохижуулах гээд чамгүй хэдэн төгрөг зарцуулж хийх атлаа түүнээс ашиг тусыг нь хүртэх өрх гэр, хүмүүсийн тоо чамлахаар ажлууд байх нь олонтаа тохиолдоно.

Харин хөдөөгийн малчдын хувьд эдгээр худаг ус гаргах, бэлчээр хаших зэрэг ажлууд нь тэдний өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай чухал асуудлууд байдаг байна.

“Ард иргэдийнхээ саналыг дагаж, тэдний амьдралд тулгараад байгаа өдөр тутмын бэрхшээлүүдийг шийдээд явах уу”, эсвэл “Олдож байгаа энэ хэдэн төгрөгөөр ажлын байр бий болгож, хүмүүсийн амьжиргааг дэмжих ажил хийх үү” гэдэг асуудал энэ сумын удирдлагуудын ёстой л толгойны өвчин болжээ.

Хэдийгээр тулгарсан сорилт бэрхшээл цөөнгүй ч гэлээ боломжийнхоо хэмжээнд шийдээд явж байгаа жижигхэн ч гэсэн тов хийсэн энэ сум руу Улаанбаатар хотоос чанх урагшаа 230 км хатуу хучилттай хар замаар яваад л хүрнэ.

Бага газрын чулуу, Тахилгатын агуй, Хадан сүм зэрэг байгалийн үзэсгэлэнт тогтоц, дурсгалыг хадгалдаг энэ сум 1500 гаруйхан хүн амтай боловч тэдний дундаас төрсөн алдартнууд их. Түүхч, гүн ухаантан, шашин соёлын нэрт зүтгэлтэн Зава Дамдин, төрийн хошой шагналт ардын жүжигчин Билэгийн Дамдинсүрэн, ардын хувьсгалын партизан М.Дорждэрэм, Д.Чимэд, Монгол улсын гавьяат багш Ч.Ишдорж гээд олон арван алдар цуутнууд энэ сумаас төрөн гарчээ (Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГ, 2010).

Дэлгэрцогт суманд малчид голдуу аж төрдөг. Нийт өрхийн 70 илүү хувийг бүрдүүлэх малчдын хувьд амьжиргааны гол эх үүсвэр нь малаас гарах сүү цагаан идээ, түүхий эд юм. Ингэний хоормог, гүүний айраг гээд Дундговийн цагаан идээ улсдаа л алдартайг бид мэднэ. Эдгээр брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдийн төлөөлөл уг сум төсвийнхөө 97 орчим хувийг мал аж ахуйн бүтээгдэхүүнээс бий болгосон орлогоор бүрдүүлдэг гэхээр энд мал аж ахуй хичнээн чухал болох нь харагдаж байна.

Говь нутагт цаг агаар улам бүр хуурайшиж, шороо шуурга тавих нь жилээс жилд нэмэгдсээр байгаа боловч энэ жил Дэлгэрцогт суманд өнтэй сайхан хавар болж өнгөрчээ. Энэ хавар сумын хэмжээнд нийт 31 мянган төл хүлээн авсанаар эднийх 110 гаруй мянган малтай болсон сайхан мэдээтэй байна. Мал сүрэг өсөн нэмэгдэхийн хэрээр сумын иргэдийн амьдрал сайжрах боловч нөгөө талдаа бэлчээрийн даац хэтэрч, байгаль орчин доройтжээ. Энэ нь малын үүлдэр угсааг сайжруулж, нэг малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэн цөөн тооны, ашиг шим өндөртэй малыг бодлогоор үржүүлэх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.

Үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг томоохон аж ахуйн нэгж энэ суманд хараахан бий болж амжаагүй. Сургууль, цэцэрлэг, тамгын газраас бүрдсэн төсвийн 5 байгууллага, үүрэн телефоны 3 оператор, жижиг хэмжээний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 13 аж ахуйн нэгж, улирлын

чанартай үйл ажиллагаа явуулдаг жуулчны 2 бааз нь энэ сумын гол ажил олгогч байгууллагууд юм.

Сүүлийн жилүүдэд ган, зудын давтамж ойртож байгаа нь малчдын амьдралд ч сөргөөр нөлөөлөх болжээ. Иймд ард иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэх зорилгоор сумын удирдлагуудаас санаачлан сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан. Мал аж ахуй эрхлэн амьжиргаагаа залгуулдаг иргэдийнхээ орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, ажлын байр шинээр бий болгох нь чухал зорилт юм.

Дэлгэрцогт сум хөгжлийн төлөвлөгөөнийхөө хүрээнд доорх дөрвөн гол зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд (Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГ, 2010):

1. Нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүн амын эрүүл, боловсролтой, ажилтай байх нөхцлийг бүрдүүлэн хүний хөгжлийг хангах,
2. Орон нутгийн нөөц боломжид тулгуурласан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх,
3. Орон нутагт бизнесийн тогтвортой, эрүүл өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх,
4. Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж тэдний оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежментийг сайжруулж, хөрс, ургамал, ан амьтныг хамгаалан цөлжилтийг сааруулан экологийн тэнцвэрт байдлыг хадгалах.

Эдгээр зорилгын хүрээнд 2010 - 2021 оны хооронд нийт 116 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба нэгдүгээр зорилгын хүрээнд 9 хөтөлбөрийн 35 төсөл, хоёрдугаар зорилгын хүрээнд 13 хөтөлбөрийн 36 төсөл, гуравдугаар зорилгын хүрээнд 7 хөтөлбөрийн 28 төсөл, дөрөвдүгээр зорилгын хүрээнд 5 хөтөлбөрийн 17 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Өнөөдрийн байдлаар уг төлөвлөгөөнд туссан 20 орчим ажил хэрэгжээд

байгаа. Хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн ажилласан энэ гурван жилийн хугацаанд Дэлгэрцогт сум олон сорилтуудтай тулгарч онож, алдаж байсныг доорх гурван сэдвийн хүрээнд хүргье.

ИРГЭДЭД ХИЙХ АЖИЛ, ТӨЛӨВЛӨСӨН ИРЭЭДҮЙН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГЭХ НЬ АМАРГҮЙ АЖИЛ

Говь нутагт бэлчээрийн даац сул, ургацын гаралт бага байдаг тул малчид гурван багийн 250 мянган га газарт тархан нутаглана. Иймд багийн хурал зохион байгуулах, малчдад мэдээлэл хүргэх гэдэг төсөв хөрөнгө багатай багийн дарга нарын хувьд хэцүүхэн даваа бололтой. Нэг багийн дарга сард ердөө 16 литр шатахууны нормтой гэж бодохоор ямар хэмжээний төсөв хөрөнгөөр ажлаа амжуулах шаардлагатай байдаг нь харагдана. Багийн дарга нэг удаад багийнхаа нутаг дэвсгэрийг тойрч иргэдтэйгээ уулзахад дунджаар 400 км замын мотоциклоор туулдаг байна.

Тус сумын удирдлагууд сумын хөгжлийн төлөвлөгөөгөө ард иргэддээ танилцуулахын тулд “Малчин Эмэгтэйчүүдийн Чуулга Уулзалт”-ыг зохион байгуулж байжээ. Чуулганы үеэр хөгжлийн төлөвлөгөөгөө танилцуулж, хүрэлцэн ирсэн өрх бүрт төлөвлөгөөний хэвлэмэл хувилбарыг (ном)⁵ тараан өгчээ. Уг чуулганыг “малчин эмэгтэйчүүдийн” гэж зүгээр ч нэг нэрлээгүй. Монгол орны хот, хөдөөгийн хаана ч ялгаагүй эмэгтэйчүүдийн байр суурь (шийдвэр гаргах) өндөр, олон нийтийн ажилд эрчүүдээс илүү идэвхтэй оролцдогийг бодолцон энэ нэрийг сонгожээ. Түүнчлэн хуучин нэгдлийн үед малчин эмэгтэйчүүд өвөлд нэг удаа уулздаг байсан уламжлал сэргэсэнд сумын эмэгтэйчүүд таатай хандаж, өндөр ирцтэйгээр цугласан байна.

Улиралд нэг удаа болох багийн иргэдийн хурлаар багийн дарга нар

⁵ А5 -аар хэвлэгдсэн энэ ном өнгө үзэмж сайтай, авсаархан ном боловч сумын иргэд уншиж сонирхоогүй бололтой. Сумын хөгжлийн талаар Дэлгэрцогт сумын залуучууд анхаардаггүй юм уу, эсвэл тарааж өгсөн номыг нээж харах зав зай байсангүй юу ямартаа ч энэ талаар асуусан бидний асуултад хариулах хүн цөөхөн таарч байв. Магадгүй номоос илүүтэйгээр хөгжлийн төлөвлөгөөгөө сурталчилсан, уншихад хялбар, ганц хоёр хуудсанд багтаасан тараах материал илүү үр дүнтэй байж болох юм.

иргэддээ мэдээлэл өгөх үүрэгтэй боловч хөдөөгийн малчид зав чөлөө муутай, сумын төвөөс хол амьдардаг тул тэр бүр хуралд суудаггүй. Иймд тэдэнд мэдээлэл түгээх зорилгоор багийн дарга нар айлуудаар орж уулзалт хийнэ. Ингэж уулзах нь мэдээлэл түгээхээс гадна малчдынхаа амьдрал ахуйтай танилцах, санаа бодлыг нь сонсох гээд олон сайн талтай. Гэвч бензин шатахуун багатай багийн дарга нар бүх айлаар орох боломжгүй тул зарим айлыг алгасдаг байна. Харин багийн даргаа яваад өнгөрснийг сонссон нэг нь бага зэрэг гомддог бололтой, “манайд багийн дарга ямар тоож ирэх биш” гэж үг хаяна.

Зуны улиралд багийн дарга нар хол нутагладаг малчиддаа зориулж, тэдэнд ойр, тусад нь багийн хурал зохиодог болсон нь нүдээ олсон шийдэл болж чаджээ. Энэ хурлуудад малчдын ирц өндөр байж, оролцоо идэвх сайн байдаг.

Дэлгэрцогт суманд зөвхөн багийн дарга нар л иргэдээ мэдээлэлжүүлэх ажлыг хийдэг гэж ойлгож болохгүй юм. Сумын захиргаанаас иргэддээ мэдээлэл түгээхийн тулд төрийн байгууллагын албан хаагчдын нөөц боломжийг давхар ашиглаж байна. Тухайлбал, багийн эмч нар өвчтөнүүд, жирэмсэн эхчүүд, нялх нярай хүүхдүүдээ эргэж очих гээд хөдөөгүүр явах ажил мундахгүй тул тэд ч бас сумын төвд болсон үйл явдлыг малчдад сонин болгон ярьж, зарим мэдээллийг сумын удирдлагуудын зааварчлагаатайгаар хүргэдэг байна.

Иргэдэд мэдээлэл түгээхэд тулгардаг хамгийн түгээмэл бэрхшээл бол иргэдийн идэвхигүй оролцоо. Энэ байдал сумын төвд ч тэр, хөдөө орон нутагт ч ялгаагүй адил байдаг тул иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд баг, сумын засаг дарга нар хэрэндээ л хичээцгээж байгаа боловч үр дүнтэй ямар алхам хийхээ сайн мэдэхгүй байгаа нь тэдний ярианаас харагдаж байлаа. Учир нь иргэд өөрсөддөө ашигтай зүйл дээр идэвхитэй оролцоод бусад үед ирдэггүй байна. Тухайлбал үнэгүй өвс тараахад сумын иргэд бүгд ирсэн атлаа тамхины тухай хэлэлцүүлэгт цөөн тооны хүмүүс л ирж байжээ.

“2008 онд үнэгүй өвс тараасан. Тэгэхэд бүгд ирээд зогссон байсан. Харин багийн хурал, иргэдийн нийтийн хурал болно гээд багийн дарга нар толгойтой болгонд хэлсэн байхад 10-20 хүн ирж байх жишээтэй. Тусламжийн будаа тараахад бас бүгд л ирээд зогсож байсан”.

Сумын удирдлага Д-тай ярилцсан ярилцлагын хэсгээс

Хүн өөртөө хэрэгтэй зүйлдээ хөдөлж бусад үед хойрго ханддаг юм хойно өөр яалтай ч билээ. Үүнийг мэдэрсэн сумын удирдлагууд ажиллах арга барилаа нөхцөл байдалтай уялдуулан өөрчилсөнд тодорхой ахиц гарсан байна. Тухайлбал, суманд байдаг төрийн байгууллагуудтай хамтран байгууллагын өдөрлөг зохион, иргэддээ мэдээлэл давхар өгч, саналын хуудсаар санал авчээ. Өдөрлөгийн хүрээнд аймгийн мэргэжлийн хяналтын газраас усны чанарын тухай хэлэлцүүлэг явуулж, мэдээлэл өгөхөд иргэд маш идэвхитэйгээр оролцсон байна. Мөн эмнэлгийн өдөрлөгөөр эмч нар иргэддээ төлбаргүй үзлэг хийж, цусны даралт, нүдний хараа зэргийг нь шалгах зэрэг анхан шатны эмнэлэгийн тусламж үзүүлсэн нь үр дүнтэй болжээ⁶.

Сумын удирдлагууд иргэдээ мэдээллээр хангахын тулд иргэдийн нийтийн хурал, багийн нийтийн хурлаас гадна сар бүрийн сүүлийн долоо хоногт иргэддээ мэдээлэл өгөх хурал зохион байгуулдаг гэнэ. Үүнээс гадна иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөж, олноор цугладаг газруудад нийт 5 ширхэг мэдээллийн самбар байршуулж тухай бүрт нь мэдээллээ шинэчлэл хийнэ. Ялангуяа хөдөө орон нутгаас малчид сумын төврүү ирэхдээ тамгын газраар дайрч аймаг орон нутгийн сонин дуулдаг тул сумын засаг даргын тамгын газрын урд байрлах мэдээллийн самбарыг байнга шинэчилж байх шаардлагатай. Хөдөөгийн малчид сум орон нутагт хийгдсэн ажлуудыг биеэр очиж үзэх бололцоо гардаггүй учир Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн

⁶ Ингэж иргэдээ (хөдөөгийн малчдаа) сумын төвийн аж амьдралтай танилцуулж, төр, төсвийн байгууллагын үйл ажиллагааг тэдэнд сурталчилж байх нь чухал ач холбогдолтой гэж сумын удирдлагууд үздэг юм байна. Учир нь хөдөөгийн малчин хүүхэд нь сургуульд сурдаггүй л бол сургууль, цэцэрлэгт тулгараад байгаа асуудлыг тэр бүр ойлгодоггүй гэнэ. Тиймээс сумын төвийн сургуулийн дотуур байр, цэцэрлэг, эмнэлэг зэрэг газруудаар малчдаа оруулж танилцуулга хийж байжээ. Малчид эдгээр байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, зохих мэдээлэл олж авсаны үр дүнд ОНХС-аар эдгээр байгууллагуудын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд саналаа өгөх сайн талтай юм байна.

ажлуудыг фото зургаар баримтжуулан гадаа самбарт өлгөсөн нь үр дүнтэй сурталчилгаа болж чаджээ.

Судалгааны үр дүнд сэтгэл дундуур байгаа бололтой сумын орлогч дарга “Бид одоо яах ёстой юм болоо? гэрээр нь ороод уулзаад явах хэрэгтэй юм болов уу? Би бүр гайхаад байна. Бид ажлын тайлангаа улирал, сар, долоо хоногоор нь гаргаад мэдээллийн самбаруудад байршуулдаг. Сар бүр хурал зохион байгуулахад хуралдаа ирдэггүй мөртлөө бидэнд мэдээлэл байхгүй гээд яриад байх юм” гэж ярилаа.

Сумын удирдлага Б-тэй ярилцсан ярилцлагын хэсгээс

Гэсэн хэдий ч сумын ард иргэд сумын хөгжлийн төлөвлөгөө болон Орон нутгийн хөгжлийн сангийн тухай ойлголт багатай байсаар байна. Саяхан аймгийн мэргэжлийн хяналтын газраас иргэдийн ОНХС-гийн тухай ойлголт хэр байгааг судалсан судалгаанд Дэлгэрцогт сумын иргэд мэдээлэл хомс байдаг гэсэн дүнтэй гарчээ.

Иргэдэд мэдээлэл түгээх арга зам учир дутагдалтай байгаа нь харагдсан болохоор өөр аргаар мэдээлэл хүргэх төлөвлөгөөтэй байгаа гэнэ. Зун цагт сумын иргэд оройн хоолны дараа ойролцоох толгод дээр гарч салхилж суудаг тул тэр үеэр сайхан дуу тавьж, иргэдтэйгээ ярилцах аятайхан уур амьсгал бүрдүүлээд энгийн яриа өрнүүлэхийн сацуу мэдээлэл өгөх төлөвлөгөөтэй байгаа. Хэсэг хугацааны дараа мэргэжлийн хяналтаас авсан өнөөх асуулгыг дахин авч хэр үр дүнтэй ажил болсон эсэхээ шалгаж үзэх ажээ.

Сүүлийн жилүүдэд хөдөөгийн айл өрхүүд Жи-мобайлын суурин утастай болсоноор хоорондоо үнэгүй бас чанартай сүлжээгээр ярих бололцоотой болсон нь сум, багийн дарга нарын ажлыг ихэд хөнгөвчилсөн байна. Багийн хурал, сум иргэдийн нийтийн хурлын товыг зарлахдаа ихэнх айлууд руу утсаар хэл дуулгах боломжтой болжээ. Зарим тохиолдолд тодорхой асуудлуудын тухай утсаар шууд мэдээллэнэ. Жи-мобайлын утасны сүлжээ ихэнх газруудад сайн барьдаг ч сүүлийн үед Ди Ди Ш-ийн кабелийн телевизийг айлууд ихээр суурилуулах болсноор утасны ярианы чанар муудсан байна. Зарим айлтай холбоо барихад хүндрэлтэй болсон тул багийн засаг дарга нар айлуудаа нэгтгэн хот айлын систем нэвтрүүлжээ. Өөрөөр хэлбэл тодорхой хэдэн айлын дунд нэг айл нь бусаддаа мэдээлэл тарааж

байх үүрэг хүлээсэн байна. Үүний үр дүнд мэдээлэл утсаар түгээх боломжгүй айлуудад ч багийн даргын үг хүрдэг болжээ.

СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ИРГЭДИЙН ХҮСЭЛТ, ХЭРЭГЦЭЭГ УЯЛДУУЛАХ НЬ

Монгол орны бусад сумдын нэгэн адил Дэлгэрцогт суманд Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлыг ард иргэдийнхээ санал хүсэлтэд тулгуурлан хийдэг болоод жил гаруйханы хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Дэлгэрцогт сум гурван ч удаа иргэдийнхээ саналыг авч, хийх ажлынхаа төлөвлөгөөг гаргасан байдаг. Өнгөрсөн онд уг суманд Орон нутгийн хөгжлийн сангаар 239,940,900 төгрөг хуваарилагдсан бөгөөд энэ төсвөөр иргэдээсээ авсан санал дээр тулгуурлан сумын ундны усыг сайжруулах, халуун ус барих (2014 онд хийгдэхээр хойшлогдсон), сумын төвд ногоон төгөл бий болгох, сумын төвийн өвс тэжээлийн агуулахыг засварлах, цэнгэлдэх хүрээлэнгийн талбайг тохижуулах, ахуйн үйлчилгээний байрыг халаалтад холбох, иргэний танхим тохижуулах, малчдад хүлээн авагч тараах зэрэг нийт 11 бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлсэн байна.

2014 онд Дэлгэрцогт сум арван ширхэг энгийн худаг засварлах, есөнжилийн сургуулийн засвар, тохижилт хийх, сумын эмнэлэгт тоног төхөөрөмж худалдан авч өгөх, нийтийн халуун ус барих, худалдан авах ажиллагааны сургалт зохион байгуулах зэрэг нийт 9 ажлыг 388,523,590 төгрөгт багтаан хийхээр төлөвлөөд байна.

Иргэдээс санал авч Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжүүлэн бүтээн байгуулалтын ажил хийх болсон энэ туршлага ард иргэдийн хувьд ч аймаг, сумын удирдлагуудын хүрээнд ч шинэ тутам байгаа тул хаа хаанаа бодож үзэх, сайжруулах зүйлүүд их байгаа нь ойлгомжтой. Ялангуяа баг, сумын хурлуудад иргэдийн оролцоог идэвхижүүлнэ гэдэг Дэлгэрцогт сумын удирдлагуудад тулгамдаад байгаа шинэ сорилт билээ. Иргэдийн хувьд ч урд өмнө сум орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалттай холбоотой асуудалд шууд оролцоотойгоор саналаа өгч байсан туршлага хомс тул сум орон нутагт тулгараад байгаа асуудал гэхээсээ илүүтэйгээр өөрт тулгамдаад байгаа асуудлуудаа шийдүүлэх

сонирхол ихтэй байдаг байна.

Харин сумын удирдлагууд сум орон нутагтаа үлдэцтэй томоохон ажил хийчих юмсан гэж хүсдэг бололтой ард иргэдээс гарч байгаа саналууд хэтэрхий жижиг, тулга тойрсон асуудлууд байх юм гэж ундууцна. Хурал цуглаанд иргэдийн ирц сул, дэвшүүлж байгаа саналууд нь дорвитой зүйл биш байгаа нь хэтэрхий хавтгайруулж олгосон халамжийн бодлоготой шууд холбоотой гэж үзэх ч хүн байна.

Сумын иргэд нийтийг хамарсан ажилд их хойрго байгаа, Орон нутгийн хөгжлийн сангаар санал асуухад жижиг сажиг, тулга тойрсон юм яриад дорвитой сэтгэж чадахгүй байгаа зэрэг нь бидэнд тархины ядуурал нүүрлээд байгааг харуулж байна. Үүний үндсэн шалтгаан нь хэтэрхий хавтгайруулж олгосон төрийн халамжийн бодлого юм.

Сумын удирдлага Х-тэй ярилцсан ярилцлагын хэсгээс

Ялангуяа хүүхдийн мөнгө, хүнсний талон зэрэг төрөөс хэрэгжүүлж байгаа халамжийн бодлогод хамрагдсан айл өрхүүд нь ид хөдөлмөрийн насны залуучууд байдаг байна. Нэгэнт идэх хоол, унтах байр нь бэлэн тул тэдгээр залуус хөдөлмөр эрхлэх шаардлагагүй болж, улмаар хөдөлмөр эрхлэх сонирхол нь буурч, нийгмийн аливаа асуудалд идэвхигүй байр сууринаас хандах нь ихэсдэг гэж хэлсэн нь оргүй зүйл биш.

Ирээдүйд Орон нутгийн хөгжлийн сангаар танай орон нутагт зөндөө л ажлууд хийгдэх байх. Гэхдээ ямар ажил хийвэл хамгийн сайн бэ? Мэдэхгүй юм. Худаг ус, хороо хашаа, бэлчээр л байдаг байхдаа...

Дэлгэрцогт сумын малчинтай ярилцсан ярилцлагын хэсгээс

Өнгөрсөн 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн саналаар Дэлгэрцогт суманд 2 худаг шинээр гаргаж, 6 худаг зассан бол 2014 онд энэ санал дахин гарсан тул 12 худаг шинээр засахаар болсон байна. Хөдөөгийн айлууд бие биетэйгээ барьцан нэг айлын дэргэдэх худгийг засчихвал нөгөө айл нь худгаа засуулах гэдэг тул энэ жил нэг баг дээр л гэхэд 20 гаруй айл худаг засуулах санал өгчээ. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлыг ганц айл хувьдаа эзэмших нь зохисгүй нь ойлгомжтой юм. Өөрөөр хэлбэл иргэдийн

оролцоотойгоор төлөвлөхөд иргэдийн хэрэгцээ болон хийгдэх ажлын үр ашгийг уялдуулах шаардлагатай нэн чухал. Иргэдийн саналаар хийгдсэн ажил нь үнэхээр ашгаа өгч, олон нийтийн хэрэгцээг бүрэн хангаж чадах зүйл мөн үү гэдгийг анхаарч үзэх зайлшгүй шаардлага сумын удирдлагуудын өмнө тулгарсан байна.

Иргэдээс жижиг сажиг санал гарч байгааг тэдэнд мэдээлэл дутмаг байдагтай холбон тайлбарлах нэг хэсэг байхад, Орон нутгийн хөгжлийн сангаар өөрийн ажлыг амжуулах гэсэн зарим хүмүүсийн хувийн сонирхолтой холбон үзэх хүмүүс ч байсан юм. Орон нутгийн хөгжлийн сангийн тухай мэдээлэлтэй болсон тухайн баг хорооны овсгоотой, нэр хүндтэй иргэд эсвэл тодорхой нэг ажлыг авч, гүйцэтгэх сонирхолтой бүлэг хүмүүс нэгдээд бусад ойлголт багатай иргэдийг өөртөө ашигтай зүйлд санал өгөхийг ятгах, хүчлэх тохиолдлууд гардаг болсон байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн дүрэм, журмыг дахин сайжруулах шаардлага байгааг илтэсэн бас нэгэн тод жишээ юм.

Орон нутгийн хөгжлийн сангаар ирээдүйд хийгдэх ажлуудад ямар ажил ороосой гэж та бодож байна вэ? Манай суманд нэг ийм юм хэрэгтэй дээ гэсэн зүйл байна уу?

Халуун ус, цэвэр бохир усаа холбохвол уг нь их сайн байна. Мөн интернет. Микомын интернет аль дээрээс тавина гээд тавигдахгүй байгаа. Эдгээр зүйлүүд бүтчихвэл сум маань илүү хөгжих байх гэж бодож байна.

*Дэлгэрцөгт сумын есөн жилийн сургуулийн багштай
ярилцсан ярилцлагын хэсгээс*

Сумын иргэдийн 70 илүү хувь нь хөдөөгийн малчид байдаг тул иргэдийн санал ихэнхдээ хөдөө орон нутагруугаа чиглэдэг. Үүнээс үүдээд сумын төвийн асуудлууд тухайлбал ундны ус, гэрэлтүүлэг, тохижилт, хог цэвэрлэгээний асуудал орхигддог болжээ.

Энэ бүгдээс сургамж авсан нутгийн удирдлагууд иргэдээс (ихэнхдээ хөдөөгийн малчдаас) санал авахдаа сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлыг жагсаалтаар оруулан асуулгын хуудасны доод хэсэгт иргэдэд өөрсдийн саналаа бичих хоосон зай үлдээдэг болжээ. Үүний үр дүнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дорвитой томоохон зүйлд зарцуулах бололцоотой болж байна.

Дэлгэрцогт сумын удирдлагууд шинэ арга барилд дасан зохицох, иргэдийнхээ ухаалаг оролцоог хэрхэн нэмэгдүүлэх тухай хэрдээ л эрэл хайгуул хийсээр байна. Нэг талдаа ард иргэдийн амьжиргаатай холбоотой өдөр тутмын асуудал, нөгөө талдаа сумын хөгжлийн тулгарч буй сорилтуудыг нэг бодлогод зангидах гэдэг амаргүй ажил бизээ. Ямартай ч тэд “Суманд хийгдэж байгаа ажлуудад иргэдийнхээ саналыг тусгаад байх хэрэгтэй. Санал нь тусаад, хийгдээд байвал иргэдийн оролцоо хүссэн хүсээгүй нэмэгдэнэ. Ядаж л хуралдаа очоод саналаа хэлчих юмсан гээд ирэх болно” гэж ярьсан юм.

Сумандаа дорвитой зүйл бүтээх нь бидэнд ашигтай гэдгийг иргэддээ ойлгуулах л хэрэгтэй байна. Өнөөг хүртэл ийм жижиг сажиг юм хийсээр ирлээ, одоо бид далайцтай зүйлд хөрөнгө оруулах хэрэгтэй. Томхон зүйл бүтээж байж л үүнээс гарах үр өгөөж нь өндөр байна гэж ойлгуулах нь чухал байна.

Сумын удирдлага Х-тэй ярилцсан ярилцлагын хэсгээс

Иргэдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан нөлөөлөх нь илүү үр дүнтэй гэж сумын удирдлагууд үздэг тул тэдний үйл ажиллагааг боломжийнхоо хүрээнд дэмжих болжээ. Тухайлбал, залуучуудын нийгмийн идэвхийг сайжруулах зорилгоор “Орон нутгийн хөгжилд залуучууд бидний оролцоо” сэдэвт чуулга уулзалт зохион байгуулсан нь амжилттай болж өндөрлөсөн байна. Залуучуудын холбоог дэмжиж Аймгийн Засаг Даргын Тамгийн газраас үйл ажиллагаа явуулах байр гаргаж өгчээ.

Дэлгэрцогт сум “Орон нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог идэвхижүүлэх нь” сэдвийн доор Швейцарийн Хөгжлийн Ангентлаг, Азийн Хөгжлийн Сангаас хэрэгжүүлж байгаа төсөлд хамрагдсан анхны 6 сумын нэг болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд олон арга хэмжээ зохиогдсоны нэг нь “2015 онд Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэхээр төлөвлөгдсөн ажлууд сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байдал” сэдэвт хэлэлцүүлэг сумын ард иргэдийн дунд явуулжээ. Хэлэлцүүлэгт гурван багийн 40 гаруй иргэд оролцсон бөгөөд оролцсон нийт хүмүүсийг багуудад хуваан хөгжлийн төлөвлөгөө болон Орон

нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа хэрхэн уялдаж байгаа тухай өөрсдөөр нь хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна⁷. Хэлэлцүүлгийн эхэнд сургагч багш нар Орон нутгийн хөгжлийн сангийн тухай зөв ойлголт өгөхийн тулд сумын иргэдээс Орон нутгийн хөгжлийн сангэж юу вэ? гэсэн асуулт тавьж Орон нутгийн хөгжлийн сангийн үндсэн зорилго, зарчмуудыг өөрсдөөр нь бичүүлж авсан нь шинэлэг бөгөөд сургажтай зүйл болсон байна.

ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ ОРОЛДЛОГО БҮХЭН ТУРШЛАГА БОЛОХ НЬ

Орон нутгийн хөгжлийн санболон бусад санхүүжилтийн эх үүсвэрээр орон нутагт зөв, санаачилгатай ажлууд олноор хийгдэж байгаа боловч тухайн ажлын гүйцэтгэлийг хангалттай хэмжээнд хянаж чадахгүй байгаагаас хийгдсэн ажлууд чанаргүй, шаардлага хангахгүй байх тохиолдол цөөнгүй байдаг гэнэ. Энэ нь цаашлаад иргэдийн дунд сумын удирдлагуудын нэр хүнд унах, хөрөнгө мөнгө үргүй зарцуулсан, мөнгө идэж уусан гэх яриа үүсэхэд хүргэдэг нэг томоохон шалтгаан болдог байна. Дэлгэрцогт сум төлөвлөсөн ажлынхаа гүйцэтгэлийг хянахдаа Дундговь аймгийн засаг даргын баталсан жишиг болон өөрсдийн боловсруулсан зөвлөмжөө дагадаг.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлуудыг хүлээж авах хамгийн чухал үзүүлэлт бол тухайн ажлууд зураг төсөвтэйгөө таарч байгаа эсэх гэнэ. Тухайн бараа үйлчилгээг аль байгууллагад бүртгүүлэхээс хамаараад байгууллагын дарга, нярав, харьяа нутаг дэвсгэрийн багийн засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч, зарцуулалт хийж байгаа өмч хариуцсан зөвлөлийн дарга, тухайн багийн 2 иргэн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр бараа үйлчилгээг хүлээн авдаг байна.

⁷ Энэ хүрээнд 2015 онд ОНХС-аар хийгдэхээр төлөвлөгдсөн бүх ажлуудыг СХТ-нд тусгагдсан зорилтуудын дагуу сумын иргэдээр хувиарлалт хийлгэжээ. Инэхэдээ том цаасан дээр СХТ-нд тусгагдсан зорилтуудыг бичээд уг зорилтуудтай уялдах ОНХС-аар хийгдэхээр тусгагдсан ажлуудыг доор нь жагсаан бичсэн байна. Хэлэлцүүлгийн үр дүнд 2015 онд иргэдээс санал авч ОНХС-аар хийгдэхээр төлөвлөгдсөн ажлууд СХТ-тэй уялдаж байна гэсэн үр дүн гарчээ.

Эхний ажлуудыг хүлээж авах үед туршлага дутсанаас алдаж онох зүйл байсан гэдгээ сумын удирдлагууд нуусангүй. Алдсан алдаагаа дахин давтахгүйн тулд хийгдсэн ажлуудыг хүлээж авахдаа хүлээн авах комиссын бүх гишүүд тухайн ажилтай холбоотойгоор санал, шүүмжээ бичгээр давхар өгдөг болжээ. Мөн ард иргэдэд саналын хуудас тарааж, уг ажлыг хэрхэн дүгнэж байгаа, юу нь сайн болсон, юу нь муу болсон тухай бичүүлж авдаг болсон байна. Энэ нь хийгдэж байгаа ажлуудын чанар сайжирах байх гэсэн итгэлийг төрүүлэх болжээ.

Бараа үйлчилгээ хүлээн авахтай холбоотой Дэлгэрцогт сумын туршлага цөөнгүй бий. Тухайлбал 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худаг сэргээн засварлахдаа “Ямар худгийг сэргээн засвар хийсэн худаг гэх вэ?” гэдэг үндсэн шаардлагыг тавьж өгөөгүйгээс зарим дутагдлууд гарсан байна. “Лайдаад орхисон худгийг сэргээн засварласан гэх үү?”, “Өрлөг хийгээд худгаа цэвэрхэн үзэмжтэй болгосныг хэлэх үү?”, бүр эсвэл “Шинэ ховоо, онгоц тавьчихсан худгийг шинээр зассан худаг гэх юм уу?”. Үүнийг ажлын шаардлагад эхнээс нь нарийвчлан тодорхой тусгах нь илүү өгөөжтэйг тэд туршлагаасаа ойлгожээ.

Энэ жил Дэлгэрцогт сум 12 худаг засварлахаар төсөвлөсөн байна. Нэг багийн нутаг дэвсгэрт 3-4 худаг сэргээн засварлах ба нэгж бүрийн өртөг 2 сая төгрөгөөс хэтрэхгүй байх үндсэн шаардлагыг тавьжээ. Түүнчлэн сэргээн засварлах худгаа сонгохдоо аль болох олон айл өрх ашигладаг, олон нийтэд ашиг тусаа өгөхүйц худгуудыг сонгожээ. Өнгөрсөн жилийн сургамжид тулгуурлан энэ жил засвар хийгдэх бүх худгуудад нэг бүрийн онцлогыг тусгасан төсөл бичүүлж авсан нь хийсэн ажлынх нь хэмжээнд тааруулж төсөв олгох боломжийг олгосон байна.

Худаг сэргээн засварлах энэ ажлыг олон нийтийн оролцоотой бүлгүүдээр хийлгэх ба эдгээр бүлгүүд нь тухайн худгийн ойр орчимд амьдардаг айл өрхүүдээс бүрдэх ажээ. Тэдгээр хүмүүс өөрсдийн хэрэгцээнд худгаа засварлаж байгаа тул аль болох чанартай хийх сонирхолтой байсан нь гүйцэтгэлийг хянахад сумын удирдлагуудад илүү дөхөмтэй болжээ. Ер нь тухайн орон нутгийнхаа уугуул иргэдээр хийлгэсэн ажил буцах эзэнтэй, буух хаягтай байдаг тул чанарын

хувьд илүү сайн болдог гэнэ. Харин 20 сая төгрөгнөөс дээш өртөгтэй ажил, үйлчилгээгэдны компани гүйцэтгэдэг. Гадны компаниуд тухайн байгууламжийг барьчихаад л яваад өгдөг тул дараа нь нэмэлт засвар үйлчилгээ хийлгэх, чанаргүй хийсэн ажлыг нь засуулах гэхээр ирдэггүй, зарим нь бүр эргээд олддоггүй.

Энэ мэтчилэн Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлуудтай холбоотойгоор бодож үзэх асуудлууд олон байдаг бололтой. Ялангуяа хийгдэхээр төлөвлөгөдсөн ажлууд болон иргэдийн хүлээлт, төсөөллийг анхнаас нь зангидаж өгөх нь их чухал байдаг. Тухайлбал, сумын төвд халуун усны газар барихаар иргэд санал өгөхдөө маш сайхан зүйл дотроо төсөөлдөг гэнэ. Хоёр давхар барилгатай, нарны энергээр цахилгаанаа хангадаг, олон хүнд нэгэн зэрэг үйлчлэх боломжтой, дотор тохижилт нь хамгийн сүүлийн үеийн чанарын шаардлага хангасан гэх мэт. Гэвч санал өгсөн иргэдийн төсөөллийг (хүсэлт) зураг төсөв хийхдээ тусгаж чаддаггүйгээс болоод хүмүүсийн хүлээлт болон бодит байдал хоёр зөрдөг байна. Зураг төсвийн компаниар хийлгэсэн зураг нь энгийн нэг халуун усны газрын зураг байдаг тул түүний дагуу л барилга баригдах шаардлагатай болдог. Гэтэл иргэд хуралд оролцоод, санал санаачилгаа хэлсэн болохоор нөгөө хэлсэн зүйлээ нэхдэг гэнэ. Ийм байдлаар ойлголтын зөрөө үүсдэг .

Суманд мэргэжилтэй ажиллах хүч цөөн учраас зураг төсөвтэй холбоотой асуудлаар бэрхшээл мундахгүй гардаг бололтой. Иргэдийн хурлын үеэр зураг төсөв нь батлагдаагүй саналуудыг батласаар иржээ. Гэтэл мэргэжлийн хүмүүс энэ хуралд оролцдоггүйгээс болоод зураг төсөв нь 50 сая байх ажлыг 100 сая эсвэл 25 сая гээд ч баталчих тохиолдол гарах боломжтой гэнэ. Сумын удирдлагууд иргэдийнхээ саналыг эрэмбэлэхдээ энэ ажил төдий хэмжээний мөнгөнд босох байх гэж таамаглаад, байгаа төсвөө багцаагаар хуваана. Иймд зураг төсөл нь бэлэн ажлуудад төсвийг нь хуваарилж өгөхгүй бол нэг бол их үрэлгэн зардал гаргах, эсвэл төсөв мөнгийг нь дутуу батлан түүнийгээ он дамжуулан хойшлуулах тохиолдол гардаг байна.

Дэлгэрцогт суманд тендер шалгаруулах эрхтэй буюу АЗ сертификаттай 7 хүн байдаг. Хэдийгээр орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах нэр хүндтэй ажил ч гэлээ хэрүүл маргаан, олны хардлага сөрдлөг

байнга дагадаг алба бололтой. Иймд АЗ сертификаттай эдгээр хүмүүс ярилцаж тохиролцсоны үндсэн дээр тендер шалгаруулахад баримтлах дотоод журмаа боловсруулсан байна. Уг журмаар нэг компани тендэрийн материал худалдаж авахад хэдэн төгрөг төлөх хэрэгтэй, үүнээс олсон мөнгийг юунд зарцуулах ёстой зэргийг зохицуулжээ. Түүнчлэн тендерийн хорооны дарга болон нарийн бичгийн дарга нэг удаа ажиллахад хэдэн төгрөгний урамшуулал авах, тэдгээр хүмүүсийн харилцаа холбооны зардалд хэдэн төгрөг төсөвлөх, тендерийн зар сурталчилгааны зардлыг хаана тусгах зэрэг заалтууд уг журманд багтсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа ажлуудыг шалгаруулахдаа тендер шалгаруулах комисс энэ журмаа мөрдөж байгаа бөгөөд энэ нь тендерийн үйл ажиллагааг шударга явуулах, нутгийн иргэдийн тендерийн тухай сөрөг сэтгэгдлийг багасгах зорилготой юм.

Сум хөгжүүлэх сангаас зээл авч төсөл хэрэгжүүлж байгаа хүмүүсийн хувьд ч анхаарах зүйл бий. Учир нь энэ сангаас зээл авсан хүмүүс анх зээл хүсэхдээ үзүүлж байсан төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэлгүй өөр зүйлд мөнгөө зарцуулах болжээ.

СХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлууд маань хүний нүдэнд ил байдаггүй учраас анх төлөвлөсөн зүйлээсээ өөрөөр бараг хэрэглээний зээл болон хувцраад байна. Саяхан бид хяналт хийгээд ирсэн. Үр дүн нь тааруу гарсан.

Сумын удирдлага Б-тэй ярилцсан ярилцлагын хэсгээс

Энэ сан нь ард иргэдийнхээ ахуй амьжиргааг дээшлүүлэх үндсэн зорилготой атал зээлээр олгогдсон хөрөнгийг зориулалтын бусаар ашигласнаар сумын иргэдийн амьжиргаанд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа аж. Жишээ нь, блок үйлдвэрлэнэ гээд зээл авсан хүн хичнээн блок үйлдвэрлэх ёстой тухай ямар ч зохицуулалт байдаггүй. Зээл олгох шалгуур үзүүлэлтэд 1000 блок үйлдвэрлэнэ, эсвэл 100000 блок үйлдвэрлэнэ гэх зэрэг нарийн шалгуур байдаггүй нь тухайн зээлийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах нэг нөхцөл болдог. Иймд цаашид зээлээр олгосон хөрөнгийг зориулалтын бусаар ашиглавал тухайн зээлдэгчийн нэрийг хар жагсаалтад оруулан дахин зээл олгохгүй.

Үнэндээ ч жижиг суманд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлнэ гэдэг (хэдийгээр бага хүүтэй зээл авсан ч гэсэн) амаргүй байдаг бололтой. Хүн амын төвлөрөлт хэтэрхий бага тул бараа бүтээгдэхүүний борлуулалт дагаад муу байдаг.

Хөгжлийн гарц гэж үздэг дэд бүтэц ч жижиг суманд сөргөөр нөлөөлөх тохиолдол байдаг нь сонирхолтой. Дэлгэрцогт сум аймгийн төв Мандалговь болон Улаанбаатар хоттой засмал замаар холбогдсон давуу талтай боловч энэ давуу тал нь зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг суманд хөгжүүлэх боломжийг хязгаарлажээ. Тухайлбал, Мандалговь хүнсний үйлдвэрийн талх, хотын үйлдвэрийн талхнаас илүү бөгөөд хямд өртөгтэйгөөр талх үйлдвэрлэж чадахгүй л юм бол энэ суманд талх борлуулах боломж бараг байдаггүй. Энэ жишээ бусад хүнсний бүтээгдэхүүнд мөн адил хамаатай болох нь ойлгомжтой. Тэгэхээр дэд бүтэцтэй холбогдсоны сайн бөгөөд сул талууд ч бас бий.

Үүнээс гадна хөдөлмөр эрхлэх хүсэлтэй залуучууд энэ суманд олддоггүй гэнэ. Сарын 300-350 мянган төгрөгийн цалинтайгаар өдрийн 8 цаг эсгий үйлдвэрт ажиллах хүн хайгаад олддоггүй тул 60 гарсан хоёр хөгшин өөрсдөө үйлдвэрийн ажлаа нугалж суухтай нь таарсан юм. Уг нь эдний үйлдвэр өдөрт дөрвөн ширхэг гэрийн эсгий үйлдвэрлэх боломжтой боловч ажиллах хүн олдохгүй байгаа учир өөрсдийн чадлын хэмжээнд өдөрт нэг ширхэг гэрийн эсгий үйлдвэрлэдэг байна. Эсгий үйлдвэрийн эзэн “Уг нь манай суманд жижиг үйлдвэрлэл хөгжих бололцоотой юм. Даанч төрийн бодлого буруу явсанаас болоод ажил хийх сонирхолтой хүн байхгүй болчихлоо” гэж хэлсэнийг энд тэмдэглэе.

Төсөв хөрөнгөө үр дүнтэй зарцуулах замаар орон нутгаа хөгжүүлэх гэж энэ сумынхан хэрдээ л хичээж, шинэ арга барил нэвтрүүлэн ажиллаж байгаа нь харагдаж байсан юм. Дэлгэрцогт суманд шийдэгдээгүй үлдсэн олон асуудал шийдлээ нэхэж, олон сорилт, бэрхшээл өмнө нь хүлээж байгаа боловч өмнө хуримтлуулсан эдгээр туршлагынхаа хүчээр амжилт дүүрэн явах бизээ.

АЙМГИЙН ЦАРААТАЙ СУМ БУЮУ БЭРХШЭЭЛ, ШИЙДЛИЙН УУЛЗВАР ДЭЭР

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМ

Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө бол иргэдийн хүсэн хүлээж, хүрэхийг тэмүүлж буй хэтийн ирээдүй, шийдвэрлэхийг хүссэн асуудал, түүнийг даван гарах арга замыгөөрсдийнх нь оролцоотойгоор тодорхойлж, урт хугацаанд төлөвлөж буй чухал баримт бичиг юм. Харин уг төлөвлөгөө тухайн орон нутгийн хөгжил дэвшлийн хөтөч болж чадах эсэх нь иргэд хөгжил гэдгийг хэрхэн ойлгож, хөгжилд хүрэх арга замыг яаж баримжаалж байгаагаас ихээхэн шалтгаална.

Оролцоонд тулгуурлан орон нутгийн хөгжлийг төлөвлөх нь иргэд өөрсдийн нөөц, боломжоо бодитой тодорхойлж, зохистойгоор ашиглан орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангах замаар амьдралын чанараа сайжруулах, амьжиргааны нөхцлөө дээшлүүлэхэд оролцох боломжийг иргэн бүрт олгож буй үйл явц юм.

Хөгжлийн төлөвлөгөө хатуу чанд, хөдөлшгүй баримтлах баримт бичиг биш билээ. Цаг үеийн нөхцөл байдлаа соргогоор мэдэрч, улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах, хэрэгжих явцад гарсан туршлага, сургамжид дүгнэлт хийн нэмж сайжруулах, шинээр үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх боломж бас бий.

Иргэдийн оролцоо төлөвлөлтөөр хязгаарлагдахгүй. Төсөвлөсөн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хуваарилсан төсвийг оновчтой зарцуулахад ч иргэдийн хяналт, оролцоо байх ёстой.

* * *

Дундговь аймгийн нийт хүн амын 30 орчим хувь нь оршин суудаг, аймгийн төвийн сум болохын хувьд Сайнцагаан сум нь аймгийнхаа хөгжлийн тэргүүлэгч, хөгжлийн гол тулгуур байх учиртай.

Байгуулагдсаныхаа 90 жилийн ойтой золгож буй уг сум төвийн тав, хөдөөгийн дөрвөн багтай, 270 гаруй мянган мал, 280 орчим аж ахуйн нэгжтэй, эмнэлэг, театр киноны хүрээлэн, музей, 50 гаруй мянган номын фонд бүхий номын сантай, нийгэм, улстөр, соёл, боловсрол,

нийтийн аж ахуй, худалдаа үйлчилгээний байгууллагууд төвлөрсөн, аймгийнхаа үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн төв нь юм.

Сайнцагаан сум Хаалганы хад, Хөрхийн хад, Алтатын цохио, Мөхийн хар хад гэхчилэн хад цохио, Хан суман, Тогоо, Бүрэн, Баян, Борогчин гэх зэрэг цэрдийн галвын сөнөсөн галт уулс зэрэг байгалийн өвөрмөц сонин тогтоц бүхий газруудтай. Нүүрс, өнгөт төмөрлөг, төмрийн хүдэр гэх мэт байгалийн баялагтай. Сумын төвөөс 30 орчим километр зайд байрлах хүрэн нүүрсний Тэвшийн говийн уурхай сумын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар зэргэлдээ сумд, аймгуудад нүүрсээ хүргэдэг.

Төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон, холбоо мэдээллийн болон үүрэн утасны бүх операторуудтай, нийслэл хоттой засмал замаар холбогдсон зэрэг дэд бүтцийн таатай нөхцөл, Улаанбаатараас уул уурхайн бүс нутаг болсон Өмнөговь аймагтай холбосон авто замын голд оршдог, аймгийн төвд төвлөрсөн төвтэй, томоохон зах зээлд хүрэх боломж, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах, ашиглах боломжтой зэрэг давуу талууд тус сумынхөгжлийн ирээдүйг эерэгээр төсөөлөх боломжийг иргэдэд олгож байна.

Сумын эдийн засгийн голлох салбар нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй бөгөөд малын тоогоороо аймагтаа хоёрдугаар байранд ордог аж. Мал сүргийн дийлэнхи хувийг хонь, ямаан сүрэг, багахан хэсгийг тэмээ, үхэр, адуу эзэлдэг.

Хөгжлийн таатай нөхцөлүүд бүрдсэн хэдий ч хур тундасны хэмжээ бага, ган зуд байнга шахуу тохиолддог, гадаргын усны нөөц багасч буй, цөлжилт идэвхижэж байгаа зэрэг аймгийн хэмжээнд тулгарч буй байгалийн гамшиг, эрсдэл энэ нутгийг тойроогүй.

2000-аад оны дунд үе Сайнцагаан сумын хувьд хүндхэн жилүүд байв. Хур бороо багатай гантай зун, зудтай өвөл, хавар ээлжилсэн жилүүд бэлчээрийг цөлжихөд хүргэсэн нь мал аж ахуйд суурилсан тус сумын малчдад хүндхэн тусаж, байнгын отор нүүдлийн амьдрал тэдний амьдралыг ихээхэн туйлдуулахад хүргэжээ. Хэдий тийм ч сумынхаа ирээдүйг өөдрөгөөр төсөөлж, улсын хөгжлийн бодлоготой хөл нийлүүлэн алхах боломжийг эрэлхийлэх, тулгарсан бэрхшээл, сорилтыг даван туулж, орон нутгийн иргэдийнхээ амьдралын чанарыг

дээшлүүлэхээр “Мандал Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөөг Мерси Кор Олон улсын байгууллагын дэмжлэг, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сумын иргэдийн оролцоо, санал, санаачилгад тулгуурлан боловсруулсан нь 2009 он байв.

“Хүний хөгжил, байгаль орчноо дээдэлж, орон нутгийн нөөцөд түшиглээн боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуй, чанар хүртээмжтэй үйлчилгээ хөгжсөн, эдийн засгийн чадавхитай, амьдралын эрүүл, таатай орчин бүрдсэн, аймгийнхаа хөгжлийн тулгуур төв болох...”

“Мандал – Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө (2009-2021)

“Хөгжлийн төлөвлөгөө ямар намаас гарч ирснээс үл хамааран үе үеийн засаг дарга нарын үйл ажиллагааны үндсэн чиглэл болж хэрэгжиж байх учиртай” гэж засаг дарга М.Баянсан хэлж байна. 2012 оны сонгуулиар засаг даргаар дахин сонгогдсон М.Баянсан уг хөгжлийн хөтөлбөрийг анх боловсруулахад оролцож явсан хүн юм. Энэ утгаараа сумын хөгжлийн хөтөлбөрийг өөрийн мөрийн хөтөлбөрт тодорхой хэмжээгээр тусган хэрэгжүүлж яваа аж.

Сайнцагаанчууд хөгжлийнхөө тэргүүлэх чиглэлийг орон нутгийн нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэр, эрчимжсэн болон уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой хослол, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд тохирсон чанар, хүртээмжтэй худалдаа, ахуйн болон бусад үйлчилгээ гэж томъёолсон бөгөөд энэ хүрээнд дараах зорилго, зорилтуудыг шийдвэрлэхийг зорьжээ. Үүнд:

Нэгд, орон нутгийн онцлогт тохирсон бизнесийн өрсөлдөөний эрүүл, тогтвортой орчинг бүрдүүлж төлөвшүүлэх зорилгын хүрээнд бизнес эрхлэгчдэд хууль, эрх зүйн шударга орчинг бүрдүүлэх; бизнесийн зуучлал, үйлчилгээний сүлжээг хөгжүүлэх зорилтууд;

Хоёрт, орон нутгийн нөөцөд тулгуурласан, зах зээлд нийцсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мал аж ахуй, чанартай үйлчилгээг зохистой хослуулан хөгжүүлж эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд орон нутгийн нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх; эрчимжсэн мал аж ахуйд

суурилсан хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх; хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд тохирсон чанар, хүртээмжтэй худалдаа, үйлчилгээг хослуулан хөгжүүлэх зорилтууд;

Гуравт, хүнийг дээдэлсэн, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ, аюулгүй орчны тогтолцоог бүрдүүлж нийгмийн хөгжлийг хангах зорилгын хүрээнд сургалтын орчин, нөхцөлийг бүрдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлж хүртээмжийг нэмэгдүүлж хамран сургалтыг 100 хувьд хүргэх; эрүүл мэндийн тусламж үйлчилгээний таатай орчинг бүрдүүлж, хүн амд шуурхай, хүргэх замаар хүн амын өвчлөлийг бууруулах; хүн ам зүйн зохистой бодлого хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ядуурлыг 60-аас доошгүй хувиар бууруулах; соёл, урлагийн үйлчилгээний менежментийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг зорилтууд,

Дөрөвт, Байгаль орчны бодлого, түүний хэрэгжилтийн тогтолцоог төгөлдөршүүлэх зорилгын хүрээнд хамгаалалтын тогтолцоог сайжруулан байгалийн доройтлыг бууруулах; усны эх үүсвэрийг хамгаалах, уст цэгийн тоог 70-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, нөөцийг зохистой ашиглах; зохиож буй ажлыг өргөтгөж 2000 га талбайд элсний нүүдэл, цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тус тус дэвшүүлжээ.

Дээрх зорилтуудыг 32 хөтөлбөрийн хүрээнд 146 төслөөр дамжуулан 2009-2021 оны хооронд гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2009-2012 онд хэрэгжих нэгдүгээр шат нь хөгжлийн суурийг бий болгоход чиглэсэн бол 2013-2016 оныг хөгжлийн шат буюу төсөл хөтөлбөр хэрэгжих хоёрдугаар шат, 2017-2021 оныг эрчимтэй хөгжил, бүтээн байгуулалтын шат болгон төлөвлөжээ. 2012 онд Мерси Кор Олон Улсын Байгууллага, сумын удирдлагууд хамтран цогц төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж үзэхэд 2021 он хүртэл 7 жил дутуу байхад 146 төслөөс 99 нь ямар нэгэн байдлаар хэрэгжсэн, төлөвлөгөөний хэрэгжилт 70 орчим хувийн биелэлттэй яваа гэж гарсан хэмээн сумын удирдлагууд өгүүлж байна.

Төсвийн тухай шинэ хуулинд зааснаар 2013 оноос Монгол Улсад анх

удаа орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилго бүхий орон нутгийн хөгжлийн нэгдсэн санг байгуулж улсын төсвөөс аймаг, сум, дүүрэгт байгуулагдсан орон нутгийн хөгжлийн санд дахин хуваарилалт хийхээр тусгасан билээ.

Ийнхүү орон нутгийн хөгжлийн сан байгуулагдаж, сум бие дааж шийдэх хөрөнгөтэй болсон нь нэг талаас “Мандал – хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц хөтөлбөрийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх, нөгөө талаас иргэд төсвийн хөрөнгийг орон нутгийнхаа хөгжилд өөрсдөө мэдэж зарцуулах бодит боломж гэж Сайнцагаан сумынхан үзэж байна.

Сайнцагаан сум 2013 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 37 бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлж хэрэгжүүлсэнээс 22 нь сумын хөгжлийн цогц төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6 хөтөлбөрийн 9 төсөлд хамаарч байгаа бөгөөд энэ нь нийт ажлын 60 орчим хувьтай тэнцэж байна. Нөгөө талаас сумын хөгжлийн цогц төлөвлөгөөнд туссан нийт ажлын 6.2 хувьтай тэнцэх ажлыг 2013 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэжээ.

Сайнцагааныхан аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдсан 40 хувиас ч сумандаа хийсэн зүйлтэй үлдэхийг хичээжээ. Үүний тулд сумын хөгжлийн цогц төлөвлөгөөнд туссан зарим томоохон ажлуудаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал болгон оруулж аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн тодорхой хувийг өөрийн суманд чиглэсэн ажил болгож чадсан байна. Эдгээр ажлын тоонд 2.6 км зам барих, 734 сая төгрөгний камержуулах, тэмдэг тэмдэглэгээ хийх, нисэхийн зам, хоёр өрхийн эмнэлгийн өргөтгөл, халуун усны засвар зэрэг ажлуудыг дурдаж болох юм.

Бид 847 сая төгрөгөөрөө томоохон бүтээн байгуулалт хийж чадахгүй байна. Томоохон бүтээн байгуулалтыг аймгийн орон нутгийн хөгжлийн санд суулгаж өгөхөд анхаардаг.

Сумын удирдлагатай хийсэн ярилцлагаас

Ингэж Төсвийн тухай хуулинд туссан бодлогын шинэчлэл нь орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог хангах, удирдлагын идэвх, санаачилга, хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой арга хэмжээ болж байгаагийн зэрэгцээ орон нутгийн

хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилтэд иргэдийг идэвхитэй оролцуулах, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг илүү зөв боловсруулах, улсын болон бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулах, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хянах, сайжруулах зэрэг олон сорилт Сайнцагаан сумын өмнө тулгарч байна.

ХҮСЭЛ СОНИРХОЛ, БОДИТ ХЭРЭГЦЭЭГ УЯЛДУУЛАХ НЬ

“Мандал - Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулах ажил гурван сар үргэлжилжээ. Сумын засаг даргаар ахлуулсан төлөвлөгөө боловсруулах “Ажлын хэсэг”, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх олон нийтийн төлөөлөл бүхий “Төлөвлөлт, хяналтын хороо” хамтран ажилласан байна.

Хөтөлбөр боловсруулхад иргэд, жижиг дунд үйлдвэрлэл болон хувиараа бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн болоод төсвийн байгууллагын ажилтнууд, ахмад настнууд, залуусын төлөөлөл зэрэг давхардсан тоогоор 1000 гаруй иргэдийн саналыг анкетын асуулга, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлэг, олон нийтийн хэлэлцүүлэг, нээлттэй утас, санал хүсэлтийн хайрцаг ажиллуулах зэрэг хэлбэрээр авсан гэж албан ёсны баримт бичигт дурдаж байгаа боловч төлөвлөгөөний ажлын хэсгийн гишүүн ч тэр, төлөвлөгөөг боловсруулхад оролцож байсан иргэний нийгмийн төлөөллүүд ч тэр өөр бодолтой байгаа ажээ.

Тухайн үед сумын нийгэм, эдийн засагт голлох нөлөөтэй бизнес эрхлэгчдийн саналыг түлхүү тусгасан бөгөөд иргэдэд чиглэсэн албан ёсны хэлэлцүүлгүүд цөөхөн хийгдсэн, багийн иргэдийн нийтийн хуралд мэдээлэл хүргэхээс хэтрээгүй, иргэд ч энэ тухай тогтсон ойлголттой байгаагүй тухай уг төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн багийн гишүүн хэлж байгаа болтөсөл боловсруулахдаа тухайн салбарын ахмадууд, залуучууд, бизнес эрхэлж байгаа хүмүүсийн хүрээнд авсан болохоос яг 2013 оны орон нутгийн хөгжлийн сангийн ажилд иргэдээс санал авч байсан шиг байж чадаагүй, иргэдийн оролцоо бага байсныг үгүйсгэхгүй гэж учир мэдэх албан тушаалтан өгүүлж байна.

Тухайн үед цогц төлөвлөгөөг боловсруулсан багийн 28 гишүүний 26 нь аймаг, сум, багийн удирдах ажилтнууд, асуудал харуцсан мэргэжилтнүүдээс бүрдэж байв. Бусад нь: малчин – 1, нийгмийн интерпренер – 1.

“Мандал – Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө (2009-2021)-нөөс

Иргэдийг хамруулах гэдэг утгаараа олон хэлэлцүүлэг болсон. Олон хүмүүс оролцсон учир ерөнхийдөө иргэдийг хамруулсан гэж болно. Тэрнээс ийм төсөл хэрэгжих гэж байна гэж иргэдээс саналын хуудсаар санал асуулга авсан зүйл бага.

Сумын удирдлагатай хийсэн ярилцлагаас

Иргэдээс, тодруулбал бизнес эрхлэгчдээс гарсан саналд үндэслэсэн 146 төсөл хоёр удаагийн шүүлтүүрээр орсны эцэст “Мандал - Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусчээ.

2012 онд Мерси Кор Олон Улсын Байгууллага, хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан ажилд үнэлгээ хийхэд хэдий иргэдийн оролцоо тааруухан байсан ч сумын удирдлага төлөвлөгөөтэй болсондоо сэтгэл хангалуун болсон гэсэн үр дүн гарчээ.

2013 оноос Төсвийн шинэ хуулиар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэд орон нутагтаа хийгдэх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд санал өгөх боломжтой болсон нь “Мандал - Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө хэрэгжих таатай боломжийг бүрдүүлж өгчээ.

Улсын төсөв, орон нутгийн төсвөөс илүүчлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хандивлагчдаас царайчилдаг байсан цаг өөрчлөгдөж сум бие даан шийдэх хөрөнгөтэй болсон нь сумаа хөгжүүлэе гэсэн хүн бүхэнд сайхан боломж гэж харагдах нь зүй ёсны хэрэг юм.

“Дундговь аймгийн Сайнцагаан сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн энэхүү цогц төлөвлөгөө нь тус сумын төр, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн хамтын бүтээл бөгөөд өмчлөх, зохиогчийн эрх тус суманд хадгалагдана”

“Мандал – Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө (2009-2021)

2013 онд Сайнцагаан сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 37 ажил, бараа худалдан авсан бөгөөд эдгээр ажлуудыг журмын дагуу тухайн багийн иргэдээс санал асуулгын хуудсаар авсан санал, иргэдийн нийтийн хурал дээр гаргасан саналаар эрэмбэлэн жагсааж сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн, тогтоолоор баталжээ.

Иргэдийн саналаар батлагдсан ажлуудын дийлэнхийг хүүхдийн тоглоомын талбай тохижуулах, усан сан, гэрэлтүүлэг, хаягжилтын ажлууд эзэлж байна. Харин малчдын хувьд гойд ашиг шимт мал үржүүлэх буюу малжуулах, худаг засварлах, бэлчээр хаших зэрэг ажлуудыг түлхүү санал болгодог нь үнэндээ тэдний хувьд нэн шаардлагатай байгаа хэрэгцээ нь л энэ юм.

Орон нутгийн хөгжлийн сангаар малчдад зориулаад ямар ажлууд хийвэл зүгээр вэ?

Есөн зүйлийн ажил байлгүй яахав дээ. Хөдөөний мань мэтэд ус худгийг нь гаргаж өгөх, бэлчээр хашуулах, хороо хотоо янзлуулах ажлууд хэрэгтэй л байдаг юм.

Ядарсан малчдад ингэж л туславал зүгээр.

Сайнцагаан сумын малчинтай хийсэн ярилцлагаас

Сумын удирдах ажилтнуудын хэлж байгаагаар анх удаа иргэдээс санал авч байгаа гэдэг утгаар нь 2013, 2014 оны орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлуудыг цэвэр иргэдийн санал дээр үндэслэн сонгожээ. Хийгдэж буй ажил нь тоглоомын талбай тохижуулах, хаяг хадах зэрэг аахар шаахар, жижиг ажил мэт боловч тухайн амьдарч буй орчноо аятай тухтай байлгах гэсэн иргэдийн хүслийг үүнд буруутгах аргагүй юм.

Эдгээр жижиг ажлууд сумын хөгжилд дорвитой нөлөөлж чадахгүй байна гэж үзсэн сумын удирдлага 2015 онд орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төслүүдийн саналыг авахдаа сумын хөгжлийн цогц төлөвлөгөөтэй холбоотой тодорхой чиглэлүүдийн ажилд санал өгөхийг иргэдээсээ хүсчээ. Үүний зэрэгцээ санал авах хуудасны доод хэсэгт иргэд өөрсдөө санал болгох төслүүдийг бичих хоосон зай үлдээсэн байна.

Журамд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг иргэдийн саналд

үндэслэн зарцуулахаар тусгасан байгаа боловч нэгд, ингэж бодлогоор тодорхой чиглэл өгөхгүй бол энэ мөнгө 5-6 сая төгрөгт эргэлдэх аахар, шаахар ажилд зарцуулагдаад дуусах нь, хоёрт, дараагийн сонгуулийн үр дүн уг сангийн үйл ажиллагааг доголдуулж магадгүй гэсэн болгоомжлолоос үүдэн үлдсэн хоёр жилийн хөрөнгө оруулалтыг сумын хөгжлийн цогц төлөвлөгөөний дагуу үр ашигтай, томоохон ажлуудад зарцууля гэсэн санал сумын удирдлагуудын зүгээс гарчээ.

Харин үүнтэй иргэний нийгмийн байгууллагууд санал нийлэхгүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хамгийн чухал, ололттой тал нь хөрөнгө оруулалтын шийдвэрт иргэдийн оролцоог хангаж, саналыг тусгах үйл явц юм. Гэтэл бодит байдалд хангалттай (ямар хэмжээг хангалттай гэж үзэх нь ч тодорхойгүй) хэмжээний саналын хуудас орж ирэхгүй байгаа, санал авч, эрэмбэлэх хуралд танхим дүүртэл иргэд ирж хуралдахгүй байгаа нь шийдвэр үндэслэлтэй эсэхэд эргэлзэхэд хүргэдэг байна.

Үнэндээ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.10-ын дагуу аймгийн төвийн сумын багийн 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж тооцдог нь иргэдийн оролцоо бага байгааг зөвтгөх шалтгаан болж ч магадгүй юм.

Баг	Хүн амын тоо	Өрхийн тоо	Хүчинтэй байх ирц (хуулийн дагуу)	Хурлын оролцогчдын тоо
1	664	198	6-10	67
2	782	216	8-11	41
3	856	252	9-13	141
4	746	245	8-13	85
5	1599	519	17-26	87
6	1821	511	17-26	33
7	-	-	-	-
8	2111	647	22-33	35
9	2303	708	24-36	49

2013 онд орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжүүлэх ажлын саналыг эрэмбэлэх хуралд хуулинд заасан хэмжээнээс хамгийн багадаа 2-3 дахин олон иргэн оролцжээ. Гэхдээ энэ нь орон нутгийн хөгжилтэй холбоотой чухал шийдвэр гаргахад хангалттай тоо биш гэж иргэний нийгмийнхэн үзэж байна. Зөвхөн эрэмбэлэх төдийгүй санал авахад иргэдийн оролцоог хангадаг байх, өрх бүрт тарааж өгсөн хуудсууд буцаж ирдэг байх, буцаж ирсэн хуудас бүр шаардлага хангадаг байх нь чухал.

Багийн хуралд 60 хүн ирсэнийг ирц бүрдсэнд тооцдог. Санал авах процессоос хамаарч л ямар ажил хийх нь тодорхой болно. Төсөл маягийн саналыг иргэнд өгч байж иргэн дэмжинэ. Иргэнээ мэдээлэлжүүлээд санал авах дээр хойрго хандаж байгаа учир эцэстээ үр дүнгүй. Тендер шалгаруулах процесс явагдсан ч гэсэн. Уг нь орон нутагт дээрдэж байгаа. Санал авч байгаа процесстай тааралдсан. Та иргэндээ мэдээлэл өгдөг үү гэхээр өгдөггүй, иргэнд нөлөөлсөн болно гэхинэ. Эрэмбэ гэдэг бол тоо. Иргэдийн санал дээр ажилладаг газар нь иргэдийн хурал. Тооцоо судалгаатай саналд иргэд саналаа өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол чанаргүй ч гэсэн олон хүн дэмжсэн бол шалгарч байна. Одоогийн саналын хуудас бол саналаа тулгасан шинжтэй.

Сайнцагаан сумын иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн ярианаас

Иргэдийн оролцоотойгоор төлөвлөхөд иргэдийн хэрэгцээ болон хийгдэх ажлын үр ашгийг уялдуулан авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, иргэдийн хүсэлт, саналаар хийгдсэн ажил нь үнэхээр ашгаа өгч, олон нийтийн хэрэгцээг бүрэн хангаж чадах зүйл мөн үү гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй юм.

Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах хуудас нь иргэдийг төлөвлөлтөд оролцуулах нэг чухал арга хэрэгсэл юм. Гэтэл зарим тохиолдолд иргэд саналын хуудсыг уншилгүйгээр “Өөрөө мэдээд бөглөчих” гэдэг, багийн зүгээс иргэдийн бөглөсөн саналын хуудсыг хурааж авахдаа хойрго хандах зэрэг асуудлаас үүдээд иргэдийн бодит хэрэгцээтэй зүйл бус, үр ашиг багатай зүйл нь цөөн хэдэн иргэний саналаар гараад ирчихдэг хандлага байна.

Дундговь аймаг онцлогтой аймаг. Хоёр сумаас бусад нь Мерси Корын аргачлалаар төлөвлөгөөтэй болсон. Орон нутгийн хөгжлийн сан гэж бий болонгуут сум хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх хөрөнгөтэй болчихож байгаа юм бишүү гэсэн ойлголттой байсан. Гэтэл Сангийн яамнаас баталсан журам нь өөр байсан. Тэгэнгүүт санал авах стандарт хуудасны дээд талын зайд Сайнцагаан сумыг хөгжүүлэх төлөвлөгөөнд ийм ийм ажил тусгагдсан гэж бичээд иргэдээс санал авсан. Тэгж нэг туршиж үзэж байна.

*Сайнцагаан сумын иргэний нийгмийн
байгууллагын төлөөллийн ярианаас*

Санал асуулгын хуудсыг бүрэн утгаар нь ашиглаж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь уг хуудасны бүтэц, агуулгатай холбоотой. Санал авах хуудас тодорхой бус, бөглөхөд хялбар биш учир иргэд ач холбогдол өгдөггүй, нөхөх зааварчилгаа, нэмэлт тайлбар байдаггүйгээс иргэд түүнийг янз бүрээр ойлгож бөглөх, хоосон зай үлдээх тохиолдол их гардаг байна. Мөн санал авах ажлыг зөвхөн багийн дарга нар хийдэг нь нэг хүнд ногдох ажлын ачааллыг нэмэгдүүлж, санал асуулгын чанарт сөргөөр нөлөөлдөг тал ч бий аж⁸.

Тиймээс саналын хуудсаар иргэдийн саналыг хэрхэн үнэн зөв гаргаж ирэх вэ гэдэгт анхаарал хандуулах шаардлагатай. Чанартай санал авахад урьдчилан тайлбарлан таниулах, биечлэн авах нь үр дүнтэй юм.

2009 онд “Мандал - Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөөг ном болгон хэвлэж нийтэд хүргэсэн, хөгжлийн цогц төлөвлөгөөний хүрээнд сурталчилгаа, мэдээлэл, олон нийттэй харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан ч хөтөлбөрийн ач холбогдол, үр нөлөөний тухай таниулан сурталчилах, хөтөлбөртэй холбоотой иргэдийн саналыг авах тухай дорвитой ажил хийлгүй байсаар өнөөг хүрчээ. Үүний шалтгаан нь төсөв хөрөнгө, гүйцэтгэх эзэн тодорхойгүй байдалтай холбоотой.

2013 онд сумын захиргааны зүгээс иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын иргэний танхим” байгуулж ажиллуулахаар

⁸ “Чулууны уулын аялгуу” ТББ-ын гүйцэтгэсэн “Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг сайжруулах” судалгааны зарим үр дүнг ашиглав.

болсон бөгөөд үүний тулд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр пургон автомашин худалдан авч хөдөөгийн иргэдэд хүрч ажиллахад боломжтой тоног төхөөрөмжийг Азийн сангийн дэмжлэгээр худалдан авч тоноглохоор болсон байна.

Дундговь аймгийн Аюулаас сэрэмжлүүлэх мэдээлэл холбооны цогцолбор Сайнцагаан сумын нутаг дэвсгэр дээр байрладаг. Энэ цогцолбор нь 250 ваттын хүчин чадалтай, 15 мэдээлэгч нэгж-толгой сэргийлэгчтэй, 70-250 км-ын радиуст үйлчилдэг, FM сувгаар нэвтрүүлгээ цацдаг монгол инженерүүдийн бүтээсэн радио станц ажээ. Уг радио станцийн нэвтрүүлгийг хүлээн авах хүлээн авагчийг тус сумын нийт 636 малчин өрхөд зориулан худалдан авах төсвийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна.

Уг цогцолбор нь өдөрт гурван удаа цаг агаарын мэдээ дамжуулдаг. Зарим хотгор гүдгэр газрыг эс тооцвол мэдээллийг малчид байнга авдаг аж. Аймгийн хэлтэс, агентлагууд тодорхой цагуудад мэдээлэл өгдөг бөгөөд 2014 оноос эхлэн иргэдэд мэдээлэл түгээх ажлыг улам өргөжүүлэхээр төлөвлөж байгаа. Үүнээс гадна малчидын утасны дугаар бүрдүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд газар нутгийн онцлогоос хамааран уг суманд харьцангуй сайн ажилладаг үүрэн утасны Жимобайл операторыг ашиглан иргэдтэй эргэх холбоотой ажиллах боломжийг судалж байгаа ажээ.

Азийн хөгжлийн сангийн “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь” хөтөлбөр Дөргөн, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдад хэрэгжиж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 24.5 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр орон нутгийн иргэдийн оролцоог нутгийн удирдлагын түвшинд сайжруулхад чиглэсэн ажлууд хийгдэх юм.

Уг хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй нэг ажил бол Сайнцагаан сумын засаг даргын тамгын газраас эрхлэн гаргадаг сар тутмын “Сүүн цагаан – Сайнцагаан” сонин бөгөөд жилд хоёр удаа сумын бүх өрхөд үнэ төлбөргүй хүрдэг. Сонинд сумын Засаг даргын захирамж, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны мэдээллээс гадна боловсрол, эрүүл мэндийн чиглэлийн мэдээлэл, зөвлөгөө, сумаас зохион байгуулах ажлуудын төлөвлөгөө, хөтөлбөрийг нийтлэдэг. Сонин бол иргэдийн мэдээлэл авах сувгийн тоог нэмэгдүүлэх нэг боломж юм.

Үүнээс гадна “Хамтдаа шийднэ 333” малчид, залуучуудын уулзалтыг сар тутам зохион байгуулах, телевиз, сонингоороо хийсэн, хийгээгүй ажлаа тайлагнах, нийтийн зар мэдээний самбар байрлуулах зэрэг ажлуудыг хийж эхлээд байна.

Сумын хөгжлийн төлөвлөгөө болон орон нутгийн түвшинд хийгдсэн, хийгдэж буй, хийгдэхээр төлөвлөсөн ажлын талаарх мэдээллийг сумын удирдлага янз бүрийн арга хэлбэрээр хүргэхийг зорьж байгаа ч багийн дарга нарын хүч тарамдах, хөрөнгө, хүч дутагдах бэрхшээл байнга тохиолддог ажээ. Тус сумын хүн ам олон, ялангуяа төвийн таван багийн хүн ам нь багахан сумтай тэнцэхүйц, энэ хэрээрээ тэдэнд хүрч ажиллах хэрэгцээ шаардлага их. Тиймээс иргэний нийгмийн байгууллагууд сумын хөгжлийн цогц төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн тухай мэдээллийг иргэдэд хүргэх, иргэдийн орон нутгийн хөгжилтэй холбоотой гаргасан санал, санаачилгыг төр, захиргааны байгууллагад уламжлах ажлыг гэрээлэн гүйцэтгэх замаар хамтран ажиллахыг хүсэж байна.

ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ӨӨРЧЛӨГДӨШГҮЙ ЗҮЙЛ БИШ

“Мандал –Хөгжил” нийгэм, эдийн засгийн цогц төлөвлөгөө батлагдсан 2009 он Дундговь аймгийн хувьд хүнд жилүүдийн нэг байжээ. Хэд хэдэн жил дамнасан ган, зудын уршигаар сумын эдийн засгийн гол салбар болох мал аж ахуйд хүчтэй нөлөөлж, сумын малчид отор, нүүдлээс салахаа байж, нүүдэл дагасан малчидын амьдрал ч тогтохоо больжээ. Энэ хэцүү бэрх үед сумын төлөвлөгөө боловсруулахад санаагаа чилээсэн хүн бүрийн сумын төв нь ногоон байгууламжтай болоосой, хөдөөгийн малчидын амьжиргаа дээшлээсэй гэсэн хүсэл эрмэлзлэлээсүүдэн мал аж ахуй, малчид руу чиглэсэн бодлогыг хөгжлийн төлөвлөгөөнд түлхүү оруулсан байна. Малчдын бүлэг байгуулах, малчдыг тендерт оролцуулах зэргээр малчид руу чиглэсэн олон ажил хийгджээ.

Хөгжлийн цогц төлөвлөгөө цаг үедээ тулгамдаж байсан асуудал бүрийг шийдэхийг хичээсэн ч мөрөөдлийн чанартай зүйлс ч мэр сэр байгааг сумын удирдлагууд ярьж байна. Улс орны нийгэм, эдийн засгийн төлөв байдал, төр засгаас авч хэрэгжүүлж буй бодлого, бүсийн болон

орон нутгийн хөгжлийн хэтийн хандлага, сүүлийн жилүүдийн байгаль, цаг уурын өөрчлөлттэй уялдуулан хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх санал сумын удирдлагуудын зүгээс ч, иргэд, олон нийтийн зүгээс ч гарах болжээ.

Энэ хүрээнд цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, хойшид анхаарах асуудлуудыг тодруулах зорилготой ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсэг дүгнэлтээ 11 сард болох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал дээр тайлагнах бөгөөд 2012 онд хийсэн үнэлгээнээс ялгаатай нь төлөвлөгөөнд туссан төсөл тус бүрийг нарийвчлан үнэлж цаашид ямар өөрчлөлтийг хэрхэн хийх тухай санал боловсруулах аж.

2012 онд батлагдсан “Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө (2012-2031)”, 2013 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн Орон нутгийн хөгжлийн сан зэрэг сумын хөгжлийн төлөвлөлтөд нөлөөтэй шинээр батлагдсан бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулах, зарим төслүүдийг шинэчлэх, өөрчлөх, шинээр тусгах шаардлага байгааг ч засаг дарга дурдаж байв.

Хөгжлийн цогц төлөвлөгөөнд туссан төслүүдийг яаж хэрэгжүүлэх, юун хүрэх нь тодорхойгүй, дунд хугацааны төлөвлөгөө байхгүй, 2009-2021 гээд бүрхэг заачихсан, яг хэзээ нь яаж хэрэгжүүлэх нь тодорхойгүй, яг хариуцах товлосон эзэнгүй, олон эзэнтэй учир дунд нь хаягдчихаад байдаг зэрэг дутагдлууд байгаа тухай шүүмжлэлтэй хандах иргэд ч бас байна.

2014 оны 2 дугаар сараас 5 дугаар сарын хооронд “Чулууны уулын аялгуу” ТББ-аас “Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг сайжруулах” судалгааг гүйцэтгэсэн бөгөөд сумын хөгжлийн төлөвлөгөөг Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай хэр уялдуулан хэрэгжүүлж байгааг судалжээ. Судалгааны хүрээнд сум хөгжүүлэх сангийн зээл авахаар ирүүлсэн төслүүдийг голчлон хэрэгжүүлж буй хүн нь хэр найдвартай вэ гэдгийг харж шийдвэрлэдэг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай иргэд төдийгүй багийн засаг дарга нар, иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид хүртэл сайн мэддэггүй, эдгээр сангуудын сонгон шалгаруулалтыг хийхдээ нэгдсэн бодлого баримталдаггүй, сангуудын

зөвлөлүүд хоорондоо уялдаагүй, тус тусдаа шийдвэр гаргадаг зэрэг дутагдалтай асуудлууд байгааг илрүүлсэн байна.

Дундговь аймгийн 15 сумын 13 нь хөгжлийн төлөвлөгөөтэй. 2014 оны 5 сард болсон Дундговь аймгийн сумдын засаг даргын орлогч нарын семинар дээр сум болгон хөгжлийн баримт бичгээ хэрхэн ашиглах, хөгжлийн загвараа хэрхэн тодотгож гаргаж ирэх тухай асуудлыг хөндөн ярилцжээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн болоод сумын засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг хөгжлийн төлөвлөгөөтэй хэрхэн уялуулах, хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг сангуудыг хэрхэн ашиглаж болох тухай санал солилцсон байна.

Түүнчлэн сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор богино хугацааны болон 4-5 жилийн хугацаатай дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, сумын засаг даргын бүрэн эрхийнх нь хугацаанд хөгжлийн төлөвлөгөөний холбогдох хэсгийг заавал хэрэгжүүлж байхаар мөрийн хөтөлбөрт нь тусгуулж, хэрэгжсэн эсэхийг нь бүрэн эрхийнх нь хугацаанд хамааруулан тооцож байх зэрэг саналыг сумын иргэдийн төлөөлөгчид санал болгож байгаа ажээ.

Сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Орон нутгийн хөгжлийн сан ганцхан гарц нь бас биш юм. Орон нутагт хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтад сум хөгжүүлэх сангийн дэмжлэгтэйгээр бий болсон жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг ч татан оролцуулах боломж бий.

Сайнцагаан сумын Сум хөгжүүлэх сангийн эргэлтийн хөрөнгө 2013 оны байдлаар 1.2 тэрбум төгрөгт хүрээд байгаа аж. Энэ сангийн үр нөлөөг нэмэгдүүлэх, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах зорилгоор эхний ээлжинд сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зөвлөлийг сумын удирдлага, олон нийтийн оролцоотойгоор байгуулах, сумын хөгжилтэй холбоотой баримт бичгүүдэд шинжилгээ хийж эдийн засгийн үр ашгийг нь тооцож үзэх арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Тухайлбал, сум бүр хөгжлийн төлөвлөгөөндөө махны үйлдвэртэй

болно гэсэн ч эдийн засгийн үр ашгийг нь тодорхой тусгаагүй байдаг аж. Үнэндээ тухайн суманд үнэхээр махны үйлдвэр байгуулах шаардлага байна уу, үгүй юу? Нийлүүлэх мах нь байгаа юу, худалдан авагч хангалттай юу зэргийг нарийн тооцоололгүйгээр хөгжлийн төлөвлөгөөнд тусгачихсан, байгууллаа ч цаашдаа үр ашигтай эсэх нь тодорхойгүй энэ мэтчилэн төслүүдийг хасаж, сумын хэрэгцээг нэн тэргүүнд хангах боломжтой үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хөгжлийн төлөвлөгөөнд тусгах, улмаар Сум хөгжүүлэх сантай уялдуулах шаардлага байгаа.

2013 оноос эхлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тухайн онд хэрэгжүүлэх сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөө, хөгжлийн тэргүүлэх чиглэлийн үндсэн дээр тухайн жилд ямар чиглэлийн төслийг дэмжиж санхүүжүүлэхээ тодорхойлох болсон байна.

Энэ жилийн хувьд хөгжлийн тэргүүлэх, хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудад хамаарах 13 төсөлд сум хөгжүүлэх сангийн зээлийг өгөхөөр шийдвэрлэжээ. Үүний үр дүнд үр ашиг багатай жижиг зээлүүдийн тоо багасаж, сумын бодлого, хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан төслүүд дэмжигдэх болсон.

Ер нь сум хөгжүүлэх сангийн зээл бол хувь хүн овсгоотой ажиллаж чадвал өөрийгөө ч, сумаа ч хөгжүүлнэ. Энэ боломжийг ашиглаад ашигтай ажиллаад, ажлын байр бий болгоод, бизнесээ өргөжүүлээд явж байгаа хүмүүс олон бий. Үүний нэг жишээ нь “Итгэлийн зээл” ажээ.

2013 онд сум хөгжүүлэх сангаас архианаас гарсан 10 хүнд 5-10 сая төгрөгний зээлийг барьцаагүйгээр, ямар нэгэн шалгуургүйгээр “Итгэлийн зээл” олгож туршиж үзсэн нь амжилттай болсон байна. Зээлийн нэг гол нөхцөл нь зээлдэгч архианаас хол байх, ажлаа хийж, амьдралаа өөд татах явдал юм. Тэдэнд итгэсэн итгэл ч талаар өнгөрөөгүй тухай засаг дарга ам сайтай байна. Архианаас хамааралтай, урд нь болж бүтэхгүй зүйл хийж явсан хүмүүс баг бүрдүүлээд хоёр давхар, 4 айлын хоёр сууц барьж ашиглалтад оруулсан, хувьдаа машин авч тээвэр хийж байгаа зэрэг олон жишээг дурдаж болох бөгөөд энэ нь нэг талаас иргэдэд үлгэр болохуйц нийгмийн ач холбогдолтой, нөгөө талаас сум, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах бүтээлч бүлэг, аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжиж буй хэрэг юм.

Сумын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан зүйл бол Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа эхэлсэн явдал билээ.

“Мандал - Хөгжил” нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөө батлагдаж байсан тэр үед уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөв, орон нутгийн төсөв болон хандив, тусламж зэрэг бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөж байжээ. Гэхдээ энэ хөрөнгийг улсын төсөвт тусгуулхад бэрх, орон нутгийн төсөвт хуваарилагддаг жаахан мөнгө нь хаа хаанаа хүрэлцдэггүйгээс төлөвлөгөөгөө алдаг оног биелүүлсээр ирсэн байна.

Харин Орон нутгийн хөгжлийн сан бий болсноор уг хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж нээгдсэн гэж сумын удирдлагууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд олзуурхах аж. Тиймээс ч уг сангийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зарцуулахын тулд хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах шаардлага гарч иржээ. Ингэснээр сумын хөгжлийн төлөвлөгөө ч хэрэгжиж, орон нутгийн хөгжлийн сангийн зорилго ч биелэх юм.

ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАХ, ТУХАЙ БҮРТ НЬ САЙЖРУУЛАХ АРГЫН ЭРЭЛД

Сайнцагаан суманд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бүтээн байгуулалтын олон ажлууд хийгдэж эхэлсэн ч цаашид анхаарч, шийдэх шаардлагатай асуудлууд урган гарах болсон байна.

Иргэдээс санал авах, авсан саналыг эрэмбэлэх, эрэмбэлсэн ажлыг зарлах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хүлээн авах зэрэг ажлууд нь журмын дагуу явагдаад байгаа боловч хүссэн үр дүн харагдахгүй байх нь иргэдийг бухимдуулах болсон байна. Үүний нэг шалтгаан нь захиалагч, гүйцэтгэгч хоёр гэрээ байгуулахдаа гүйцэтгэх ажлынхаа тодорхойлолт, шаардлагаа сайтар боловсруулаагүй байгаагаас үүдэлтэй аж. Үүний уршигаар төлөвлөсөн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, цаасан дээрх сайхан зүйл амьдрал дээр хог болж хувирах, иргэдийн сумын удирдлагуудад хандах хандлага, итгэл сулрах явдал гарах болжээ.

Хэр өндөртэй, ямар материалаар хийгдсэн шонг хэдэн метрийн зайтай байрлуулж, ямаршуу тороор торлохыг нарийн заалгүйгээр зөвхөн “Тор, хашаа” гэж бүрхэг тодорхойлж гэрээ байгуулснаас үүдээд тор ч гэхэд хэцүү, шон ч гэхэд хэцүү зүйлийг хүлээж авахаас өөр аргагүй байдалд хүрч байсан тухайгаа үнэлгээний хороонд ажилласан албан хаагч ярьж байна.

Тиймээс анх гэрээ байгуулахдаа л бүх шаардлагыг дэлгэрэнгүй бичих, техник эдийн засгийн үндэслэлийг нь сайтар боловсруулахгүй бол гүйцэтгэл тааруу болоод байгаа нь харагджээ. Батлагдсан төсөвтөө тааруулах, техник эдийн засгийн үндэслэлийг алдаатай боловсруулах, бараа материалын чанарын шалгуурыг нэг бүрчлэн тусгаагүй байх нь ажлын явц болон гүйцэтгэлд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг байна.

Нэг талаас энэ нь үнэлгээний хорооны ажлын чанар, үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг, чадвараас ихээхэн хамаатай боловч нөгөө талаасбатлагдсан зураг төсөвт ч их учир бий. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллагсад мэргэжлийн мэдлэг дутуу, зураг төсвийн үнэн зөв, баталгаатай байдалд тэр бүр хяналт тавьж чаддаггүйгээс зураг төсөвт юу гэнэ түүний дагуу л шийдвэр гаргах нь олонтаа ажээ. Зөвхөн Орон нутгийн хөгжлийн сангаар зогсохгүй бусад сангуудын хөрөнгийг зарцуулах гол шийдвэр гаргадаг зөвлөл, ажлын хэсэг, хорооны гишүүд төсөл сонгон шалгаруулах, иргэдийн саналыг үнэлэн шалгаруулах тухай мэдлэг, чадвар сул, хэт олон төсөл богино хугацаанд шалгаруулах шаардлага гардаг зэрэг сул талууд бий.

Сум суманд төдийгүй баг бүрт хийгдэж буй ажлууд өөр өөр зураг төсөвтэйгээр хийгдэж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, иргэдийн итгэл алдагдахад хүргэдэг байна. Иймээс төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил, үйлчилгээг нэг стандарт, жишигт оруулах санал, санаачилгыг иргэний нийгмийн байгууллагууд гаргаж, сумын удирдлага ч дэмжих бодлого баримталж байна.

Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн явцад захиалагчийн хувьд сумын Засаг даргын тамгын газар, төсөв зөв зарцуулагдсан эсэхэд Иргэдийн төлөөлөгчдийн хурал хяналт тавьдаг тогтсон жишиг бий. Гэхдээ албан болон албан бусаар иргэдийн хяналтыг дэмждэг

тогтолцоо бүрэлдэж, процедурын шинжтэй зарим нэг шинэлэг алхамууд хийж эхэлжээ. Тухайлбал, сумын зарим баг тухайн жилд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг идэвхитэй иргэддээ өгч, уг жагсаалтын дагуу иргэд ажлын явцад хяналт тавих, хэрэв ажил муу хийгдэж байна гэж үзвэл багийн засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мэдээлдэг байна.

Мөн 2014 оноос эхлэн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга, байгууламж, тохижилтын бусад ажлуудыг хүлээн авахдаа багийн иргэдээс бүрдсэн иргэний зөвлөлд багийн дарга болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг танилцуулан, актаархүлээлцдэг туршлага бий болжээ.

Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг (үүнд машин техник, малчдад олгосон радио, өндөр үржил шимт мал ч мөн орно) орон нутгийн өмчид бүртгэж авч байгаа ч эдгээр хөрөнгийн урсгал зардлыг хэрхэх тухай бүрэн шийдэлд хүрээгүй л байна.

Машин техникийн зардлыг сумын засаг даргын тамгын газрын, бие засах газар, гудамжны гэрэлтүүлгийн урсгал зардлыг Мандалговь хотын захирагчийн албаны урсгал зардалд шингээгээд явж байгаа бол ногоон байгууламж, мод, зүлгийг тордох, арчлах ажлыг нийтийг хамарсан ажлын хүрээнд хүн авч зуны цагт ажиллуулах, гаднаа хашаагүй өвсний агуулахын сахиул, манааны ажлыг дотоод нөөц бололцоогоороо шийдээд явах зэргээр аргацаах төдий байгаа ажээ. Бүтээн байгуулалтын ажил хийгээд байгаа боловчэдгээрт шаардлагатай шатахуун, хамгаалалт, халаалт, цахилгаан, элэгдэл хорогдол зэрэг урсгал зардлыг хэн гаргах гаргах вэ гэдэг нь одоо болтол тодорхойгүй байсаар байна.

Учирч буй бэрхшээл, тулгарч буй сорилт олон байгаа боловч сумын иргэд даваад гарах хүсэлтэй байна. Хэдэн жилийн өмнө иргэд жилд мянга мянгаараа шилжин явдаг байсан бол одоо буцаж суурьших хандлагатай байгаа нь орон нутагт амьдрах, хөгжих боломж илүү байгааг олж харсных биз ээ. Сүүлийн жилүүдэд хийгдсэн зам гэрэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг иргэд иргэд сайшаан хүлээн авч байгаа боловч хөгжил гэдгийг тэд өөр нүдээр харж байна. Тэд үйлдвэрлэл хөгжих, түүнийг дагаад ажлын байр нэмэгдэх, эдийн засаг, бизнесийн

таатай орчин бүрдэх, амьдралын чанар дээшлэхийг хөгжил гэж үзэж байна. Дундговь аймаг, тэр дундаа Сайнцагаан сумын ирээдүйг иргэд нь сайхнаар төсөөлж уул уурхай, байгалийн баялагт түшиглэсэн Өмнөговь, улсын нийслэл Улаанбаатарыг холбосон хөгжлийн гүүр болохыг эрмэлзэж байна.

*Энэхүү бүтээлтэй холбоотойгоор
бидэнтэй холбоо барихыг хүсвэл:*

МЕРСИ КОР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө-31
Баянзүрх дүүрэг, шуудангийн хайрцаг 49-761
Улаанбаатар 13381
Утас: (976-11) 461145
(976-11) 461048
Цахим хаяг: contactus@mn.mercycorps.org

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

Хаяг: Партизаны гудамж-31
Сүхбаатар дүүрэг, шуудангийн хайрцаг 49-761
Улаанбаатар 14250
Утас: (976-51) 266153
(976-51) 266173
Цахим хаяг: www.ndi.gov.mn , info@ndi.gov.mn

